



Ш.БАТТӨР
Д.БААСАНЖАРГАЛ

ЯЛАЛТ РУУ ТЭМҮҮЛСЭН ОН ЖИЛҮҮД


2008-2012



МАН-ЫН ДАРГА, ЕРӨНХИЙ САЙД
2008-2010 ОН



МАН-ЫН ДАРГА, ЕРӨНХИЙ САЙД
2010-2012 ОН



Ш.БАТТӨР
Д.БААСАНЖАРГАЛ

ЯЛАЛТ РУУ ТЭМҮҮЛСЭН
ОН ЖИЛҮҮД
(2008-2012)



УЛААНБААТАР 2018 ОН



ХӨГЖИЛ
АРДЧИЛАЛ
ТББ



KONRAD
ADENAUER
STIFTUNG

Ялалт руу тэмүүлсэн он жилүүд (2008–2012)

Зохиогч: Ш.Баттөр (Хэлбичгийн ухааны доктор /Ph/, дэд профессор)

Д.Баасанжаргал

Редактор: Б.Цээпил

Н.Галбаатар

Хэвлэлийн эх бэлтгэсэн: Д.Энхнаран

Хэвлэлийн хэмжээ: 148x210

Хэвлэлийн хуудас: 8.0 хх

“Мөнхийн Үсэг” ХХК-д эхийг бэлтгэж хэвлэв.

ISBN:

АГУУЛГА

ӨМНӨТГӨЛ	9
2008 ОНЫ УИХ-ЫН СОНГУУЛЬ	10
Сонгуулийг будлиантуулав	11
Луйврын баримт	11
Баримт дэлгэгдсээр	14
7-р сарын 1	15
Тэмцэл хурцдав	16
ОНЦГОЙ БАЙДАЛ ЗАРЛАВ	19
Таван хүн амиа алджээ	21
Цагдаагийн удирдлагуудаар туг тахив	23
АН-ын дарга Ц.Элбэгдорж:	
Амандаа ус балгасан мэт дуугүй суух уу!	23
ХААЛТТАЙ ХУРАЛДСАН ОНЦГОЙ ЧУУЛГАН	25
БАЙР СУУРЬ: АРДЧИЛСАН НАМ	
УИХ-ЫН ЧУУЛГАНД ОРОЛЦОХГҮЙ	25
УИХ-ЫН СОНГУУЛИЙН ДҮНГ МАН ӨӨРТ	
АШИГТАЙГААР ӨРГӨН БАРИВ	27
МУХАРДАЛД ОРСОН Ц.ЭЛБЭГДОРЖ	
НАМЫН ДАРГЫН АЖЛАА ӨГНӨ	28
ДОЛООН УДАА ЗАРЛАГДСАН АНХДУГААР ЧУУЛГАН	29
АН-ын ажлын хэсгийнхэн:	
Халуун байна, зангиагаа тайлчих уу	29
Намаасаа зөрсөн Э.Бат-Үүл УИХ-д орж суув	30
Намууд зөвшилцөв	31
67 гишүүн тангараг өргөв	32

АРДЧИЛСАН НАМЫН ШИНЭ ДАРГААР Н.АЛТАНХУЯГ СОНГОГДОВ	33
“Ядаж нөгөөдөр...”	33
Ардчилсан намын шинэ дарга сонгогдов	33
МУХАРДАЛ ДУНДАХ ГАНЦ ГАРЦ: ХАМТАРСАН ЗАСАГ	35
Шинэ даргын эхний өдөр	35
Хамтарсан Засгийн газар байгуулах ажлын хэсэг байгуулагдав	35
Хагарах амар, хамтрах хэцүү	36
Хамтран ажиллах гэрээ байгуулагдав	38
Хамтарсан Засгийн газар байгуулагдав	39
Хамтарсан Засгийн газрын гишүүд	41
ИХ АЖЛЫН ЭХЭН	42
ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ БОЛОВ	44
25 ДУГААР ТОЙРГИЙН МАРГААН	47
Л.ГҮНДАЛАЙГ ШОГЛОХЫГ ОРОЛДОВ	50
“ШУДАРГА СОНГУУЛЬ”-ИЙН ТӨЛӨӨХ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ	51
2009 ОНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ	52
АН-аас Ерөнхийлөгчийн сонгуульд Ц.Элбэгдорж нэр дэвших боллоо	53
АН-ын 4-р их хурал	55
Ерөнхийлөгчийн сонгуулийн төв штабыг Н.Алтанхуяг удирдана	57
Баабар: Элбэгдоржид найдаж байна. Миний сүүлчийн горьдлого	58
2009.05.25: “АРДЧИЛСАН ЕРӨНХИЙЛӨГЧТЭЙ ӨГЛӨӨНИЙ МЭНД”	60
ОЮУТОЛГОЙН ГЭРЭЭ	61
Асуудал дагуулсан - 68%	63
Гэрээг үзэглэв	64

ЭЛБЭГДОРЖИЙН ТОЙРОГТ УИХ-ЫН НӨХӨН СОНГУУЛЬ БОЛОВ	66
УИХ-ын нөхөн сонгуулийн дүн	67
С.БАЯР АЖЛААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ ХҮСЭЛТ ГАРГАВ БУЮУ ӨГӨВ, АВАВ	68
Огцрох асуудлаас өөр	68
Өгөв, авав	69
Бүтэц, бүрэлдэхүүнээ хадгалж үлдэхээр тогтлоо	70
Н.Алтанхуяг: Аль болохоор зовлон тоочихгүйг хичээж байгаа	71
20 ЖИЛИЙН ОЙГООРОО“АРДЧИЛСАН ХУВЬСГАЛ” БОЛОВ НАМЫН ДОТОР “ХОЛБОО” БАЙГУУЛАГДАВ	71
Э.Бат-Үүл: Ардчилсан хүчний холбоо чинь МАХН-ын захиалгаар явж байгаа урвагч нар юм шүү	74
АН-ЫН ҮЗХ-НЫ РОТАЦИ БОЛЛОО	75
АН-ЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ҮҮРЭГ	76
НАМАА СӨРСӨН АРДЧИЛСАН ХҮЧНИЙ ХОЛБООНЫ ЧУУЛГАН	77
НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМЫН ДАРГА С.ЭРДЭНИЙГ ЧӨЛӨӨЛӨВ	79
ҮЗХ-ААР “МОНГОЛ ХҮН 2020” ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛАХ ШИЙДВЭР ГАРГАВ	79
Намын Ээлжит бус Их хурал хуралдуулахыг гишүүд дэмжсэнгүй	80
ХАМТАРСНЫ ҮР АШИГ	82
Хамтарсан Засгийн газрын ололт	82
Төмөр замын тухай асуудал	86
МАХН “МАН” БОЛОВ	87

ЭБЭХ-ний САЙД ЗОРИГТЫГ ОГЦРУУЛАХ САНАЛ ДЭМЖИГДСЭНГҮЙ	88
ТАВАН ТОЛГОЙН ОРДЫГ АШИГЛАХ ЭХНИЙ ШИЙДЭЛД ХҮРЛЭЭ	89
АРДЧИЛСАН ХУВЬСГАЛЫН 20 ЖИЛИЙН ОЙН ХААЛТЫН ХУРАЛ	90
ХӨГЖЛИЙН БОДЛОГО: “МОНГОЛ ХҮН-2020”	94
Эхлэл тавигдсан нь	94
Хөгжлийн бодлого	95
АРДЧИЛСАН НАМЫН АНХНЫ ВИДЕО ХУРАЛДААН	96
ЭДИЙН ЗАСГИЙН ХУВЬСГАЛ	97
Анхны лекц	98
“Монгол хүн-2020” хэлэлцүүлгийн хаалтын ажиллагаа болов	99
АРДЧИЛСАН НАМ ДЭЛХИЙН АРДЧИЛСАН ХОЛБООНЫ БҮРЭН ЭРХТ ГИШҮҮН БОЛОВ	100
РОТАЦИ ӨНЖИХ ҮЗХ-НЫ ШИЙДВЭР	101
М.ОЛБРАЙТ: АРДЧИЛСАН НАМТАЙ ХАМТАРЧ АЖИЛЛАНА	103
МАН ДОНДОГ ГИШҮҮНЭЭ ХАМГААЛЖ ҮЛДЭВ	104
УИХ-ЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА	105
Тоглоомын дүрмийг тогтоох хувилбарууд	106
Бүх нийтийн санал асуулга явуулах боломжгүй	107
Хэлэлцээр үргэлжилсээр	108
Сонгуулийн хууль батлагдав	109
Цэцийн шийдвэрийг хүлээж авна, авахгүй	110
ХАМТАРСАН ЗАСГААС ГАРАХ ДОХИО	111
УИХ-ын 57-р тогтоолыг буруушаах нь	111
Ерөнхий сайд Сү.Батболдыг огцруулах бичгийг өгөв	113

СОНГУУЛИЙН ЖИЛ: АРДЧИЛСАН НАМ ЗАСГИЙН ГАЗРААС ГАРАВ	114
Зарим гоморхол	115
Ширүүн болсон ҮЗХ-ны 35 дугаар хуралдаан	116
Засгийн газраас гарах шийдвэрийг дэмжив	118
МОНГОЛ УЛСЫГ 2020 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР: “МОНГОЛ ХҮН-2020”	119
“ШОНХОР” ФРАКЦ МЭНДЛЭВ	120
АРДЧИЛСАН НАМЫН ДАРГА Н.АЛТАНХУЯГ: СОНГУУЛЬ БУДЛИАНТУУЛАХГҮЙ БАЙХЫГ АНХААРУУЛАВ	122
МӨНГӨНИЙ АМЛАЛТААР ӨРСӨЛДӨХГҮЙ БАЙХ САНАМЖ БИЧИГ	123
УИХ-ЫН СОНГУУЛИЙГ НИТХ-ЫН СОНГУУЛЬТАЙ ХАМТ ЯВУУЛАХ БОЛЛОО	123
УИХ-ЫН СОНГУУЛЬ—2012	125
Сонгуулийн будлианы эсрэг тэмцэл: Н.Алтанхуяг vs Ц.Нямдорж	125
Мөрийн хөтөлбөрөө нууцлав	127
Ардчилсан намын Сонгуулийн хороо байгуулагдав	128
Намууд батламж гардав	128
УИХ-ын сонгуульд АН-аас нэр дэвшигчид тодров	129
Ардчилсан нам 76 нэр дэвшигчээ танилцууллаа	131
Ардчилсан нам Алтай Таван Богдоос сурталчилгаагаа эхлүүлэв	132
ТӨГСГӨЛИЙН ОРОНД	134
ҮГИЙН ТОВЧЛОЛ	135

ӨМНӨТГӨЛ

Хүн төрөлхтний түүх зогсолтгүй урагшилж, ард түмний түүх мандан буурах үе шатыг дамждаг нь жам ёс. Басхүү өнгөрсөн түүхээ шүүн хэлэлцэх, задлан шинжлэх, нэгтгэн дүгнэх, сургамж авах нь ч соёлт хүн төрөлхтний жам ёс билээ. Энэ ч үүднээс сонгуулийн нэгэн бүрэн эрхийн хугацаагаар тухайн үеийн түүхийг нээн гаргасан, Ш.Одонтоерийн гурван цуврал болох “Ардчилалын алдаа оноотой жилүүд. 1996-2000” (УБ.,2010), “Ардчилалаа хамгаалсан он жилүүд. 2000-2004 он” (УБ.,2011), “Хамтарч, хагарсан он жилүүд. 2004-2008” (УБ.,2016) номын шууд үргэлжлэл болгон “Ялалтруу тэмүүлсэн он жилүүд. 2008-2012” гэсэн гарчигтай нэгэн номыг хэвлэн нийтлүүлж байна.

Ардчилсан намын туулсан замыг дөрөв, дөрвөн жилийн үечлэлээр нь бичиж үлдээсэн Ш.Одонтоерийн ажлыг үргэлжлүүлэх санал аваад хамгийн түрүүнд бид барах болов уу, яах бол гэж эргэлзэж байсан ч Ардчилсан намыг бас нэгэн өвөрмөц “хүн” гэж үзээд, түүний түүхийн нэгэн зурвас дахь намтрыг журмын нөхдийн нь тусламжтайгаар бичиглэж үлдээх нь бас хэн хүнд олдохооргүй аз завшаан гэж олзуурхсан юм.

Аливаа судалгаанд сэтгэлийн хөөрөл, намын буюу бүлгийн, хувийн үзэл хандлагад авталгүйгээр баримт түшин сурвалжлах, баримтыг тоймлох, задлан шинжлэх, нэгтгэх, дүгнэх нэн чухал байдаг. Энэ зарчмыг баримтлахыг хичээсэн болно. Нэгэн номыг хэмээсний учир нь цаашид энэхүү цуврал номыг үргэлжлүүлэн гаргахыг бодсонд, төлөвлөсөнд орших билээ.

Зохиогчид



2008 ОНЫ УИХ-ЫН ЭЭЛЖИТ СОНГУУЛЬ



2008 оны 6-р сарын 29. Нийт 356 нэр дэвшигч өрсөлдсөн, УИХ-ын тав дахь удаагийн сонгууль Монгол Улс даяар боллоо.

Санал хураалт өглөө 07 цагт улс даяар эхэлсэн ба "УИХ-ын сонгуулийн

санал хураалтыг 22 цагт хаасны дараа бүх хэсгийн хороодын бүртгэлийн дүнг Сонгуулийн ерөнхий хорооноос 00 цаг өнгөрч байхад урьдчилсан байдлаар танилцууллаа...Улсын хэмжээнд иргэд сонгуульд 74,3 хувьтай хамрагдлаа"¹.

Ардчилсан нам УИХ-ын ээлжит сонгуульд эртнээс бэлдэж эхэлсэн ба 2008 он дөнгөж гаруут "Зөв бодлого, зөв сонголт" гэсэн сонгуулийн уриагаа зарлажээ. Мөн 2007 оны дунд үеэс эхлэн МУ-ын 620 мянган өрхөөр дамжуулан улс даяар мөрийн хөтөлбөрөө хэлэлцүүлсэн байна.

Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Дорлигжав "Дангаараа сонгуульд орох нь намын цаашлаад төрийн төлөвшилд чухал юм. Зөвхөн сонгуульд ялахын тулд хэврэг эвсэл байгуулдаг. Дараа нь бутардаг. Түүнээс болоод бүх зүйл замардаг байж болохгүй гэж үзсэн. Олон түмэн итгэвэл, тэр итгэлийг АН дангаараа аваад явдаг, үгүй бол сөрөг хүчин болоод явах нь цаашдаа төрийн эрх ашигт нийцэж байгаа учраас АН энэ байр суурин дээрээ хатуу зогсч байгаа юм"² гэсэн нь өмнөх алдаанаасаа сургамж авсан, аливаа нам хариуцлагатай байхыг сургамжилсан байр суурь байв. Ингэснээр 2007 оны 5-р сарын 17-ны бямба гарагт АН-ын Үндэсний зөвлөлдөх хороо хуралдаж УИХ-ын ээлжит сонгуульд ямар нэгэн улс төрийн хүчинтэй эвсэл байгуулахгүйгээр оролцох шийдвэрийг гаргажээ.

¹ ӨС.№156 (2008.06.30)

² Дорлигжав,Д.: Гар нийлж ардчиллын төлөө зорьсон үйлээ бүтээх цаг болсон (ярилцсан Г.Эрдэнэбат),-ӨС.№035 (2008.02.13)

Сонгуулийг будлиантуулав

УИХ-ын сонгуулийн сурталчилгаа ил бас далд хэлбэрээр хуулийн хугацаанаас өмнө эхэлсэн бөгөөд энэ тухай дөрөвдүгээр сард Сонгуулийн ерөнхий хороо мэдэгдэл гаргасан байдаг. “УИХ-ын сонгуулийг товлон зарлаагүй байхад сонгуульд нэр дэвшихээр горилж буй зарим хүмүүс, албан тушаалтны зүгээс сонгогчдод цаг тооны бичиг, архи, хадаг зэрэг эд зүйлс, мөнгө тараах, иргэдийн хувийн нууцад халдан төрсөн өдрийг нь тохиолдуулан оршин суугаа хаягаар нь бэлэг дурсгалын зүйлс хүргүүлэх, сурталчилгааны самбар ашиглах, сонгуульд зориулан хандивын данс нээж хандив цуглуулах, хандивын хүлээн авалт зохион байгуулах зэрэг хууль бус үйл ажиллагаа явуулах нь даамжирч байна... Сонгогчдын саналыг эртнээс худалдан авахад чиглэсэн аливаа зохисгүй үйл ажиллагаа явуулж буй улс төрийн нам, нэр дэвшигчдийг Сонгуулийн ерөнхий хороо албан ёсоор бүртгэх үедээ дээрх зөрчлийн талаархи мэдээллийг баримтжуулан авч хариуцлага тооцох болно гэдгээ албан ёсоор мэдэгдэж байна”³ гэж тэмдэглэжээ. Нэг талаасаа хууль бус үйлдэл гарч байгааг буруушаасан мэт боловч хууль бус үйлдэл хийсэн зарим хүн, албан тушаалтан, намыг мэдсэн ч эс мэдсэн, тодорхойгүй, шийдвэргүй мэдэгдэл гаргасан нь СЕХ-ны зүгээс нүглийн нүдийг гурилаар хуурахын үлгэр болсон бол хууль зөрчигчдийн зүгээс жин явж л байна, жингэр хуцаж л байхын яруу тод жишээ болон үлджээ. Ийм хууль бус үйлдэл цааш даамжирсаар сонгууль, сонгуулийн санал тооллогын үеэр оргилдоо хүрсэн юм.

Луйврын баримт

Тооллого явуулахдаа саналын хуудсыг хулгайлсан, сольсон, луйвардсан, иргэдэд мөнгө тараасан, санал худалдаж авсан гэх зэрэг олон маргаан дэгдсэн, мөн сонгуулийн эцсийн дүн албан ёсоор эцэслээгүй, санал тоолж эхлээд удаагүй байхад (03.00 цагт) МАХН ялалтаа зарласан байна. Харин олон нийт УИХ-ын ээлжит сонгуулийг будлиантай, маргаантай, луйвартай болж өнгөрөв гэж үзэж байлаа. Баримт нотолгоо ч олноор гарч ирэв.

³ ӨС.№086 (2008.04.09)



Зөвхөн жишээ болгоход:

“Чингэлтэй дүүргийн УИХ-ын сонгуулийн 24 дүгээр тойрог нийт 22 хэсгийн хороотой. Гуравдугаар хэсгийн сонгогчдын санал ямар ч битүүмжлэлгүй. Түүнийг нь МАХН-ын гишүүн бүсгүй нарийн бичгийн даргын хамтаар хүргэж ирсэн байна... Сонгууль өгөх өдөр иргэний үнэмлэхийг 100, 100 ширхгээр нь бөөндчихсөн тарааж явсныг АН-ын гишүүд илрүүлсэн”⁴,

“Баянзүрх дүүрэг буюу УИХ-ын 22 дугаар тойрогт сонгуулийн санал тоолох ажиллагаа будлиантай болсон тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр гарсаар байна. Жишээ нь санал тоолох явцад сонгуулийн хорооны ажилчид Батзандан гэхийг Батбаяр, Ганхуяг гэхийг Ганди гэж дуудаж байсныг ажиглагч нар илрүүлжээ... хэсгийн хороодоос саналын хуудсыг битүүмжлээгүй, ил задгай цаасан хайрцганд хийсээр орж ирэхтэй таарсан байна. Хараа хяналтгүй, лац ломбогүй ил задгай саналын хуудас авч яваагаа хэсгийн хорооныхон машинд багтахгүй учраас ингэж хэсэг хэсгээр болгосон гэж тайлбарлав”⁵,

“Сонгинохайрхан дүүрэг буюу УИХ-ын 26 дугаар тойргийн 14 дүгээр хэсгийн хорооны ажилтан н.Дондогмаа гэх эмэгтэй санал тооллогыг будлиантуулжээ. Тэрбээр, илтэд Ардчилсан намын

⁴ Долзодмаа.Б. МАХН-ын гишүүн хэсгийн хороон дарга сонгогчдын саналыг ил задгай авчирчээ, -ӨС.№157 (2008.07.01)

⁵ Цог.Д. Батзандан.Ж саналын хуудас ураагүй гэв, -ӨС.№157 (2008.07.01)

болон бусад нам эвслийн нэр дэвшигчдийн нэрийг дарж, МАХН-ын хүмүүсийн саналын тоонд нэмэрлэсэн байна. н.Дондогмаа ч үнэхээр нэрсийг албаар зөрүүлэн дуудсанаа хүлээсэн байна”⁶,

“Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын сонгуулийн дөрөвдүгээр хэсгийн хороонд зургадугаар сарын 23-нд Баянгол дүүргээс хаягийн шилжүүлэг хийлгэсэн бичиг баримттай хэсэг хүн санал өгөхийг завдсан байна. Тэд тус сумын төвөөс 2-3 км-ийн зайд автобустайгаа буудалласан аж. Тэднийг 4-5 жижиг машинаар хэсгийн хорооруу ээлжлэн зөөж санал өгүүлэхийг завдсан”⁷,

“Мөнгө тараасан нь видео бичлэгээр тогтоогдсон Д.Арвин, Ц.Цэнгэл, Ш.Сайхансамбуу, Б.Чойжилсүрэн нарын нэр дэвших эрхийг ч СЕХ Сонгуулийн тухай хуулийн дагуу хасах ёстой байжээ”⁸,

УИХ-ын сонгуулийн 23 дугаар тойрог, Сүхбаатар дүүрэгт бие даан нэр дэвшсэн Б.Лхагважав “Өчигдөр би Сүхбаатар дүүргийн иргэний бүртгэлийн мэдээллийг тулгаж үзлээ. Энэ дүүрэгт 48 мянган иргэн хамрагдаж байгаа. Энэ тоон дээр нэмээд 12 мянган иргэн сүүлийн долоо хоногт шилжиж ирсэн байна. Ялангуяа сүүлийн хоёр хоногт 4200 хүн ирсэн. Нэг хэсэг дээр 10-20 хувийн нүүдэлчин сонгогчтой болчихсон гэсэн үг. Уг нь бол шилжилт хөдөлгөөнийг хориглосон улаан шугамыг долоо хоногийн өмнө тасалсан”⁹ гэх мэт, гэх мэт...

Иргэний эвслийнхэн сонгуулийн маргааш буюу 6-р сарын 30-ны 14 цагт хэвлэлийн бага хурал зарласан ба нэр дэвшигч Д.Энхбат: “АН, МАХН-аас хэсгийн хорооны бүрэлдэхүүнд багтсан гишүүд саналын хуудас дээрх нэрсийг ээлжилж дуудаж байгаа. Ингэхдээ АН дуудаж байгаа хугацаанд тухайн тойрог дахь тус намын хүн дийлэнх санал авч байна. Сөргүүлээд МАХН-ын төлөөлөл болох хэсгийн хорооны гишүүн бас саналын хуудас дахь нэрийг дуудахдаа өөрийн намын хүндээ зохиомол оноо нэмэх замаар тооллого явагдаж байна”¹⁰ гэсэн нь ардчилсан хүчний төлөө

⁶ Хэрлэн.Х. Иргэний хөдөлгөөний нам улс төрийн суулт зарлалаа, -ӨС.№157 (2008.07.01)

⁷ Ө.№150 (2008.06.30)

⁸ Туул.С. Засгийн газрын огцруулах тухай хуулийн төслийг Ардчилсан намын гишүүд өргөн барилаа, -Ө.№157 (2008.07.08)

⁹ Лхагважав.Б: С.Баяр дарга аа, таны сонгогчдын 25 хувь нь хуурамч байхад шударга сонгууль боллоо гэж үзэх үү (ярилцсан Х.Хэрлэн), -ӨС.№158 (2008.07.02)

¹⁰ ӨС.№157 (2008.07.01)

өгсөн санал хаачсан болохыг асуусан олон түмний уур хилэнг улам дүрэлзүүлсэн, сонгуулийн тооллого, үр дүнг хууль бус хэмээсэн, цаашлан улс төрийн зарим хүчин төрийн эрхийг хууль бусаар авахыг санаархсан ч гэж үзэж болох нэг талаасаа ноцтой, нөгөө талаасаа турхирсан мэдэгдэл байлаа.

Баримт дэлгэгдсээр

АН-ын Гүйцэтгэх зөвлөл мөн сарын 4-ний өдөр өргөтгөсөн байдлаар хуралдан будлиантай нь тогтоогдож нотлох баримт цугларсан зарим тойрогт дахин санал хураалт явуулах нь зүйтэй гэсэн дүгнэлтэнд хүрчээ. Олон нийт ч, улс төрийн намууд ч УИХ-ын ээлжит сонгууль хууль бус болсон гэж үзэж байсан бөгөөд өөрийн хэлсэн үг, бичсэн цэг таслалдаа ч хариуцлага хүлээнэ гэж бардам мэдэгддэг нийтлэлч Б.Батбаяр “Төрийн байгууллага өөрөө зохион байгуулж луйвар хийдэг тогтолцоо хувь хүнээс үл хамаарсан машин болон хувирчээ”¹¹ гэсэн. УИХ-ын гишүүн З.Энхболд “ИБМУТ энэ луйварт оролцжээ. Мөн СЕХ-ны дарга Б.Баттулгын оролцоо бий. УИХ-ын сонгуулийн 23 дугаар тойрог Сүхбаатар дүүрэгт сонгогчдын тоо анх 71125 гэж гарсан. Шилжилт хөдөлгөөн, нас барсан хүмүүс гэж хасагдсаар 54872 болсон. Гэтэл сонгууль болохын сүүлийн хэдхэн хоногийн дотор энэ тоон дээр 11928-аар нэмэгдчихсэн. Чингэлтэй дүүргийн сонгогчдын тоо 62655 байсан бол 74483 болж өссөн... Сонгуулийн дүнг шударгаар гаргая гэвэл иргэний үнэмлэх тараадаг албан тушаалтнуудыг цагдан хорих шаардлагатай. СЕХ-ны дарга Б.Баттулга огцрох ёстой. Гадаадад яваа 68000 хүний овог нэр хаягийг МАХН-д худалдсан ХХЕГ-ын дарга Баатарцогт нарыг огцруулж байж үнэнийг тогтоож чадна. Энэ бол төрийн эсрэг гэмт хэрэг мөн”¹² гэж мэдэгдсэн байдаг.

¹¹ Мөнхбаясгалан.Л. Иргэдийн бухимдал эцэстээ тулж дэлбэрчээ.-ӨС.№163 (2008.07.08)

¹² Долгодмаа.Б. Ардчилсан нам сонгуулийн луйврыг баримттайгаар дэлгэв,-ӨС.№163 (2008.07.08)

7-р сарын 1



Сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн анхны жагсаал 6-р сарын 30-ны 22 цагийн орчим эхэлсэн ба Улаанбаатар хотын төв цэгт, замын хөдөлгөөн хаан жагсчээ. Энэ жагсаал нь их жагсаал, эсэргүүцэл, үймээний эхлэл байсан нь үнэн ч нөгөө талаараа их үймээний бэлтгэл, тандалт байсан байж болох талтайг үгүйсгэх аргагүй юм. Мөн орой АН-ын байрны үүдэнд олон хүн цуглаж, байдал хурцтах, эсвэл хэргээр хурцатгах шинж ажиглагдаж эхэлжээ.

Үйл явдал нэн хурдацтай өрнөлөө. Ардчилсан намын дарга Ц.Элбэгдорж 12 цагийн үед мэдээлэл хийв. Тэрбээр “Ардчиллыг гэсэн ард түмнийхээ саналыг хүндэтгэж бахархаж байна. Ард түмний сонголтод хууль бус өөрчлөлт, зохиомол мэс засал хийсэн, жам ёсны ялагдлаасаа айсан эрх баригчдыг хараад ой гутаж байна... Монголын найман хүн тутмын зургаа нь, 10 хүн тутмын долоо нь, монголчууд гэр бүлээрээ, ах дүүсээрээ ардчиллыг дугуйллаа. МАХН харин 10 тутмын долоон хүний саналыг өөрчлөн луйвардаж чадлаа”¹³ хэмээн хатуугаар мэдэгдсэн байна.

Иргэний хөдөлгөөнийхөн будлиантай явагдсан сонгуулийн эсрэг жагсаал зохион байгуулна гэсэн зарыг 6-р сарын 30-нд

¹³ Элбэгдорж.Ц: Ардчиллыг сонгосон ард түмэндээ баярлалаа (Х.Хаш), - ӨС.№158 (2008.07.02)

тараасан ба О.Магнай, Б.Жаргалсайхан нар оройлон тэргүүлж 13.30 цагаас Драгон төвөөс Сүхбаатарын талбай чиглэн жагсчээ. 15 цагийн орчим О.Магнай тэргүүтэй жагсагчид шаардах бичиг өгөхөөр МАХН-ын Төв байрны гадаа ирэн хамгаалалтын албаныхантай зөрчилдсөн байна. Энэ үед Сүхбаатарын талбай дээр иргэд мөн цугласан байсан бөгөөд АН-ын дарга Ц.Элбэгдорж жагсаалд оролцож буй иргэдэд хандан, МАХН-ын Төв байрны өмнө жагсч буй иргэдийг ирж нэгдэхийг уриалан үг хэлжээ. Тэрбээр хэлэхдээ “Монголчууд ардчиллыг сонгосон. Энд зогсч буй хүмүүс та бүхэн хэнд, хаана саналаа өгсөн бэ гэж бие биенээсээ асуугаарай.

Бүгдээрээ ардчиллыг сонгосон, ардчилалд өгсөн гэж хэлнэ. Монголын ард түмний хийсэн энэ ариун сонголт, ард түмний энэ дээд шийдвэр яагаад ийм амархан будилав аа... Ард түмнээсээ хулгай хийгээгүй юм бол эрх баригчид ард түмнээсээ юунд нь айдаг юм бэ, эрх баригчид яагаад гарч ирж чадахгүй байгаа юм... Сонгуулийн тойргийн хамгийн маргаантай байгаа хэсгүүд дээр дахин санал тооллого явуулъя. Мөн Монголын ард түмний саналыг худалдаж авдаг хүмүүс шударга хуулийг хүндэтгэдэг байх ёстой. Саналын хуудсыг тарааж өгсөн, хэвлэсэн, мөнгө шилжүүлсэн этгээдүүдтэй хариуцлага тооц гэж МУ-ын Ерөнхий прокурор, АТГ, ЦЕГ, УМБГ-т бичиг явуулсан. МУ-ын Ерөнхийлөгчид энэ сонгуулийн дүнг өргөж барьсан. Хэрэв энэ байдал даамжирвал Ерөнхийлөгч шийдвэр гарган, дахин тооллого явуулж, улс орон даяар дахин санал хураалт явуулах ёстой. Хүмүүс ганцхан зүйлийг ойлгох хэрэгтэй. Бид өөрсдийнхөө илэрхийлэл, оролцоог хүчирхийллийн бус аргаар хийх ёстой. Бид бие биедээ, төрийг хамгаалж байгаа хүмүүст ямар нэгэн гэмтэл учруулах ёсгүй. Тайван замаар хэлэлцэж, ярилцаж шийдье”¹⁴ гэжээ.

Тэмцэл хурцдав

Гэвч сонгуулийн үр дүнг эсэргүүцсэн ард түмний уур хилэн МАХН-ын Төв байрруу чиглэсэн юм. Цаашлаад хэн нэгэн буюу аль нэгэн байгууллага, хүчин, гадаадын буюу дотоодын оролцоотойгоор санаатай буюу санамсаргүйгээр хууль ёсны төлөөх, шударга байдлыг шаардсан тэмцлийг уур хилэн,

¹⁴ ӨС.№158 (2008.07.02)

хүчирхийлэл, түрэмгийлэл болгосон билээ. Жагсаалыг цагдаа, хүчний байгууллагын хүчээр зогсоох гэсэн нь нөхцөл байдлыг улам ч хурцатгав. Харин жагсагчид түрэмгийлэлд шилжиж, эсвэл шилжүүлж, цагдаа иргэдийн хооронд мөргөлдөөн хурцтахад нөгөө олон оройлогчид, өнөө олон дагуулагчид, хууль бус сонгуулийг эсэргүүцэгчид, эх оронч дүр эсгэгчид зайлан одов, дутаан арилав.



20 цагийн үед жагсагчид МАХН-ын Төв байрны нэг давхар руу дайран орж татваргүй барааны дэлгүүрийг тонон дээрэмдэн, архидан согтуурч, галдан шатааж эхэллээ. Гал унтраах машиныг нэвтрүүлэлгүй чулуугаар нүүлгэсээр буцаав. Мөн тус байрны дэргэд байсан суудлын машиныг галдлаа. Цагдаа иргэдийн хоорондох мөргөлдөөн улам ширүүсч, цагдаа нар нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагч хэрэглэж эхлэв.

21 цагийн үед Дуурь бүжгийн эрдмийн театрын урд баригдаж байсан барилгын төмөр хийц, хашааг нураан бамбай, зэвсэг болгон галт бамбар, тоногдсон дэлгүүрийн согтууруулах ундааны лонхонд шатамхай бодис хийн нүүлгэн галдаж байв. Жагсагчдын нүүлгэж байсан тэр их чулуу, шатамхай бодисыг хэн, хэзээ, хэрхэн авчирсан нь нууц эсвэл нууцалсан хэвээр үлдсэн юм. "Өчигдөр оройн 21.00 цагийн байдлаар жагсаалд оролцсон хүмүүсээс 50 гаруй нь хүнд, хөнгөн бэртэл авч Гэмтэл

согог сэргээн засах үндэсний төвд хүргэгдээд байв. Тус төвд хүргэгдсэн хүмүүсийн ихэнх нь толгойгоо хагалуулсан, хөл, гараа хугалуулсан байлаа. Мөн жагсагчдад зодуулж ухаан алдсан цагдаа ч цөөнгүй хүргэгдэв. Бэртэгсдийн биеийн байдлын талаар тус төвийн Яаралтай тусламжийн клиникийн эрхлэгч М.Төгсбаяраас тодруулсан юм. Тэрбээр дөрвөн хүний биеийн байдал хүнд байгаа тухай онцлов. Тодруулбал, жагсаалд оролцож явсан 17 настай хүү нүдэн тус газартаа буудуулсан байдалтай иржээ. Мөн Япон улсын болон Монголын гэрэл зургийн сурвалжлагч тархины хүнд гэмтэл авсан тул эмчлүүлэхээр болжээ. Эдгээрээс гадна хамгаалалтад гарч байсан цагдаа нараас ухаан алдаж, сэхээнд орсон хүмүүс ч байлаа”¹⁵.

Дахиад нэг цаг өнгөрөхөд нөхцөл байдал улам хурцтаж, улам зэрлэг балмад болон, жагсагчид буюу үймээн дэгдээгчид бульдозер дээрэмдлээ. 23 цагийн орчим МАХН-ын Төв байрны хоёрдугаар давхар, цаашлаад гуравдугаар давхар бүхэлдээ галд шатаж эхлэв. Жагсагчид улам л зэрлэг балмад үйлдэл гаргах болж Соёлын төв өргөөрүү дайрлаа. Уран зургийн галерейг шатааж тонов. 24 цагийн орчим зургаан машин галджээ. Жагсаал хийж байгаад саатуулагдсан хүмүүсийг хүчээр суллах зорилгоор Баянзүрх дүүргийн цагдаагийн хэлтэсрүү дайрах гэсэн боловч цагдаа, сонсогчид хамгаалалтанд гарсан байв. Соёлын төв өргөөний урд хэсэгт байрлах “Өглөөний сонин”, “Хүмүүс”, “Хүмүүсийн амьдрал” сонины байрыг бүрэн галдав.

Байдал нэгэнт хяналтаас гарч эрүүл ухаанаас давлаа.

¹⁵ Бадам.Б. Жагсаалын үеэр 17 настай хүү хүнд бэртэл авчээ,-ӨС.№158 (2008.07.02)

ОНЦГОЙ БАЙДАЛ ЗАРЛАВ



Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр зарлиг гарган, Нийслэл хотод 7-р сарын 1-ний 23.30 цагаас онц байдал зарлалаа. Ингэхээс ч өөр арга байсангүй.

Үүнээс өмнө АН-ын санаачилгаар Ерөнхийлөгчид хүсэлт гаргаснаар, намуудын удирдлага Ерөнхийлөгч Н.Энхбаярт бараалхсан билээ. АН-ын дарга Ц.Элбэгдорж “Нэгдүгээрт, сонгуулийн будлиан гарсан хэсэг, тойргууд дээр дахин тооллого явуулах хэрэгтэй. Нэг тойрог, нэг хэсэг дээр л будлиан гарсан нь тогтоогдсон тохиолдолд сонгуулийг дахин зарлах хэрэгтэй. Энэ удаагийн сонгуулийг будлиантуулахад оролцсон, зохион байгуулсан, гол үүрэг гүйцэтгэсэн, санхүүжүүлсэн, зохион байгуулалттайгаар төрийн эрхийг хууль бусаар авахыг санаархсан нийт хүмүүсийг шалгах хэрэгтэй. Шөнийн гурван цагаас хойш бүх саналууд дээр луйвар орсон. 03.30-д МАХН мэдээлэл хийсэн” гэсэн бол МАХН-ын дарга, Ерөнхий сайд С.Баяр үүнийг нь үгүйсгэсэн ч дахин сонгууль явуулахад татгалзах зүйлгүйгээ илэрхийлсэн байна.

Ерөнхийлөгч байдал хяналтаас гарч байгааг удаа дараа сануулсан ч холбогдох албан тушаалтнууд үгүйсгэсээр хугацаа алдсан байдаг. Ерөнхийлөгч Н.Энхбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Мөнх-Оргилд онц байдал зарласан дөрвөн өдрийн турш мөрдөх дүрэм, журмыг даалгалаа. Онц байдал зарласан хугацаанд Улсын онц

болон хүн ам олноороо цугласан газар, объектыг хүч нэмэгдүүлэн хамгаалах, олон нийтийн цуглаан, жагсаалыг албадан тараах, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах, 22.00 цагаас 08.00 цаг хүртэл хөл хорио тогтоох, согтууруулах ундаа худалдаалахыг хориглох, цагдаагийн байгууллагын зүгээс тэсэрч, дэлбэрэх бодис авч явах магадлалтай иргэдийг шалгах, Олон нийтийн радио, телевизээс бусад телевизийн үйл ажиллагаа, мэдээллийн сайтыг түр хугацаагаар хориглолоо.

Онцгой байдал зарласнаас хойш буюу 00.00 цагаас эхлэн хүчний байгууллагын зүгээс гудамжинд байсан иргэдийг хүчээр тараан, саатуулан шалгаж, бичиг баримтгүй иргэдийг баривчлан дүүргүүдийн урьдчилан саатуулах төвд хүргэж эхлэв. Чингэлтэй дүүргийн урьдчилан саатуулах төвд гэхэд л 800 орчим хүнийг баривчлан хорьжээ. “Ганц худаг”-ийн урьдчилан хорих төвд үймээнд оролцсон, зохион байгуулсан 45 хүнийг хорьжээ. Шөнийн 01.00 цагт цэрэг, 02.30 цагт байлдааны техник оруулав. Нийслэл хот онцгой байдалд, даваадуулж хэлбэл цэрэг, зэвсгийн хяналтанд шилжлээ.

7-р сарын 2-ны өдөр АН-ын дарга Ц.Элбэгдорж, УИХ-ын гишүүн З.Энхболд, Х.Баттулга, Л.Гантөмөр, Б.Батбаатар нар үймээний үеэр гэмтсэн иргэдийн биеийн байдалтай танилцахаар Гэмтэл согог сэргээн засах клиникийн төв эмнэлэгт очжээ. “Гэмтэн ирсэн хүмүүсийн дийлэнх нь буюу 76 нь зөөлөн эдийн, 14 нь тархины, хоёр нь нурууны, долоо нь бууны суманд өртсөн, найм нь ясны хугаралтай, нэг хүн мултралттай гэсэн оношоор эмчлүүлж байгаа аж. АН-ын дарга Ц.Элбэгдорж тэдэнд “Хүний амь эрсэдсэн явдалд бид үнэхээр харамсч байна. Ард иргэдийнхээ эсрэг зэвсэг хэрэглэсэн тэр эдгээдүүдэд хариуцлага тооцох ёстой... Хүмүүс өөрийнхөө саналаа луйвардуулсандаа бухимдаад гарч ирэхэд нь хүчирхийлэл үүсгээд асуудлыг шийдэхгүй цаг алдлаа”¹⁶ гэж хэлсэн байна.

¹⁶ Цогзолмаа.Д. Үймээн самууны үеэр гэмтсэн иргэдтэй Ц.Элбэгдорж уулзлаа, -ӨС.№159 (2008.07.03)

ТАВАН ХҮН АМИА АЛДЖЭЭ



Хамгийн харамсалтай бөгөөд эмгэнэлтэй нь тэр шөнө жагсагчид, өөрөөр хэлбэл энгийн иргэдийн эсрэг байлдааны зэвсэг хэрэглэсэн байв. Дөрвөн хүн буудуулж, нэг хүн угаартан нас барсан байлаа. Цагдаагийнхан үймээнд оролцсон 800 гаруй иргэнийг баривчилжээ. Үймээнд оролцсон гэж үзэж баривчлагдсан иргэдийг цагдаагийн ажилтан болон бусад хуулийн байгууллагын ажилтнууд бөөнөөр нь жижиг өрөө тасалгаанд хүнд орчинд хорьж, мөрдөн байцаалтын үед хүчээр далайлган сүрдүүлэх, эрүүдэх, зодох болон худал мэдүүлэгт хүчээр гарын үсэг зуруулах зэргээр хууль завхруулж байсан нь ч удалгүй тодров. Мөн олон тооны насанд хүрээгүй хүүхдүүдийг баривчлан хорьж байсан ба шүүн таслах үед бүлэглэн төрийн эсрэг гэмт хэрэг үйлдсэн гэдэг үндэслэлээр ял тулган тасалж хуулийг завхруулсан гэж үздэг.

МАХН-ын байр шатахад тус намын архив давхар шатсан байдаг. Өөрөөр хэлбэл, орчин цагийн Монголын далд түүх шатсан байна. Мөн Соёлын төв өргөөнд байдаг Уран зургийн галерей шатсан бөгөөд үүний уршгаар Монголын дүрслэх урлагийн зарим сор бүтээлүүд алдагдаж, шатаж үрэгджээ.

Онцгой байдал зарлагдсан гурван өдрийн турш Ерөнхийлөгч Н.Энхбаяр улстөрийн намуудын удирдлагуудтай Төрийн ордонд

тогтмол уулзан, үүсээд буй зөрчилдөөнийг шийдвэрлэхийг уриалж чармайлт гаргаж байв. Нэгэн уулзалтын протоколд тэмдэглэснээр (2012.04.12-нд ил болсон) тухайн уулзалтад оролцсон улстөрийн намуудын дарга нар өөр өөрсдийн байр суурийг хамгаалан ширүүн маргалдаж байжээ. Ялангуяа жагсагчдыг хэн хэрхэн, яаж буудаж байсан талаар АН-ын дарга Ц.Элбэгдорж тодорхой мэдээлэлтэй байснаа тэрхүү уулзалт дээр тодорхой ярьж байжээ. Гэтэл 2012 оны хавар болсон ЦЕГ-ын хуучин удирдлагуудтай холбоотой анхан шатны шүүх хурал дээр дээрх протоколд тэмдэглэгдэн үлдсэн Ц.Элбэгдоржийн хэлсэн зүйл нотлох баримтаар огт сөхөгдөөгүй байна. Иргэдийн буудуулж амь алдсан тухай Ц.Элбэгдорж яаж тийм сайн мэдэж ярьж байсан нь олон нийтийн онцгой анхаарал татдаг.

7-р сарын 1-ний жагсаал, үймээн, хүчирхийлэл нь нийгмийн уур бухимдал, тодруулбал баялгийн тэгш бус хуваарилалт, авилга, шударга бус явдлын эсрэг хилэгнэлийн туйлширсан илрэл байсан юм. Жагсаалыг үймээн самуун болгох нь буюу болгосон нь гадны болоод дотоодын аль нэг улс төрийн хүчин, эдийн засгийн бүлэглэл, хувь хүмүүст ашигтай байсныг ч үгүйсгэх аргагүй. Олон нийтийг хамарсан жагсаал цуглааны дараа үүссэн нөхцөл байдал хурцдан даамжирч хүчирхийлэлд хүрч таван хүний амь эрсдэн, зуугаар тогтохгүй хүний эрүүл мэнд хохирч, 800-аад иргэн баривчлан саатуулагдаж, байгууллага, иргэдийн өмч хөрөнгө, соёлын үнэт өв сан устан үгүй болсон юм. Хамгийн ноцтой нь хүчний байгууллага ба иргэдийн хоорондын найрсаг, хүнлэг итгэлцэл, харилцаа бараг үгүй болж, төрд итгэх ард түмний итгэл айдсаар солигдсон билээ. Иргэний хөдөлгөөний намын дарга Ж.Батзандан, дэд дарга О.Магнай, Бүгд найрамдах намын дарга Б.Жаргалсайхан нарыг жагсаал цуглааныг өдөөн турхирсан гэж 25 жил хүртэл хорих, цаашлан цаазаар авах ялтай зүйл ангиар Эрүүгийн хэрэг үүсгэсэн байдаг.

Гэвч энэ бүх эвдрэл, үл итгэлцэл 2008 оны 8-р сарын 14-нд Монгол хүн анх удаа Олимпын алтан медаль авсан түүхэн өдөр улс төрийн дээд түвшинд ядаж л өнгөн талдаа үгүй болсон билээ. 7-р сарын 1-ний хар өдөр монгол түмнийг эвдрэлцүүлсэн гэж бараанаар дурсагдах бол 8-р сарын 14-ний өдөр монгол түмний эвлэрлийн, бахархлын түүхэн өдөр байлаа. УИХ-ын гишүүн Ц.Элбэгдорж “УИХ-ын сонгуулийн хуурамч дүн бол суудал, ямбандаа улайрсан манай увайгүй эрх баригчдаас Монгол

Улсын иргэдийн дархан, бие даасан байдал, тусгаар тогтнол, үнэт зүйлсэд нь, итгэлийг нь эвдэн халдсан төлөвлөгөөт “бохир дайн” байсан”¹⁷ хэмээн дүгнэсэн юм.

Цагдаагийн удирдлагуудаар туг тахив

Яваандаа хэрэг явдал тодорхой болж, цагдаагийн ажилтнууд галт зэвсэг хэрэглэсэн талаар мөрдөн байцаалт явуулж эхлэхэд цагдаагийн ажилтнууд эсэргүүцэл илэрхийлэн Сүхбаатарын талбайд жагсаал хийж эхлэв. Төр, түмнийг хамгаалах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үүрэгтэй цагдаагийн байгууллага болоод цагдаа зарим талаараа төрийн зүтгэлтэн, төрийн албан хаагчдын эсрэг жагсаал хийсэн нь чухамхүү үндсэн үүрэг, хариуцлагатай нь зөрчилдөж байлаа.

Эцэстээ галт зэвсэг хэрэглэсэн нь тогтоогдов. Ингэснээр ЦЕГ-ын даргын үүрэг гүйцэтгэгч асан, хошууч генерал Ч.Амарболд, хурандаа О.Зоригт, Ш.Батсүх нарт 2.6-3.6 жилийн хорих ял оноож, хурандаа Г.Ганбаатарыг “Өршөөл үзүүлэх тухай хууль”-д хамруулан сулласан билээ.Цагтаа “...Үймээний үед цагдаа иргэдийг буудаагүй. Хэрвээ буудсан байвал би хариуцлага хүлээнэ” гэж Ерөнхий сайд С.Баяр албан ёсоор мэдэгдэж байв. Цагдаагийн ажилтнууд зэвсэг хэрэглэн иргэдийн амь насыг хохироосон нь тогтоогдсон, цагдаагийн удирдлага генерал, хурандаа нар шүүхэд шилжин эрүүгийн хариуцлага хүлээсэн. Харин Ерөнхий сайд С.Баяр өөрийн мэдэгдэлдээ ч эзэн болоогүй, улс төрийн ба ёс суртахууны ямар ч хариуцлага хүлээгээгүй билээ.

АН-ын дарга Ц.Элбэгдорж: Амандаа ус балгасан мэт дуугүй суух уу!

АН-ын ҮЗХ долдугаар сарын 8-нд хуралдсан ба Намын дарга Ц.Элбэгдорж “6-р сарын 29-ний шөнө МАХН мэдэгдэл хийж ялалт байгуулж байгаагаа зарлаж эхэлсэн. Гэтэл энэ үеэр санал тооллого дөнгөж 30 хувьтай явж байсан. Иргэд ч санал луйвардчихлаа гэж бухимдан маргааш өдөр нь хэний ч зааваргүй

¹⁷ Элбэгдорж.Ц: Ардчилсан хувьсгалын ачаар энэ орон чинь монгол хүн нэг бүрийн эх орон болсон. Үзэл санааны улс болсон юм (ярилцсан Ж.Сандагдорж),-ӨС.№041, 042 (2009.02.16)

өөрсдийн үзэл бодлоо хамгаалж жагссан. Эхлээд ард түмний саналыг хулгайлж авдаг. Үүнийг эсэргүүцээд тэмцээд ирэхээр нь зохион байгуулалттайгаар үймээн болгох тактик байдаг. Үүнийг хэрэглэсэн¹⁸ гэж тус хурал дээр хэлсэн үгэндээ цохон тэмдэглэжээ. МАХН-ын зүгээс сонгуулийн булхай хийдэг арга улам боловсронгуй, хүний санаанд оромгүй хэлбэрээр явагдах болсныг энд ярьж байсан юм. Мөн цаашдаа автомат машинаар санал тоолдог дэлхий нийтийн жишгийг дагах тухай санал энэ хуралдааны үед гарлаа.

АН-ын дарга Ц.Элбэгдорж хэлэхдээ, "...МАХН-ынхан сонгуулийн луйвар хийхдээ үнэхээр гаршиж байна. Тэд энэ удаа л гэхэд "Гүйлгээ", "Сэлгээ" гэсэн хоёр арга хэрэглэсэн байна. "Гүйлгээ" гэдэг нь нэг хуудсаар дамжуулж олон хүн санал өгөх арга юм байна. "Сэлгээ" гэдэг нь нэг хүн олон удаа санал өгөхийг хэлжээ. Сонгуулийн өмнө МАХН 26 хүнээ Оросруу явуулж бэлтгэн, нөгөөдүүл нь ирээд 80 орчим хүнд нууцаар сурсан эрдмээ заасан байна. Одоо сонгуулийн луйврыг харин ч Ардчилсан нам хийсэн мэтээр дайрч эхэллээ. Ийм байхад Ардчилсан нам амандаа ус балгасан мэт дуугүй суух уу" гэж байв. ҮЗХ-ны гишүүд ч үзэл бодлоо илэрхийлж байсан бөгөөд ихэнх нь Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулах санал гаргаж, энэ асуудал олонхийн дэмжлэг авснаар таван ажлын хэсэг байгууллаа. Мөн юуны өмнө СЕХ-ны дарга Б.Баттулга, МҮОНРТВ-ийн удирдлага М.Наранбаатар, Б.Пүрэвдаш, УИБМТ-ийн дарга Л.Мөнхбаатар, ХХЕГ-ын дарга Г.Баатарцогт, ТЕГ-ын дарга Р.Болд, ЦЕГ-ын даргын үүрэг гүйцэтгэгч Ч.Амарболд нарыг огцруулж хариуцлага тооцох шаардлага хүргүүлэхээр болов. Хууль зөрчиж сонгууль будлиантуулсан, Онц байдлын үеэр хууль сахиулаагүй Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулах, эс тэгвээс шинээр бүрэлдэх УИХ-д Ардчилсан намаас сонгогдсон гишүүд оролцохгүй байхаар шийдлээ. Үүнийхээ дагуу ч Улсын их баяр наадмын өмнөх өдөр УИХ дахь АН-ын зөвлөлийн дарга, УИХ-ын гишүүн Л.Гансүх Засгийн газрыг бүрэн бүрэлдэхүүнээр нь огцруулах тогтоолын төслийг УИХ-ын дарга Д.Лүндээжанцанд өргөн барьсан юм.

¹⁸ Долгодмаа.Б. Ардчилсан нам амандаа ус балгачихсан юм шиг дуугүй сууж болохгүй нь, -ӨС.№164, 165 (2008.07.09)

ХААЛТТАЙ ХУРАЛДСАН ОНЦГОЙ ЧУУЛГАН

УИХ-ын онцгой чуулган онц байдал зарласнаас хойш 72 цагийн дотор хуралдах хуультай байдаг бөгөөд 7-р сарын 2-ны 18.40 цагт 57 гишүүний ирцтэйгээр хуралдаж эхэлжээ. Чуулганд Ерөнхийлөгч Н.Энхбаяр, Ерөнхий сайд С.Баяр нар оролцсон ба УИХ-ын гишүүн Э.Бат-Үүлийн санал, ХЗДХ-ийн сайд Ц.Мөнх-Оргилын дэмжлэгээр, санал хураалтын дагуу хаалттай хуралдсан байдаг. Э.Бат-Үүл хаалттай хуралдуулах болсон шалтгаанаа 2010 онд “Тэр үед УИХ нээлттэй хуралдсан бол Киргиз шиг болох байсан. Сонгуульд ялагдсан гишүүд нийгмийг мөргөлдөөнд турхирах гээд чуулганы танхимд орж ирсэн байсан. Гудамжинд танк зогсчихсон, цэргүүд бүсэлчихсэн, бүх хүн УИХ-ын чуулган хуралдахыг телевизээ асаагаад хараад сууж байсан. Чуулган нээлттэй болоод ялагдаж хорссон нөхөд алалцъя гээд орилсон бол хүмүүс гудамжинд гараад ирэхээр нөхцөл байдал үүссэн байлаа. Тэгээд аягүй бол цэргүүд зэвсгээ хэрэглэхийг байг гэхгүй.”¹⁹ гэж дурссан байдаг.

АРДЧИЛСАН НАМ УИХ-ЫН ЧУУЛГАНД ОРОЛЦОХГҮЙ



¹⁹ Бат-Үүл.Э: МАХН-ын захиалга байгаа гэж бодож байна (ярилцсан Д.Доржпагма), -ӨС.№215 (2010.09.10)

АН-ын Гүйцэтгэх зөвлөл УИХ-ын гишүүдээ оролцуулсан өргөтгөсөн хуралдаан хийж, Ерөнхийлөгч Н.Энхбаяр улстөрийн намуудын дарга нартай зөвшилцөөд ирэх 23-нд УИХ-ын анхны хуралдааныг хийж, шинээр сонгогдсон гишүүд тангарагаа өргөхөөр болсон тухай мэдээлэл цацагдаж буйтай холбогдуулан намын даргаасаа энэ талаар тодруулахыг хүссэн юм. АН-ын дарга Ц.Элбэгдорж, “Ерөнхийлөгч Н.Энхбаяр намуудын дарга нартай уулзсан. Тэгэхдээ зүгээр л зарлиг гаргах гэж байгаа шүү гэсэн мэдээлэл өгсөнөөс бус тэнд намуудын дарга нар зөвшилцөөд анхдугаар чуулганаа хийе, тэгье, ингэе гэсэн юм байхгүй” гэлээ.

Мөн ард түмний сонголтын эсрэг ажилласан булхайг илрүүлэх, иргэдийн амь нас, эрүүл мэндийг хохироосон гэмт хэргийг илрүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдалд халдаж, үйл ажиллагааг нь зогсоосон шалтгааныг судлах ажлын хэсгүүдийг томилон ажиллахаар болсон юм. Тэрчлэн Ардчилсан намын Гүйцэтгэх зөвлөл Дорноговь, Завхан, Хөвсгөл, Увс, Төв, Хэнтий аймагт сонгууль дахин явуулах шаардлага, мөн эдгээр аймагт сонгуулийн санал хураалтын үеэр болон сурталчилгааны хугацаа дууссанаас хойших хугацаанд бусад нэр дэвшигчдийн зүгээс хийсэн хууль бус үйлдлүүдийг баримтжуулан СЕХ-нд хүргүүлэхээр боллоо. Энэхүү УИХ-ын гишүүдээ оролцуулсан өргөтгөсөн хуралдаанд Сонгуулийн ерөнхий хорооны Нарийн бичгийн дарга Б.Баярсайханыг дуудаж оролцуулав.

АН-ын дарга Ц.Элбэгдоржийн хувьд УИХ-ын хуралдаанд оролцохгүй байх, ер нь МАХН-тай ямар нэг асуудлаар хэлэлцээрийн ширээний ард суухгүй гэсэн байр суурьтай байгаагаа илэрхийллээ. Харин АН юуны өмнө Сонгуулийн хуулинд өөрчлөлт оруулах хэрэгтэй гэж үзээд АН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Дорлигжав ажлын хэсэг байгуулан, ахлагчаар нь С.Ламбааг томилж байлаа.

Эмгэнэлт 7-р сарын 1-ээс гурван жилийн дараа буюу 2011 оны арванхоёрдугаар сарын 28-нд УИХ, Монгол Улс Тусгаар тогтнолоо сэргээн тунхагласны 100 жилийн ойд зориулан хүндэтгэлийн хуралдаан хийлээ. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж хүндэтгэлийн чуулганаар хэлсэн үгэндээ “Иргэнийхээ аюулгүй байдал, эрүүл мэнд, амьд явах үндсэн эрх, эрх чөлөөг нь хангаж чадаагүйнхээ төлөө ард иргэдээсээ болон амь насаа алдсан, эрүүл мэнд, эрх чөлөөгөөрөө хохирсон нийт иргэдийнхээ гэр

бүл, ойр дотныхноос Монгол улсын төрийн нэрийн өмнөөс уучлал гуйя”²⁰ хэмээн тэр нэгэн өдрийн эмгэнэлт үйл явдлын үеэр хохирогсдоос уучлал гуйсан юм, Монголын төрийн өмнөөс. Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржоос өмнө АН-ын дарга Н.Алтанхуяг ард түмнээсээ уучлал гуйсан байдаг.

УИХ-ЫН СОНГУУЛИЙН ДҮНГ МАН ӨӨРТ АШИГТАЙГААР ӨРГӨН БАРИВ

7-р сарын 14-ний өдөр СЕХ-ны дарга Б.Баттулга, Нарийн бичгийн дарга Б.Баярсайхан нар МУ-ын Ерөнхийлөгч Н.Энхбаярт 2008 оны УИХ-ын сонгуулийн дүнг өргөн барьсан юм. 26 тойрогт 356 нэр дэвшигч өрсөлдсөнөөс 22 тойргоос 66 гишүүн сонгогдсоныг Ерөнхийлөгчид өргөн барьсан байна. МАХН-аас 39, АН-аас 25 (Р.Гончигдорж, Н.Батбаяр, С.Ламбаа, Х.Баттулга, Батж.Батбаяр, Я.Батсуурь, Д.Батхүү, Д.Зоригт, З.Энхболд, Ц.Баярсайхан, С.Баярцогт, Э.Бат-Үүл, Р.Амаржаргал, Л.Гүндалай, Ц.Сэдванчиг, Л.Гансүх, Д.Одхүү, Л.Болд, Ч.Сайханбилэг, Л.Гантөмөр, Ц.Элбэгдорж, Г.Баярсайхан, Д.Батбаяр, Н.Алтанхуяг), ИЗН-аас нэг, бие даагч нэг сонгогджээ. УИХ-ын 25 дугаар тойрог буюу Баянгол дүүрэг, 7 дугаар тойрог буюу Дорнод, 18 дугаар тойрог буюу Хэнтий аймгийн санал хураалтын дүн эцэслэн шийдэгдээгүй байв.

МУ-ын Үндсэн хуулийн 27 дугаар зүйлийн дөрөв дэх хэсэг, МУ-ын ИХ-ын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн нэг дэх хэсэгт заасны дагуу Ерөнхийлөгч Н.Энхбаяр, Их Хурлын тавдахь удаагийн сонгуулийн Анхдугаар чуулганыг 2008 оны долдугаар сарын 23-ны өдрийн 10.00 цагт товлон зарлах зарлиг гаргажээ. Тэрбээр хуралдааныг нээж үг хэлэхдээ “Энэ удаагийн УИХ-ын сонгуулийг будлиантай болсон гэж огт бодохгүй байна. Бас зуун хувь шударга сайхан сонгууль болчихлоо гэдэгтэй санал нийлэхгүй байгаагаа улс төрийн намуудын болон СЕХ-ны удирдлагыг хүлээн авахдаа хэлж байсан” гэж хоёрдмол утгатай үг хэлэв.

Үүний дараа СЕХ-ны дарга Б.Баттулга сонгуулийн дүнг танилцуулсан ба танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асуужээ. Асуулт, хариултын дараагаар УИХ-д АН-аас нэр

²⁰ Элбэгдорж.Ц. Миний Монгол мөнх оршиг, -ӨС.№001 (2012.01.03)

дэвшин, шинээр сонгогдсон гишүүд хуралдааны танхимыг орхисноор тангараг өргөх ёслолын ажиллагаа, УИХ шинээр зохион байгуулагдах үйл ажиллагаа хийгдэх боломжгүй болсон бөгөөд анхдугаар чуулган түр завсарласан билээ.

МУ-ын Ерөнхийлөгчийн хуулийн бодлогын зөвлөх Д.Зүмбэрэлхам “Үндсэн хууль, УИХ-ын тухай хуульд зааснаар Төрийн сүлдэнд тангараг өргөснөөр гишүүний бүрэн эрх эхэлдэг. УИХ-ын чуулганы хаалт, анхдугаар чуулганы нээлт болсноос үл хамааран хуучин гишүүдийн бүрэн эрх дуусгавар болох, шинэ гишүүний бүрэн эрх эхлэх тэр торгон зааг бол тангараг өргөх ажиллагаа байгаа юм. Шинэ 57-оос доошгүй гишүүний бүрэн эрх хүчинтэй байвал бүрэн эрхээ хэрэгжүүлэх бүрэлдэхүүнтэйд тооцохыг хуульд тодорхой заасан. Тэгэхээр шинэ сонгогдож түр үнэмлэх авсан доод тал нь 57 хүн буюу нийт гишүүдийн дөрөвний гурав нь тангараг өргөснөөр хуучин, шинэ гишүүдийн бүрэн эрх халаагаа авалцаж, УИХ-ын шинэ бүрэлдэхүүн хөдлөх юм”²¹ гэж тайлбарласан байна.

МУХАРДАЛД ОРСОН Ц.ЭЛБЭГДОРЖ НАМЫН ДАРГЫН АЖЛАА ӨГНӨ

Ардчилсан намын дарга Ц.Элбэгдорж мэдээлэл хийх тухай зар долдугаар сарын 18-нд гэнэт тарлаа. Тэрбээр, “Засгийн газар огцрохгүй байна. Уг нь өөрөө огцрох ёстой. Ардчилал ард түмний нүдэн дээр амь тавьж байна. УИХ-ын хуралдааныг хар. Үнэхээр ой гутмаар... Ер нь би цаашдаа АН-ын дүрэм журмынхаа дагуу намын даргын албан тушаалаа өгнө” гэж мэдэгдсэн нь гэнэтийн цочир алхам байлаа. Асуудлыг өөр өнцгөөс харахад эсрэг нам буюу МАХН, АН-ын шаардлагыг биелүүлээгүйн улмаас Ц.Элбэгдорж яагаад намын даргынхаа суудлыг өгдөг билээ гэсэн асуулт хариултгүйгээр үлдэж байв.

Улстөрийн үүсэн бий болсон нөхцөл байдлаас улбаалаад АН-ын Гүйцэтгэх зөвлөл (2008.07.22) дахин хуралдлаа. Хурлаас УИХ-ын анхдугаар чуулганд түр үнэмлэхээ авсан гишүүд оролцох, чингэхдээ СЕХ-ны дарга Б.Баттулгад асуулт тавин, хариулт аваад л УИХ-ын чуулганыг орхин гарах шийдвэр гарав.

²¹ Зүмбэрэлхам.Д.: Төрийн ажил төгсөх газраа төгсч, эхлэх газраа эхэлж байх ёстой (ярилцсан Х.Хэрлэн), -ӨС.№179 (2008.07.26)

Өөрөөр хэлбэл, тангараг өргөх ёслол болон тогтоол гаргах үйл ажиллагаанд оролцохгүй байхаар шийджээ. Долдугаар сарын 22-ны мягмар гарагт 2004-2008 оны УИХ-ын сүүлчийн чуулган хуралдаж хаалтаа хийлээ. Ингээд шинэ УИХ-ын анхны хуралдаан (2008.07.23) болоход Ардчилсан намаас УИХ-д сонгогдсон гишүүд тогтсон ёсоороо тангараг өргөхгүй гэсэн тайлбараа хэлээд танхимыг орхин гарсан юм.

ДОЛООН УДАА ЗАРЛАГДСАН АНХДУГААР ЧУУЛГАН

АН-ын ажлын хэсгийнхэн: Халуун байна зангиагаа тайлчих уу

УИХ-ын анхдугаар чуулганыг цаашид үргэлжлүүлэх, шинээр сонгогдсон гишүүдийг тангараг өргүүлэх ёслолыг хийх үүднээс хоёр нам зөвшилцөхөөс аргагүй байдалд хүрэв. Үнэндээ бол монголын улс төр гацаанд орчихоод байлаа. Ингээд хоёр талаас ажлын хэсгээ томилов. АН-ын ажлын хэсгийг З.Энхболд ахалж, С.Баярцогт, Н.Батбаяр, Х.Баттулга, Ч.Сайханбилэг нар бүрэлдэхүүнд ньорсон бол МАХН-ын ажлын хэсэгт Д.Дэмбэрэл, Сү.Батболд, Н.Энхболд, Су.Батболд, Ж.Сүхбаатар нар оржээ.

Хоёр намын зөвшилцөх ажлын хэсгийн анхны уулзалт 7-р сарын 24-нд, хоёрдахь уулзалт 29-нд болсон байна. Анхны уулзалтын үеэр МАХН-ын ажлын хэсгийн зүгээс “УИХ-даа орж тангарагаа өргө, цааш явмаар байна” гэсэн хүсэлт тавив. АН хариуд нь “Сонгуулийн дүн эцэслээгүй байна. Сонгуулийн маргаантай байгаа тойргуудын дүнг дахин авч үзэх, “7-р сарын 1”-ний хэргээр хоригдож байгаа хүмүүсийг өршөөх, суллах, Сонгуулийн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах” гэсэн шаардлагыг тавиад, цаашид ажлын хэсгүүдийнхээ хүрээнд хэлэлцэхээр болон тарлаа. Чухам энэ үед АН-ынхан, “Халуун байна, цөмөөрөө зангиагаа тайлчих уу” гэж байгаад энэ асуудлыг хэлэлцсэн байдаг юм. Үнэхээр улстөрийн нөхцөл байдлын хувьд ч, хэлэлцэж байгаа асуудал ч, нийгмийн сэтгэлзүй ч, гадаа ч тэр тун халуун байлаа.

Цаг хугацаа өнгөрсөөр. Зарчмын хувьд байр суурь нэгдээгүй хэвээр л. МАХН-ынхан ямар ч аргаар хамаагүй, зарчмыг умартан анхдугаар чуулганыг үргэлжлүүлэх, шинээр УИХ-ыг байгуулахыг

бүтэлгүй оролдсоор л. Хуульч Б.Чимид “Гацааж буй эзэн нь АН-ын удирдлага, УИХ-ын гишүүний түр үнэмлэх авсан эдний цөөн хүн юм шиг сэтгэгдэл төрүүлж буй ч цаана нь далд өөр эзэд, өөр сонирхол байна уу гэх эргэлзээ надад төрж байгаа. Улс төрийн нөхцөл байдлыг хүндрүүлж буй гол шалтгаан нь аливаа асуудлыг намын, тэр ч байтугай түүний толгойд суугаа явцуу бүлгийн ашиг сонирхолд нийцүүлэх гэсэн дур зоргын хандлагатай холбоотой”²² гэж дүгнэсэн байдаг. Өөрөөр хэлбэл, Монголын төрийн тогтолцоог аль нэгэн нам хүчин гэлгүйгээр, эдийн засгийн сонирхол нэгтэй хэсэг бүлэг эрх ашгийнхаа төлөө ашигладаг хэрэгсэл болгосны нэгэн баталгааг дээрх шалтгаантай болоод шалтгаангүй гацаагаар тайлбарлажээ.

Хоёр намын харилцааны хувьд ийнхүү мухардмал байдал орж эхэлсэн тул хэлэлцээрийн ширээний ард сууж зөвшилцөх хэрэгтэй гэсэн саналыг АН-ын сонгогдсон олон гишүүд Гүйцэтгэх зөвлөлдөө нэг бус удаа тавьж байв. Үүссэн улстөрийн нөхцөл байдал төрийн өндөр дээд алба хашиж асан хүмүүсийн анхаарлын гадна байсангүй. Тухайлбал, Ерөнхийлөгч асан Н.Багабанди, Ерөнхий сайд асан Д.Содном, Ш.Гунгаадорж нар сонгогдсон гишүүдийнхээ тоогоор талцан маргах бус, улс нийгмийнхээ эрх ашгийн үүднээс МАХН ба АН хамтран ажиллах ёстой гэсэн зөвлөмжийг МАХН-ын дарга С.Баяр, АН-ын дарга Ц.Элбэгдорж нарт өгч байлаа.

УИХ-ын үйл ажиллагаа тасалдсаны бурууг хоёр нам бие биенээсээ хайж байсан ч АН-ын байр суурь нь 76 гишүүний нэрийг өргөн барих, бариулах шаардлага дээр төвлөрч байв.

Намаасаа зөрсөн Э.Батүүл УИХ-д орж суув

АН-аас УИХ-д сонгогдсон 25 гишүүн тангараг өргөөгүйн улмаас Монгол Улс нэг цаг дор хуучин ба шинэ хоёр парламенттай болчихоод байв. Энэ үед УИХ-ын гишүүн Э.Бат-Үүл, Батж. Батбаяр нар (2008.08.13) хэвлэлийн бага хурал хийлгэлээ. Э.Бат-Үүл, “УИХ-ын үйл ажиллагаа 20 хоног гацлаа. Мухардлаа. Ерөнхийлөгч Н.Энхбаярын хийж байгаа үйл ажиллагаа ч буруу байна. Хоёр намын ажлын хэсгүүд ч гацаанд орсон. Энэ УИХ Ардчилсан намын 25 гишүүнгүйгээр цаашаа явахгүй. Манай

²² Чимид, Б.: УИХ-ыг ард түмэн байгуулчихсан, одоо ажиллах л шаардлагатай (ярилцсан И.Рэнчинханд), -Ө.№194 (2008.08.22)

шинээр сонгогдсон 25 гишүүн тангараг өргөхгүйгээр СЕХ-той хэзээ ч хариуцлага тооцох боломжгүй” гэж мэдэгдэв. АН-ын зарим гишүүд тангараг өргөхөд бэлэн, намын нэгдмэл байр суурь ганхаж болох, тухайн онцгой нөхцөлд тохируулан уян хатан хандах шаардлага урган гарсны энгийн баталгаа энэ байв. Ерөнхийлөгч Н.Энхбаяр шинэ УИХ-ын анхдугаар чуулганыг наймдугаар сарын 18-ны өдөр зарласан боловч үр дүнд хүрсэнгүй. Гэхдээ энэ өдрийн хуралдаанд АН-ын гишүүдээс Э.Бат-Үүл, Батж. Батбаяр хоёр орж суусан нь содон байлаа. Э.Бат-Үүл “Эрхэм Ерөнхийлөгч өө! Та гишүүдээ тангараг өргүүлээч гээд намын дарга нарт хандаад байх юм. Тангараг өргөх үү, үгүй юу гэж хэн намаасаа асуух юм. Асуухгүй. Харин хувь гишүүдэд нь хандвал өөр байж магадгүй. Би лав намаасаа асуухгүй” гэв. Харин Батж. Батбаяр “Хожим хэн нэгэн би өргөхгүй ээ гээд байхад та нар өргүүлсэн биз дээ гэвэл яахвэ. Хэлэх үггүй болно биз” гэх зэргээр ихэвчлэн Ерөнхийлөгчид хаягласан санал, шүүмжлэл хэлжээ.

Намууд зөвшилцөв

Ардчилсан нам болоод МАХН-ын ажлын хэсгүүд наймдугаар сард доорх асуудлаар зөвшилцөөнд хүрснээр улстөрд үүсээд байсан гацаа арилах өнгө харагдав.

1. МУ-ын Үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулах,
2. Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах,
3. Сонгуулийн хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах,
4. Улстөрийн намуудын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах,
5. Төрийн албаны тухай хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт оруулах,
6. УИХ-ын тухай хуульд УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны дэргэд Сонгууль, нэгдсэн бүртгэлийн дэд хороо байгуулах талаар нэмэлт, өөрчлөлт оруулах,
7. Ашигт малтмалын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах,
8. Ашигт малтмалын орлогоос иргэн бүрт хүртээх тухай “Эх орны хишиг” сан, “Эрдэнийн хувь” хууль батлуулах,
9. Ажлын байр нэмэгдүүлэх, амьжиргааны түвшин

дээшлүүлэх шинэ бодлого боловсруулж батлуулах,

10. Үнийн өсөлт, инфляцийг хязгаарлах дунд болон урт хугацааны хөтөлбөр боловсруулж батлуулах гэсэн 10 зүйл заалт байсан бөгөөд үүнийг нь АН-ын Гүйцэтгэх зөвлөл сайшаасан юм.

67 гишүүн тангараг өргөв



Үйл явц үргэлжилсээр. 8-р сарын 14-нд СЕХ-ны дарга Б.Баттулга, МУ-ын Ерөнхийлөгчид УИХ-ын сонгуулийн Хэнтий аймгийн дүн болох МАХН-аас нэр дэвшсэн Н.Ганбямба, Б.Бат-Эрдэнэ, Д.Арвин нарын нэрийг айлтгалаа. Харин Баянгол дүүрэг, Дорнод аймгийн сонгуулийн үр дүнг гацсан, гацаасан хэвээр байв. Мөн сарын 28-ны өдөр Ерөнхийлөгч Н.Энхбаяр УИХ-ын анхдугаар чуулганыг үргэлжлүүлэхээр 17.30 цагт тов зарласан ба чуулганы танхимд гишүүний түр үнэмлэх авсан 67 гишүүн ирсэн байлаа. Ерөнхийлөгч “2008 оны УИХ-ын анхдугаар чуулганыг энэ оны долдугаар сарын 23-нд зарлан хуралдуулсан. АН-ын гишүүд хурлыг орхисон учир чуулган завсарлахад хүрсэн. Энэ удаа долоо дахь удаагаа товлон зарлаж байна” гэсэн юм. Чуулган дэгийн дагуу явсаар тангараг өргөх ёслол эхэлсэн бөгөөд энэ удаагийн УИХ-ын ахмад гишүүн болох Д.Дэмбэрэл тангараг уншихад бусад нь дагаж уншин тангараг өргөжээ.

СЕХ-оос Ерөнхийлөгчид нэрийг нь өргөн барьсан 69 гишүүнээс 67 гишүүн тангараг өргөж АН-ын дарга Ц.Элбэгдорж, ИЗН-ын дарга С.Оюун нар ёслолд, чуулганд оролцоогүй байна.

АРДЧИЛСАН НАМЫН ШИНЭ ДАРГААР Н.АЛТАНХУЯГ СОНГОГДОВ

“Ядаж нөгөөдөр...”

Наймдугаар сарын 28-нд АН-ын дарга Ц.Элбэгдорж намынхаа хэсэг нөхөдтэй уулзаж байхдаа гэнэтхэн “Маргааш намын даргынхаа ажлыг өгнө” хэмээн мэдэгдлээ. Журмын нөхөд нь ч гайхав. Н.Алтанхуяг “Юу гэсэн үг вэ, ядахдаа нөгөөдөр больё” гэсэн байдаг. Ц.Элбэгдорж Ардчилсан намын даргаас чөлөөлөгдөх хүсэлт бүхий өргөдлөө 29-ны өдөр өглөө. Ингэж яарах болсны чухам шалтгаан нь намын даргын халааг өгөх бас авах, залгамжлуулах ба залгамжлах үйл явц бэлтгэгдсэнд оршиж байсан нь хожим тодорхой болсон билээ.

ҮЗХ-оор намын дүрэмд өөрчлөлт оруулав



ҮЗХ-ны ээлжит бус 27 дугаар хуралд наймдугаар сарын 30-нд хуралдлаа. Ажиглагчид АН-аас УИХ-ын хуралдаанд дур мэдэн орж суусан Э.Бат-Үүл, Батж.Батбаярыг хэлэлцэж, намаас хөөхгүй юм гэхэд хатуу донгодох хурал болно гэж үзэж байв. Яг энэ асуудлыг ҮЗХ-ны гишүүн Х.Золжаргал хөндөн, хариуцлага тооцох санал оруулсан ч ҮЗХ-ийн гишүүд авч хэлэлцсэнгүй. Цаашлаад АН-ын Ёс зүйн хороонд ирсэн өргөдөл, санал гомдлуудыг ч татаж авсан буюу хэрэгсэхгүй болгосон байжээ.

Чухам үнэндээ нам дотор үүссэн шинэ нөхцөл байдал буюу үндсэндээ намын дарга Ц.Элбэгдорж чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасантай уялдуулж зохион байгуулсан хурал гэдэг нь эхнээсээ тодорхой болж, юуны өмнө намын даргаа сонгох дүрэмд өөрчлөлт орууллаа. Ингэснээр намын дарга өргөдлөө өгсөн, эсвэл өвчний учир, шүүхээр хэрэг хийсэн нь тогтоогдвол АН-ын Их хурлыг зарлахгүйгээр ҮЗХ-ноос намын даргыг сонгоно гэсэн заалт оруулав. АН-ын дарга Ц.Элбэгдорж намын тамгаа З.Энхболдод залгамжлуулахын тулд ҮЗХ-ны гишүүдээ “хайрцаглан”, ийм өөрчлөлтийг хийсэн ч гэж үздэг.

Ардчилсан намын даргаар Н.Алтанхуяг сонгогдов

Н.Алтанхуяг намын даргад нэрээ дэвшүүлж өрсөлдсөн нь зарим хүний төлөвлөгөө тавилтыг эвдэж орхив.

Намын даргыг сонгох асуудлын эхэнд Э.Бат-Үүл шинэ даргыг АН-ын Их хурлаар шийдэх ёстой гэсэн санал гаргасан хэдий ч, нэгэнт дөнгөж сая шинээр өөрчилсөн дүрмийн дагуу шийдэх учир ҮЗХ-ийн олонхи гишүүн хүлээж авсангүй. Орон нутгийн сонгууль аравдугаар сарын 12-нд зарлагдсан нөхцөлд намын их хурал, шинэ даргын тухай ярилтгүй, цаг хугацаа ч байхгүй, тэгээд ч намын дүрмээр нэрээ 30 хоногийн өмнө дэвшүүлэх ёстой гэх мэтийн шалтгааныг ҮЗХ-ны гишүүд өгүүлээд, оруулсан өөрчлөлтийг мөрдөнө гэдэгт санал нэгдэж байв.

АН-ын ҮЗХ, 180 орчим хүний бүрэлдэхүүнтэй хуралдан намын даргад УИХ-ын гишүүн З.Энхболд, Н.Алтанхуяг нар өрсөлдсөнөөс санал тооллогын дүнгээр АН-ын шинэ даргаар Н.Алтанхуяг илүү санал авч сонгогдов.



МУХАРДАЛ ДУНДАХ ГАРЦ: ХАМТАРСАН ЗАСАГ

Шинэ даргын эхний өдөр

Н.Алтанхуягийг АН-ын даргаар томилогдсоны яг маргааш нь буюу ням гарагт МАХН-ын дарга, МУ-ын Ерөнхий сайд С.Баяр уулзах урилга ирүүлсэн байна. Уулзалтын үеэр МАХН-ын дарга С.Баяр АН-ын дарга Н.Алтанхуягт хамтарч ажиллах санал тавьжээ. Үүссэн нөхцөл байдалд хатуу байр сууринаас хандаж байсан Ц.Элбэгдоржийн оронд аливаа асуудалд уян хатан, зөвшилцөх байдлаар ханддаг Н.Алтанхуяг сөргөлдөгч намын нь дарга болсон явдал С.Баярын өмнө улстөрийн үүссэн нөхцөл байдлаас эвтэйхэн гарах боломж олгосныг үгүйсгэх аргагүй. Тиймээс тэрбээр хожим өөрийнхөө байгуулсан хамтарсан Засгийн газрыг “Стандарт бус” хэмээн нэрлэсэн биз ээ.

Хамтарсан Засгийн газар байгуулах ажлын хэсэг байгуулагдав



АН-ын шинэ дарга хэвлэлийн хурал дээр “МАХН олонхи болохоор бид сөрөг хүчин болж ажиллах. Нөгөө нь олонхитой

хамтрах буюу шинэ сонголтоор бүрдсэн засаг төрийн хариуцлагыг хуваалцах явдал юм... Хамтрах нь Ардчилсан намд биш ард түмэнд л хэрэгтэй, наалдацтай байх болно”²³ хэмээн намын байр суурийг илэрхийлэв.

Мөн, “Намайг Ардчилсан намын даргаар сонгогдсоны маргааш өдөр МАХН-ын дарга С.Баяр урьж уулзаад, журмын нөхдийнхөө итгэлийг хүлээн сонгогдсонд баяр хүргэсэн. Хүн бүхэн биднээс ард түмнийхээ амьжиргааг хэрхэн, яаж дээшлүүлэх гээд байгаа юм бэ гэж асууж байгаа цаг үе учраас тэрхүү том эрх ашгийн үүднээс хамтарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байгаа саналаа С.Баяр даргад хэлсэн. Энэ саналынхаа хамт шинэ УИХ-ынхаа 76 гишүүнийг нэн хурдан, бүрэн бүрэлдэхүүнээр нь ажиллуулахын тулд боломжит бүх шаардлагыг тавьж, хэрэгжүүлэх хэрэгтэй гэдгээ ч хэлсэн. Эцсийн эцэст АН, МАХН-тай хамтарна гэж яримааргүй байна. Гэхдээ ард түмний амьдралыг дээшлүүлэх төрийн бодлого, төрийн үүргийн төлөө хамтарч ажиллахаас өөр аргагүй байна. Цөөнх болсон АН-д саналаа өгсөн иргэд сонгогчдын итгэл найдвар биелэгдэхгүй үлдэх ёсгүй” гэв. Хэвлэлийн хуралд оролцож байсан УИХ-ын гишүүн З.Энхболд, “Бид АН-ын шинэ даргаа дэмжиж ажиллана аа” хэмээн залгуулан мэдэгдсэн юм.

Есдүгээр сарын 4-нд МАХН-ын дарга, Ерөнхий сайд С.Баяр АН-ын дарга, УИХ-ын гишүүн Н.Алтанхуягтай уулзаж, Хамтарсан Засгийн газар байгуулах саналыг МАХН-ын Бага хурал 100 хувь дэмжсэн тухай тогтоолыг танилцууллаа. Н.Алтанхуяг дарга, “Манайх энэ саналыг ҮЗХ-ны хурлаараа хэлэлцээд хариуг нь өгнө” гэв. Тус уулзалтад АН-аас Ч.Сайханбилэг, Ч.Билэгсайхан, Г.Батхүү, Л.Гансүх нар оролцсон билээ. Нийгмийн ба улстөрийн нэн эгзэгтэй үед хамтран ажиллах, ойлголцох хамгаас чухал байдаг бөгөөд байх ч биз ээ.

Хагарах амар, хамтрах хэцүү

АН-ын дарга Н.Алтанхуяг МАХН-ын зүгээс тавьсан хамтарсан Засгийн газар байгуулах саналыг 2008 оны есдүгээр сарын 5-ны өдөр ҮЗХ-ны ээлжит бус 28 дугаар хурлаараа хэлэлцүүлээ. Хурлын уур амьсгал халуун бас хатуу болно гэдэг нь анхнаасаа

²³ Алтанхуяг.Н: Том эрх ашгийн төлөө хамтрах нь зөв гэж үзэж байна (ярилцсан Б.Хажидмаа),-ӨС.№213 (2008.09.04)

тодорхой байв. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр хамтрах хэрэгтэй, хэрэггүй гэсэн саналаа АН-ын ч, МАХН-ын ч гишүүд илэрхийлсээр. УИХ-ын гишүүн Э.Бат-Үүл “Өдрийн сонин”-д “Хамтрах гэж юу яриад байгаа юм. Хаана ч олонхи болсон нам дангаараа Засгийн газраа байгуулдаг. Энэ чинь ардчиллын зарчим” гэсэн нь ердөө ганц жишээ билээ.

ҮЗХ-ны хурал Энхтайвны гүүрийн баруун талд байх Аялал жуулчлалын газрын зааланд болов. Хэн хаанаас авчирсан нь тодорхойгүй уриа лоозон байрлуулжээ: Агуулга нь МАХН-тай яах гэж хамтрах гээд байна вэ, боль гэсэн утгатай. Намынхаа шинэ даргыг С.Баяртай хамт нэг хөнжилд оруулаад зурчихсан дүрслэлтэй.

Хуралдаанд ҮЗХ-ны гишүүн бус хүмүүс, тодруулбал Ардчилсан хувьсгалын партизанууд оролцохыг эрмэлзсэн ч дүрмийн дагуу заалнаас гаргалаа. Үүнд нь бухимдсан партизанууд хурлын завсарлагаанаар гарч ирсэн ҮЗХ-ны гишүүд рүү түүхий өндөгөөр нүүлгэж байв. Тэр олон өндгийг хэн хаанаас авчирсан нь, зарим хүнд согтууруулах ундаа тараасан нь ч мөн тодорхойгүй байдаг. Н.Алтанхуягийн нэр хүндийг унагах гэсэн дээрх оролдлого харин ч намын шинэ даргын нэр хүнд намын гишүүд, дэмжигчдийн дунд хэр өндөрт байдгийн баталгаа болсон билээ.

Хурал ширүүн эхлэв, өрнөв. Чингэсээр МАХН-ын санал болгосон Хамтарсан Засгийн газарт Ардчилсан нам орох эсэх талаар санал хураахаар болов. Энэ үед Ц.Элбэгдорж “Хамтарч ажиллах эсэх дээр санал хурааж болно. Гэхдээ эхлээд хамтран ажиллах зарчим дээрээ санал хураах нь зүйтэй” гэсэн боловч олонхийн дэмжлэг авсангүй. Цаашлан С.Эрдэнэ “Дүрмийн биш дарга-Н.Алтанхуяг” гэсэн үгийг дахин гаргаж ирсэн боловч ҮЗХ-ны гишүүд тоосонгүй. Кёкушюүзан Д.Батбаяр, “Намын эрх ашгаас илүү ард түмний эрх ашиг гэж бий. ҮЗХ хуралдаж байгаад МАХН-тай хамтрах эсэхээ шийдье” гэлээ. Б.Дэлгэрмаа, “Эвсэх нь зүйтэй гэж үзэж байна. Ард түмнийхээ эрх ашгийн төлөө ирэх дөрвөн жилд асар их ажил хийх ёстой” гэлээ. Энэ мэтээр ҮЗХ-ны гишүүд үзэл бодлоо илэрхийлсэний дараа санал хураалт явуулах үед Элбэгдорж толгойлсон хэсэг гишүүд хурлыг хаяж гарав. Гэвч ирц хангалттай байсан тул санал хураалт явуулж олонхийн саналаар Ардчилсан нам МАХН-тай хамтран ажиллахаар болсон билээ. Мөн энэ хурлаар АН-ын Ерөнхий нарийн бичгийн даргын сонгууль

явуулахад Намын дарга Н.Алтанхуягийн санал болгосон ҮЗХ-ны Багануур дүүргийн төлөөлөл Д.Эрдэнэбат 132 хүнээс 110 хүний санал авснаар энэ албан тушаалд очсон юм.

Ингэж олон сарын турш хэрхэн, хаашаа эргэх нь үл мэдэгдэж асан АН-ын байр суурь тодорхой болж, С.Баярын санаачилсан стандарт бус буюу олонхи болсон хэрнээ цөөнхтэйгөө хамтарсан Засгийн газрыг байгуулах ажил шуударлаа. Харин АН-ын хувьд юуны өмнө нийгмээ, ард түмнээ айдасгүй амар жимэр аж төрөн, ажиллаж амьдрах боломжоор хангах, нөгөө талаас 2008 оны Сонгуулийн мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэх, улс орны өмнө зайлшгүй шийдвэрлэх ёстой хөгжлийн гол гол асуудлаа хамтарсан дээрээ шийдээд авах гэсэн гурван зорилгын үүднээс МАХН-ын Засгийн газарт орж ажиллахаар шийдсэн байдаг. Ялангуяа иргэддээ амалсан “Эрдэнийн хувь” хишгээ хүртээхэд онцгой анхаарна гэдгээ мэдэгдэж байв.

Мөн энэ хурлаас дөрөв хоногийн дараа (2008.09.09) АН-ын Гүйцэтгэх зөвлөл хуралдаж, УИХ дахь АН-ын Бүлгийн дарга, УИХ-ын дэд дарга нарыг томилох сонгууль явуулан, олонхийн санал авсан УИХ-ын гишүүн Ч.Сайханбилэгийг АН-ын Бүлгийн дарга, УИХ-ын гишүүн Г.Батхүүг УИХ-ын Дэд даргад нэр дэвшүүлэхээр тогтон, ёсоор болсон юм. Түүнчлэн Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны даргаар З.Энхболд, Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хорооны даргаар Б.Батбаяр, Эдийн засгийн байнгын хорооны даргаар Ц.Баярсайхан нар сонгогдож байв.

Хамтран ажиллах гэрээ байгуулагдав

АН-ын дарга Н.Алтанхуяг есдүгээр сарын 11-нд намынхаа Гүйцэтгэх зөвлөлийг зарлан хуралдуулж, юуны өмнө АН хамтарсан Засгийн газарт орохын тулд МАХН-тай маш нарийн, бас туйлын тодорхой гэрээ хийх хэрэгтэйг онцлоод, тушаал гарган ажлын хэсэг байгуулав. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд УИХ-ын гишүүн Н.Батбаяр, Х.Баттулга, Ц.Баярсайхан, С.Баярцогт, Ч.Сайханбилэг, Ц.Сэдванчиг нар орсон байлаа, ахлагч нь С.Баярцогт. Цаашлаад Хамтран ажиллах гэрээний төсөлд Ардчилсан намын сонгуулийн мөрийн хөтөлбөрөөс түлхүү оруулсан тохиолдолд баталгаажуулах үүргийг АН-ын дарга Н.Алтанхуяг өглөө. Ингээд есдүгээр сарын

12-ны өдөр хоёр намын хамтран ажиллах гэрээ бэлэн болж, гарын үсгээ зурцгаав.



Уг гэрээнд АН-ыг төлөөлж УИХ-ын гишүүн С.Баярцогт, Н.Батбаяр, Х.Баттулга, Ц.Баярсайхан, Ч.Сайханбилэг, Ц.Сэдванчиг, МАХН-ыг төлөөлж УИХ-ын гишүүн М.Энхболд, Сү.Батболд, Г.Занданшатар, Д.Лүндээжанцан, Э.Мөнх-Очир, Ц.Нямдорж нар гарын үсэг зурлаа. Есдүгээр сарын 17-ны өдөр Ардчилсан намын дарга Н.Алтанхуяг батламжлав.

Чингэснээр МАХН, АН-ын хамтран ажиллах таван зүйл 85 заалт бүхий гэрээ бүрэн батлагдлаа.

Хамтарсан Засгийн газар байгуулагдав

9-р сарын 11-ний өдрийн УИХ-ын нэгдсэн хуралдаанаар Ерөнхийлөгч Н.Энхбаяр бүрэн эрхийнхээ дагуу МУ-ын Ерөнхий сайдад МАХН-ын дарга С.Баярыг нэр дэвшүүлснийг танилцуулсан бөгөөд санал хураалтад 66 гишүүн оролцсоноос 65 нь дэмжиж С.Баяр МУ-ын Ерөнхий сайдаар хоёрдахь удаагаа томилогдсон билээ.

Маргааш нь хамтарсан ЗГ байгуулахаар болсон хоёр намын дарга нар Төрийн ордонд хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зуржээ. Үүнээс 6 хоногийн дараа АН-ын ҮЗХ хуралдсан ба Намын

дарга Н.Алтанхуяг, УИХ-ын дэд дарга Г.Батхүү, УИХ дахь АН-ын бүлгийн дарга Ч.Сайханбилэг нар цаг үеийн байдал, орон нутгийн сонгуулийн асуудлаар мэдээлэл хийсэн байна. Үүний хойно Гүйцэтгэх зөвлөл хуралдан Сангийн сайдаар С.Баярцогт, Батлан хамгаалахын сайдаар Л.Болд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдаар Л.Гансүх, Зам тээвэр, хот байгуулалтын сайдаар Х.Баттулга, Эрүүл мэндийн сайдаар С.Ламбаа нарыг дэмжихээр тогтон, шийдвэрийг Ерөнхий сайд С.Баярт танилцуулах болжээ.

Ингэснээр 19-ний өдрийн УИХ-ын чуулганааршинэ, хамтарсан, стандарт бус гэхчлэн олон тодотгол, нэр хүртсэн Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнийг баталлаа. С.Баярын оруулсан шинэ Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэх үед Ерөнхийлөгч болон УИХ дахь намуудын бүлгээс зарим нэг санал оруулсан боловч Ерөнхий сайд С.Баярын дэвшүүлсэн хувилбар “ногоон гэрлээр” батлагдав. Ингэснээр хамтарсан Засгийн газар 11 яам, 15 сайдтайгаар үйл ажиллагаа явуулахаар болж, цааш цаашдын нь ажил ч шуурхай өрнөж эхэллээ.

УИХ-ын гишүүн, АН-ын дарга Н.Алтанхуягаас Тэргүүн шадар сайдаар дөнгөж томилогдсоных нь дараа “Өдрийн сонин”-ы сурвалжлагч ийн асуужээ.

- Та нэгэнтээ манай сонинд ярилцлага өгөхдөө хамтарсан Засгийн газар байгууллаа гэхэд би сайд болохгүй ээ гэж хэлж байсан санагдана?
- Тийм. Би тэгж хэлж байсан. Хамтарсан Засгийн газрыг байгуулахаар болох үед энэ саналыг тавихад нь татгалзаж байсан. Гэвч манай намын журмын нөхөд хамтарсан засагт намын дарга заавал орох ёстой гэж байлаа. МАХН-ын зүгээс ч АН-ын дарга Тэргүүн шадар сайдаар ажиллах нь аль аль талдаа зохимжтой, эс тэгвээс энэ Засгийн газар тун хэврэг байх магадлалтай гэж үзсэн юм билээ. Тэгээд л нөхдийнхөө шийдвэрийг дагалаа даа.

Харин УИХ дахь АН-ын бүлгийн дарга Ч.Сайханбилэгт “Ардчилсан нам бүлэгтэй боллоо. Тэгсэн хэрнээ хамтарсан Засгийн газарт бас орж байна. Тэгэхээр сөрөг хүчнийхээ үүргийг огтхон ч гүйцэтгэж чадахаа болих нь дээ” гэсэн асуулт басхүү тавигдсан юм.



- Сөрөг хүчин болж чадна. УИХ дахь АН-ын бүлгийн хоёр хөл нь хоёр өөр газарт зогсч байна гэсэн үг. Нэг хөл маань хамтарсан Засгийн газарт орж ачааны хүндийг үүрэлцэнэ. Нөгөө нь шийдэгдээгүй удаж байгаа асуудлыг шавдуулж, зөв чигт нь хандуулах ёстой. Тэгэхээр ард түмэн, сонгогчдынхоо итгэл найдварыг хүлээж, биелүүлж ажиллана гэдэгт огтхон ч эргэлзэх хэрэггүй.
- Хамтарсан Засгийн газрыг эсэргүүцэж байгаа хүмүүс нэлээд байна шүү дээ?
- Энэ бол нийгмийн хамгийн эрүүл үзэгдэл...

Хамтарсан Засгийн газрын гишүүд

1. Ерөнхий сайд С.Баяр /МАХН/
2. Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг /АН/
3. Шадар сайд М.Энхболд /МАХН/
4. Монгол улсын сайд, ЗГХЭГ ын дарга Б.Долгор /МАХН/
5. Гадаад харилцааны сайд Сү.Батболд /МАХН/
6. Сангийн сайд С.Баярцогт /АН/
7. Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж /МАХН/
8. Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх /АН/
9. Батлан хамгаалахын сайд Л.Болд /АН/
10. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ё.Отгонбаяр /МАХН/
11. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга /АН/
12. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди /МАХН/
13. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай /МАХН/
14. Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт /МАХН/
15. Эрүүл мэндийн сайд С.Ламбаа /АН/

Шинээр томилогдсон 15 сайдын 10 нь УИХ-ын гишүүн байв. МАХН-аас ес, АН-аас зургаан хүн сайдын суудалд очлоо. Өөрөөр хэлбэл, хамтарсан Засгийн газар дахь хүчний харьцаа 60:40 болсон юм.

Цаашлан мөн оны төгсгөлөөр дэд сайдуудыг томилсон ба АН-

аас Гадаад харилцааны дэд сайдаар Б.Болор, Боловсрол, соёл, шинжлэх ухааны дэд сайдаар Ч.Куланда, Зам тээвэр, барилга хот байгуулалтын дэд сайдаар А.Гансүх, Нийгэм хамгаалал, хөдөлмөрийн дэд сайдаар Д.Нямхүү, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн дэд сайдаар Б.Золжаргал, Эрдэс баялаг, эрчим хүчний дэд сайдаар Б.Ариунсан тус тус томилогджээ.

УИХ-ын тав дахь удаагийн намрын чуулганы нээлтийн үеэр Ерөнхийлөгч Н.Энхбаяр хэлсэн үгэндээ “МАХН, АН хоёр хамтран ажиллах гэрээгээ хэрэгжүүлж ажиллавал манай нийгэмд сүүлийн жилүүдэд ихээхэн газар аваад байгаа хэт улс төржиж талцаж явдлаас ангижирч, улс орны өмнө тулгамдсан томоохон асуудал, зорилтуудыг шийдвэрлэхэд зоримог алхам хийх байх гэсэн хүлээлт байна. Бас төрийн ажилд зохиомол саад бий болгодог, явцуу бүлэг ба хувийн сонирхлоо гүйцэлдүүлэхийн тулд нийтийн эрх ашгийн нэр барин элдвээр “жүжиглэдэг” зохисгүй явдлыг даамжруулахгүй таслан зогсоож, улс төрийн соёлын шинэ хэм хэмжээ тогтоох, улмаар үндэсний нэгдмэл үзэл санаа төлөвшихөд түлхэц болно гэж найдаж буй” хэмээсэн нь ард түмний нийт хүсэл сонирхлыг илэрхийлсэн хэрэг байлаа.

Шатахуун, цахилгаан, төмөр замаар ОХУ-аас хараат, эдийн засгийн хувьд БНХАУ-аас хараат шахуу болсон Монгол Улсын хувьд нэн тэргүүнд эдийн засгаа өөд нь татах шаардлага зайлшгүй урган гарч байв. Энэ шаардлагын үүднээс, эв нэгдэл хангах гэсэн өргөн утгаар засаглалын хамтарсан хэлбэрийг ойлгох нь зүйтэй болов уу.

ИХ АЖЛЫН ЭХЭН

Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан МАХН, АН-ын хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг Монгол улсын Мянганы хөгжлийн зорилтод тулгуурласан Үндэсний хөгжлийн цогц бодлого, МАХН, Ардчилсан намын хооронд 2008 оны есдүгээр сарын 12-ний өдөр байгуулсан хамтын ажиллагааны гэрээ болон хувийн хэвшлийн байгууллагуудын төлөөллийн санал, Монгол улсын Засгийн газраас олон улсын байгууллагуудтай өмнөх жилүүдэд байгуулсан гэрээ, хэлэлцээр зэргийг үндэслэн 15 хоногийн дотор бэлэн болгоод Засгийн газрын хуралдаанд оруулж байлаа.



Энэ удаагийн боловсруулсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн нэг онцлог нь зөвхөн өөрийн эх орондоо оршин сууж байгаа Монгол улсын иргэдийн нийгэм, эдийн засгийн асуудлаас гадна анх удаа хилийн чанадад, гадаад оронд оршин сууж, ажиллаж, сурч, хөдөлмөрлөж, амьдарч байгаа иргэдийнхээ өмнө тулгамдаж байгаа олон асуудлыг шийдвэрлэх, зохицуулах талаарх зорилтыг тусгасан байв. Ингээд таван үндсэн зорилт бүхий хамтарсан Засгийн газрын хэрэгжүүлэх хөтөлбөр батлагдсан бөгөөд эндээс Ардчилсан намын мөрийн хөтөлбөрөөс юу юу тусгагдсаныг харахад нэг их төвөг учрахгүй буйза.

1. Ашигт малтмалын салбарын хөгжлийг түргэтгэж эрх зүйн орчныг шинэчлэх, ашигт малтмалын стратегийн болон томоохон ордуудыг эдийн засгийн эргэлтэд оруулах асуудлыг бодитойгоор хэрэгжүүлж, түүнээс олсон орлогоос иргэдэд хүртээх;
2. Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж, уул уурхайн салбарт түшиглэсэн үйлдвэрлэл, орон нутгийн түүхий эдэд тулгуурласан жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх;
3. Мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүнээр, тухайлбал, мах, сүү, гурил, төмс, хүнсний ногоогоор хүн амын хүнсний хэрэгцээг бүрэн хангах;

4. Иргэн бүр эрүүл, боловсролтой, ажилтай, орлоготой байх нөхцөлийг бүрдүүлэхийн зэрэгцээ мэргэжилтэй ажилтан бэлтгэхэд онцгой анхаарах;
5. Төрийн удирдлагын ил тод, нээлттэй, шуурхай, шударга, хариуцлагатай, ёс зүйтэй, ажил хэрэгч байдлыг хангаж, төр, иргэний харилцан итгэлцлийг бэхжүүлэх.

Ийнхүү хамтарсан, эвссэн, стандарт бус Засгийн газарт мөрийнхөө хөтөлбөрөөс чамлахааргүй хэмжээнд тусгуулж дөнгөсөн Ардчилсан намын дарга, Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, сайд С.Баярцогт, Л.Гансүх, Л.Болд, Х.Баттулга, С.Ламбаа гэсэн төлөөлөлтэйгөөр Засгийн газрын их ажилдаа орлоо.

Ийнхүү төр, засаг дээд шатандаа төвхсөнөөр, ойлголцосноор Монгол Улсын улс төр гацаанаас гарав.

ОРОН НУТГИЙН СОНГУУЛЬ БОЛОВ



Гэхдээ Ардчилсан намын дотоод амьдрал бужигнасан хэвээр байлаа. Энэ бужигнаан нь хэрүүл тэмцэл биш, харин орон нутгийн сонгуулийн асуудал байв. Үнэндээ тус нам өмнө нь орон нутгийн сонгуульд онцгой анхаарал тавьж ирээгүй байдаг. Нэг талаасаа намын дотоод хүч, нөөц, боломжийг анхаардаггүй байдал, нөгөө талаасаа орон нутгийн удирдлагын суурийг дутуу

үнэлдэг байдал нь чингэхэд нөлөөлдөг байсан нь харамсалтай үнэн байлаа.


Харин Ардчилсан намын даргаар Н.Алтанхуяг томилогдсоны дараа болсон ҮЗХ-ны хоёр ч ээлжит бус хурлаар Орон нутгийн сонгуулийн талаар тун нухацтай хэлэлцэж, онцгой ач холбогдол өгөхөөр шийдвэр гаргасан юм.

2008 оны аравдугаар сарын 4-7-ны хооронд АН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Эрдэнэбат тэргүүтэй хүмүүс Сүхбаатар, Хэнтий аймгуудад ажиллаж, орон нутгийн сонгуулийн сурталчилгааг хэрхэн зохион байгуулж байгаа ажилтай танилцан газар дээр нь зөвлөгөө өгөв. Иргэдтэй ч уулзлаа. Намынхандаа ч хэрхэн яагаад МАХН-тай хамтрах болсон тухай тодорхой тайлбарлан таниулав.

2008 оны аравдугаар сарын 12-ны ням гарагт орон нутгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдийг сонгох сонгууль болов. Хөдөө орон нутгийн сонгогчид харьцангуй идэвхтэй оролцож ирц тавиас дээш хүрснээр 21 аймгийн ИТХ, сумдын ИТХ-ын сонгууль хуулийн дагуу хүчинтэй болжээ. Харин Дорноговь аймгийн Замын-Үүд, Хэнтий аймгийн Дархан сум, түүнчлэн нийслэлд ирц хүрээгүй, тухайлбал 47,4 хувийн ирцтэй (тодруулбал нийслэлийн есөн дүүргээс Баянзүрх, Сонгинохайрхан, Чингэлтэй дүүргийн сонгогчдын ирц хуульд заасан босгонд хүрээгүй) тул дахин сонгууль явуулах байдалд хүрэв.

АН Сүхбаатар, Завхан, Өмнөговь, Дорноговь аймгийн ИТХ-д олонхи болжээ. Энэ нь хөдөө орон нутагт Ардчилсан намын гаргаж буй анхны томоохон амжилт яах аргагүй мөн байв. Цаашлаад дөрвөн аймаг АН-ын Засаг даргатай боллоо. Тухайлбал, Сүхбаатар аймгийн Засаг даргаар Ж.Батсуурь, Завхан аймгийн Засаг даргаар Я.Санжмятав, Өмнөговь аймгийн Засаг даргаар Б.Бадраа, Дорноговь аймгийн Засаг даргаар П.Ганхуяг нар сонгогджээ. Мөн ИТХ-д ойролцоо суудал авсан Говь-Алтай, Баянхонгор аймгийн Засаг даргын орлогчоор Х.Энхбаяр, О.Тойвгоо нар сонгогдож байлаа.

Нийслэл, дүүргийн дахин сонгуулиар ч Ардчилсан нам чамлахааргүй амжилт үзүүлсэн билээ. Тодруулбал, Нийслэлийн ИТХ-ын төлөөлөгчдийн 40 суудлаас есийг нь авчээ. Хан-уул дүүргээс Б.Ариунболд, Х.Баттуул, П.Батчимэг, Да.Ганболд,



Э.Тамир, Баянгол дүүргээс С.Одонтуяа, Сонгинохайрхан дүүргээс Л.Эрхэмбаяр, Сүхбаатар дүүргээс Д.Нямхүү, Д.Баттулга нар сонгогдсон юм. Мөн Хан-Уул дүүргийн Ардчилсан нам ИТХ-ынхаа 35 суудлын 27-г авч олонхи болоод байлаа. Гэвч Хан-Уул дүүргийн МАХН-ын хороо ялагдлаа хүлээн зөвшөөрөхгүй маргаан үүсгэж, хэсэг хугацаанд ойлгомжгүй байдал үүсгэв.

Ардчилсан нам, Нийслэлийн Ардчилсан нам, Хан-Уул дүүргийн Ардчилсан нам аргагүйн эрхэнд арваннэгдүгээр сарын 18-нд Сонгуулийн ерөнхий хороо, Нийслэлийн Сонгуулийн хороонд шаардлага хүргүүлсэн юм. Гэтэл Орон нутгийн сонгууль явагдаад даруй 24 хоног өнгөрөөд байхад асуудлыг шийдэлгүй сунжруулсаар л. Харин ИТХ-ын сонгууль явагдаж дууссанаас хойш 14 хоногийн дотор дүнг зарлаж, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага үйл ажиллагаагаа саадгүй үргэлжлүүлэн явуулах ёстой билээ.

Үнэн ялдаг жамаар, Хан-Уул дүүргийн Засаг даргаар АН-ын Ц.Ганхуяг сонгогдов. Намын дарга Н.Алтанхуяг Хан-Уулын АН-ынхандаа баяр хүргэн, мэндчилгээ дэвшүүллээ.

Энэ удаагийн нийслэл, дүүргийн сонгуулийн нэг онцлог нь иргэдийн сонгуулийн идэвх маш их суларсан тул ирц бүрдэхгүй байх магадлал өндөрссөнөөр хорооны ажилтнууд айл гэрийн хаалга бүрийг тогшин саналаа өгөөрэй хэмээн гуйж, сануулж байлаа. Гэвч эцсийн дүндээ ирц 47 хувьд хүрч, нийслэлийн гурван дүүрэгт ирц хүрээгүйн улмаас дахин сонгууль явуулсан түүхтэй.

Орон нутгийн сонгуульд есөн нам, бие даагч гэсэн субъект нэр дэвшүүлсэн ба аймаг, нийслэлийн ИТХ-д намуудаас 1638, бие даагч 140 хүн нэрээ дэвшүүлсэн ажээ. Харин сум, дүүрэгт 14881 хүн өрсөлдөв. Аймгийн ИТХ-ын сонгуулийн урьдчилсан дүнгээр МАХН 393, АН 233, бие даагч 16 суудал авсан байна. Харин дахин сонгуулиар НИТХ-ын 45 суудлын 36-г МАХН, есийг нь АН авчээ.



25 ДУГААР ТОЙРГИЙН МАРГААН

Зарим нэгэн шалтаг, шалтгаан, будилаан, хариуцлагагүй байдлаас болж УИХ-ын хэд хэдэн тойргийн нэгэнт сонгогдсон гишүүд тангарагаа өргөж, бүрэн эрхээ хэрэгжүүлж, ард түмний төлөөлөл байх, хууль санаачлах, батлах эрхээ хэрэгжүүлж чадахгүй хэвээр байлаа. 2008 оны 9-р сарын 17-нд УИХ-ын долдугаар тойрог буюу Дорнод аймгаас сонгогдсон гурван гишүүн тангараг өргөсний нэг нь АН-аас нэр дэвшсэн П.Алтангэрэл байлаа. Харин Баянгол дүүргийн санал хураалтын дүн эцэслээгүй хэвээр.

2009 оны нэгдүгээр сард УИХ-ын 25-р тойргоос сонгогдсон Х.Тэмүүжин, Д.Энхбат, Ц.Мөнх-Оргил нар тангараг өргөж, бүрэн эрхээ баталгаажууллаа. Харин АН-аас нэр дэвшигч С.Эрдэнийн ИХ-ын гишүүний бүрэн эрх хуулийн байгууллага шалгасан, хуулийн байгууллагаар шалгуулсантай холбоотойгоор хойшилсоор, сунжирсаар.

Нийслэлийн АН-ын дарга, Улсын нийгмийн даатгалын газрын дарга асан С.Эрдэнэ, мөн АН-ын хэд хэдэн гишүүнийг шүүхээр ялласан нь улс төрийн амьдралыг хурцатгалаа. Нэгдүгээр сарын 27-нд АН-ын Гүйцэтгэх зөвлөл, УИХ дахь намын бүлэгтэй хамтран өргөтгөсөн хуралдаан хийжээ.

Хуралдаанаар С.Эрдэнийн хоригдсонтой холбогдуулан асуудлыг гүнзгийрүүлэн судлаж үзэх, цаашид намын гишүүдээ хамгаалахын тулд хэрхэх ёстой талаар санал дүгнэлт гаргахаар Ч.Сайханбилэгээр ахлуулсан ажлын хэсэг томилсон байна. Тус хурлаар мөн мэдэгдэл гаргажээ.

Мэдэгдэлд “УИХ-ын 2008 оны ээлжит сонгуулийн дараагаар өөрийн итгэл үнэмшлийн дагуу үзэл бодлоо илэрхийлсэн олон зуун иргэнийг хоморголон шүүх, хууль хяналтын байгууллагууд зохион байгуулалттайгаар яллаж, шүүн тасалж байгаа нь Монгол Улсад ардчилсан шударга ёс алдагдаж, шүүх, прокурорын байгууллага нэг хүний, нэг намын улс төрийн хараат байдалд орсныг гэрчилж байна. УИХ-ын гишүүнээр сонгогдсон С.Эрдэнэ болон сонгуулийн тойрог, хэсгийн хороодод ажилласан төрийн албан хаагчдыг үзэл бодлоор нь ялгаварлан эрүүгийн хариуцлагад татан яллаж Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг ноцтой зөрчсөн нь ард түмний сонголтыг улс төрийн зорилготойгоор шүүх, прокурорын байгууллага хууль

бусаар засварласан хэрэг боллоо. Хэн нэгэнд ямар нэг хохирол учраагүй байхад эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зарчмыг алдагдуулж нотлох баримтгүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй хэргийг урьдчилан төлөвлөсний дагуу улс төрийн зорилгоор олноор нь ял тулгаж шүүн тасалсныг эрс эсэргүүцэж байна” гэжээ.

Харин УИХ-ын 25 дугаар тойрогт МАХН-аас нэр дэвшигч Н.Баяртсайхан хариу мэдэгдэлдээ “Анхан шатны шүүхээс Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргаар ажиллаж байсан С.Эрдэнийн хууль зөрчсөн үйл ажиллагаанд нь оногдуулсан хорих ялыг Монгол Улсын Их Хурлын 2008 оны сонгуулийн 25 дугаар тойргийн маргаантай холбогдуулж оногдуулсан ял мэтээр шүүхийн шийдвэрийг гуйвуулж, олон нийтэд зориуд худал мэдүүлгийг Ардчилсан намаас тарааж байгааг эрс эсэргүүцэж байсан гэсэн бол Улсын дээд шүүхээс анхан шатны шүүх улс төрийн зорилгоор яллаагүй, цаашлаад АН-д “Хатуу арга хэмжээ авна” гэсэн мэдэгдэл гаргасан байна.

УИХ-ын сонгуулийн 25 дугаар тойрогт нэр дэвшигч С.Эрдэнэд Эрүүгийн хуулийн 239 зүйл ангиар эрүүгийн хэрэг үүсгэж, улмаар Баянгол дүүргийн шүүх авч хэлэлцлээ. Ингэснээр АН-аас нэр дэвшигч С.Эрдэнэ эрүүгийн гэмт хэрэгтэн болж хувирав. Гэтэл улсын ялагч гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй байна гээд яллахаас татгалзжээ. Ингэсэн тохиолдолд эрүүгийн хэрэг хэрэгсэхгүй болдог хуультай билээ. Харин улсын ялагч яллахаас татгалзмагц Баянгол дүүргийн Шүүхийн шүүгч Х.Батбаяр, “Би 00-д орчихоод ирье” гээд гарч яван 20 орчим минут болсныхоо дараа эргэж орж ирээд Шүүхийн захирамж гарган, уг хэргийг нэмэлт мөрдөн байцаалтад буцаасан байдаг. Ингээд арванхоёрдугаар сарын 31-ний өдөр Авилгатай тэмцэх газрын мөрдөн байцаагч н.Одхүү С.Эрдэнийг дуудаж ирүүлээд, “Танд одоо Эрүүгийн хуулийн 239 бус 150 дугаар зүйлийн 3-аар буюу бусдын эд хөрөнгийг завшиж, үрэгдүүлсэн гэх хэргээр эрүүгийн хэрэг үүсгээд шүүхэд шилжүүлсэн гэдгээ мэдэгджээ. Гурав хоногийн дараа БГД-ийн шүүх хуралдан С.Эрдэнийг ЭХ-ийн 150 дугаар зүйлийн 3-аар ял тулган, улмаар зургаан жил жирийн дэглэмтэй хорих ангид ял эдлүүлэх, 200.000 мянган төгрөгөөр торгох шийдвэр гаргав. Шүүх хуралдаанаар 25 дугаар тойргийн хорооны дарга Д.Үүрийнтуяа, Н.Лувсандагва нарт 5,1 жил хорих, 200 000 мянган төгрөгийн нь эд хөрөнгийг хураах, 50 сая төгрөгийг нөхөн төлүүлэх шийдвэр

гаргалаа. Тэрчлэн энэ тойргийн хороонд ажиллаж байсан бусад шүүгдэгчдэд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 51 дахин нэмэгдүүлсэн буюу 5,5 сая төгрөгөөр торгох ял оноов.

Тухайн үед Ардчилсан намын дарга, Монгол Улсын Тэргүүн Шадар сайд Н.Алтанхуяг Улсын Дээд Шүүхийн Ерөнхий шүүгч Батдэлгэртэй энэ асуудлаар тусгайлан уулзаж С.Эрдэнэтэй холбоотой асуудлыг улс төржүүлэхгүй, үнэн зөв шударга шийдэх тал дээр анхаарч ажиллахыг хичээнгүйлэн хүссэн байдаг. Н.Алтанхуяг энэ тухайгаа “Амьдралдаа анх удаа Дээд шүүхийн Ерөнхий шүүгчтэй уулзаж намын нөхрийнхөө асуудлаар хүсэлт тавьлаа” гэж тухайн үеийн хэвлэлд ярьжээ.

Анхан шатны шүүхийн шийдвэрийг шүүгдэгчид эсэргүүцэн давж заалдсан билээ. Иймээс С.Эрдэнэ нарын долоон хүнд холбогдох хэргийг Нийслэлийн шүүх дөрөвдүгээр сарын 17-ны өдөр хянасан байна. Хэргийг хянаад шүүгдэгчдийг яллах нотлох баримт хангалтгүй гэж үзээд хэргийг мөрдөн байцаалтад буцаахаар болсон юм. Ингэснээр С.Эрдэнэ 100 гаруй хоног хоригдсоны эцэст мөн сарын 29-нд “Ганц худаг”-ийн урьдчилан хорих төвөөс суллагдан, батлан даалтанд гарчээ.

НДЕГ-ын дарга асан С.Эрдэнийг Эрүүгийн хуулийн 150 дугаар зүйлийн гурваар аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өмчийг итгэмжлэгдэн хариуцсан атлаа завшин үрэгдүүлсэн хэмээн буруутган эрүүгийн хэрэгт татсан билээ. Тэрбээр (2009.09.24) Баянгол дүүргийн шүүгч Т.Өсөхбаярийн даргалсан шүүх хуралд нэмэлт мэдүүлэг өгөхдөө “Энэ зүйл ангийг огт ойлгохгүй байна. Би аж ахуйн нэгж удирдаж ажиллаж байгаагүй. Харин тангараг өргөсөн төрийн албан хаагч учир ямар ч эд зүйл итгэмжлэн хариуцаж байгаагүй” хэмээж байсан юм. Даваа гаригийн 20.00 цаг хүртэл хуралдсан шүүх хурал маргааш нь 15.00 цагт завсарлаж шүүх бүрэлдэхүүн шийдвэр гаргахын тулд хэлэлцэхээр боллоо.

Шүүгч Т.Өсөхбаяр, Ц.Оюунчимэг, Д.Уранчимэг нар 15.00 цагаас эхлэн хэлэлцсээр 21.00 цаг хүргэв. Эрүүгийн байцаан шийтгэх хуулинд шүүх бүрэлдэхүүн тухайн өдрийн 22.00 цагт багтаан шийдвэрээ гаргах ёстой хэмээн заасан байдаг учир 21.20 цагт ямар шийдвэр гаргаснаа танилцуулав. Нийслэлийн прокурорын газраас Эрүүгийн хуулийн 150.3-аар иргэн С.Эрдэнэд яллах дүгнэлт үйлдэн ирүүлсэн гэмт хэргийг хэрэгсэхгүй болгон цагаатгах шийдвэр гаргалаа.



Үйл явдал шалтгаантай бас шалтгаангүй шахуу унжирч сунжирсаар наймдугаар сарын 25-нд Баянгол дүүргийн шүүх Нийслэлийн АН-ын дарга, Нийгмийн даатгалын газрын дарга С.Эрдэнэд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгосон билээ.

Л.ГҮНДАЛАЙГ ШОГЛОХЫГ ОРОЛДОВ

Улсын ерөнхий прокурор М.Алтанхуяг мөн оны аравдугаар сарын 2-ны өдөр “Эрүүгийн гэмт хэргийг эцэслэн шийдвэрлэх бололцоо олгох зорилгоор энэ асуудлыг шийдэж өгнө үү” хэмээн УИХ-ын гишүүн Л.Гүндалайн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай асуудлыг УИХ-д тавьжээ. Халдашгүй байдлын дэд хорооны дарга Ч.Улаан, гишүүн Ц.Нямдорж, Д.Лүндээжанцан нар УИХ-ын гишүүн Л.Гүндалайн бүрэн эрхийг түдгэлзүүлэх нь зүйтэй гэсэн шийдвэр гаргасан бол Р.Гончигдорж татгалзсан байна. Энэ асуудлын тухай УИХ-ын гишүүн Л.Гүндалай “Эрүүл мэндийн сайд байхдаа тендер будлиантуулж улсад хохирол учруулсан гэж би хоёр жил гүтгүүлж байна. Ер нь яамны сайд тендерийн үйл ажиллагаанд оролцдоггүй, тендерийг зохион байгуулдаггүй. Хууль нь ч ийм. Тендерийн үйл ажиллагааг манай ТНБД Б.Батсэрээдэнэ бүгдийг нь зохион байгуулж гүйцэтгэсэн. Үүний үр дүнд “Сийменс” компанийн MRI, “Женерал электрик” компанийн 250 ширхэг эхо аппарат цаг хугацаандаа орж ирсэн. Эдгээр нь чанартай, дэлхийн тэргүүлэгч хоёр компанийн тоног төхөөрөмж” гэж тайлбарлажээ. Үнэндээ бол тухайн тендерт БНХАУ-ын үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг мөн санал болгосон байдаг. Маш товчоор бол арай чанартай бүтээгдэхүүнийг арай үнэтэй сонгосон хэрэг л болжээ. Эрүүл мэндийн сайд асан Л.Гүндалайг арай чанар муутай бүтээгдэхүүнийг арай хямдаар аваагүй хэмээн буруутгаж, УИХ-ын гишүүнээс түдгэлзүүлэх тухай асуудал нь мөнөөх л нэг суудлын үнэ цэнэ, мөнөөх л барьцаа, мөнөөх л АН-ыг дотроос нь хагаралдуулах зорилго, мөнөөх л ард түмний дунд АН-ын нэр хүндийг унагах чиглэлд оршиж байв.

Харин хэдэн жилийн дараа УИХ-ын гишүүн Ж.Энхбаяр, Ц.Нямдорж нарыг огцруулах асуудлыг гаргаж ирэхэд МАХН (тухайн үеийн МАН) өндгөө харамласан бүргэд мэт хамгаалж авч үлдсэн байдаг билээ.



“ШУДАРГА СОНГУУЛЬ”-ИЙН ТӨЛӨӨ ХЭЛЭЛЦҮҮЛЭГ



Аль ч шатны сонгуулийг цаашид шударга явуулахгүй бол сонгогчдын саналыг луйвардах, иргэдийн Үндсэн хуулиар олгогдсон сонгох, сонгогдох эрх ноцтойгоор зөрчигдөх, яваандаа сонгогчдын итгэл алдарч, сонгуулийн ирц бүрдэхгүй байх, нийгмийн сөрөг үзэгдэл газар авах нь нэгэнт тодорхой болсон нь 7-р сарын 1-ний үймээнээр ил болсон билээ. Ийм байдлыг таслан зогсоож, аливаа улс төрийн намын хариуцлагыг дээшлүүлэх асуудалд Ардчилсан нам онцгой анхаарах болов. Тиймээс 2009 оны нэгдүгээр сарын 23-нд “Шударга сонгууль” сэдэвт анхны хэлэлцүүлгийг Ардчилсан намын Улстөрийн бодлогын хэлтэсээс зохион байгуулж, 2008 оны УИХ болон орон нутгийн сонгуулийн үеэр гарсан хууль бус зөрчил, маргаантай асуудлуудыг хэлэлцлээ. Хэлэлцүүлэгт орон нутгийн сонгуулийн тойрог, хэсгийн хороодод дарга, нарийн бичгийн дарга, гишүүдээр ажилласан АН-ын гишүүдийн төлөөлөл оролцож, хаана ямар зөрчил гарсныг баримттайгаар дэлгэн, цаашид хэрхэх талаар ярилцав.

“Шударга сонгууль” хэлэлцүүлгийн маргааш нь Ардчилсан нам ард түмэндээ хандаж дараах мэдэгдлийг гаргалаа. “...УИХ-ын гишүүнээр сонгогдсон С.Эрдэнэ болон сонгуулийн тойрог хэсгийн хороодод ажилласан төрийн албан хаагчдыг үзэл бодлоор нь

ялгаварлан, эрүүгийн хариуцлагад татан яллаж, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийг ноцтой зөрчсөн нь ард түмний сонголтыг улстөрийн зорилготойгоор шүүх, прокурорын байгууллага хууль бусаар засварласан хэрэг боллоо. Хэн нэгэнд ямар нэг хохирол учраагүй байхад Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагааны зарчмыг алдагдуулж, нотлох баримтгүй, гэмт хэргийн бүрэлдэхүүнгүй хэргийг урьдчилан төлөвлөсний дагуу улстөрийн зорилгоор ял тулгаж, шүүн тасалсныг эрс эсэргүүцэж байна. Бусдыг хууль бусаар гэмт хэрэгт холбогдуулан яллах замаар УИХ-ын сонгуулийн 25 дугаар тойрогт МАХН-аас нэр дэвшсэн Н.Баяртсайханыг УИХ-ын гишүүнээр сонгогдсон гэж тулгахыг хэзээ ч хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ Ардчилсан нам албан ёсоор мэдэгдэж байна. Шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч байгууллагын үйл ажиллагаа шударга бус явагдаж байгаад түүнийг томилдог Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр, болон Шүүхийн ерөнхий зөвлөл дүгнэлт хийж, зохих этгээдүүдэд хариуцлага тооцохыг шаардаж байна. Шударга ёс, хүний эрх, эрх чөлөөг хангах, шүүх, хууль сахиулах байгууллагын үйл ажиллагааг үндсээр нь өөрчлөх чиглэлээр бүхий л хүч бололцоогоо дайчлан ажиллахаа Ардчилсан нам Монголын нийт ард түмэндээ хариуцлагатайгаар мэдэгдэж байна”.

2009 ОНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ

МУ-ын Ерөнхийлөгчийн сонгууль дөхөх үед цуу яриа, гүжир гүтгэлэг дэгддэгээрээ дэгдэв. Жишээлбэл, АН энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд сул нэр дэвшигч тодруулж, МАХН-ын нэр дэвшигчийг дэмжих нь гэсэн цуу ихэд тархлаа. Харин “Өдрийн сонин” (2009.03.30), АН-ын дарга Н.Алтанхуягаас маш тодорхой хариулт авсан байдаг.

Н.Алтанхуяг: “Бидэнд энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд ялах үнэхээрийн чин хүсэл, эрмэлзэл байна. Зарим нэг хэвлэл, мэдээллийн хэрэгсэл АН сул хүн гаргаж өгөх гэж байгаа тухай бичсэн байна билээ. Уншсан. Тийм юм ёстой байхгүй. Бид 20 жил ардчиллын замаар явлаа. Монгол Улс анх удаа ардчилсан Ерөнхийлөгчтэй болох цаг нь ирсэн гэж бодож байна. Ардчиллын төлөө зүтгэж ирсэн бүх хүн үүнийг тууштай дэмжих

байх. Сонгуулийн кампанийн явцад ч энэ талаар байнга уриалах болно” гэсэн байв.

АН-ын Гүйцэтгэх зөвлөл хуралдаж дөрөвдүгээр сарын 2-нд ҮЗХ-ны хурлыг, Их хурлын товыг дөрөвдүгээр сарын 3-нд тус тус хуралдуулахаар зарлалаа. Намын дүрмийн дагуу ҮЗХ-ноос нэр дэвшигчийг тодруулж, Их хурал батламжлах ёстой бөгөөд ҮЗХ-ноос оруулсан нэр дэвшигч намын их хурлаас олонхийн санал авахгүй бол шууд дахин нэр дэвшүүлэх бүрэн эрхтэй юм. Гуравдугаар сарын дунд үе гэхэд Л.Гүндалай, Г.Батхүү, Ц.Элбэгдорж, Э.Бат-Үүл, Р.Амаржаргал, Р.Гончигдорж нар дэвших бололцоотойгоо намын удирдлагад илэрхийлээд байв. Намын дүрмийн дагуу дээрх зургаан нэр дэвшигч ГЗ-ийн хурлаар орох ёстой ба цааш нь нэр дэвшигчдийг ҮЗХ-ны хуралд оруулж их хуралд нэг нэр дэвшигч тодрох ёстой билээ.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тав дахь удаагийн сонгууль Ардчилсан намын хувьд нэн чухал байсан ба энэ нь ч МУ-ын Тэргүүн шадар сайд, Ардчилсан намын дарга Н.Алтанхуагийн “Ардчилсан намын хувьд энэ сонгуульд маш том ач холбогдол өгч байгаа. Ардчиллын 20 жилийн түүхэнд ардчилсан Ерөнхийлөгч сонгогдож байгаагүй юм. Ардчилал гэж ярьсаар бид 20 жил өнгөрчихөж, энэ ойн дээрээ ардчилсан Ерөнхийлөгчтэй болох том зорилгыг манай нам тавьж байгаа”²⁴ гэснээс тод харагдана.

АН-аас Ерөнхийлөгчийн сонгуульд Ц.Элбэгдорж нэр дэвших боллоо

Дөрөвдүгээр сарын 2-нд Ардчилсан намын Үндэсний зөвлөлдөх хорооны хурал Төрийн ордны их танхимд болсон ба намын дотоод сонгуулиар олонхийн санал авсан Гүйцэтгэх зөвлөлийн шинэ гишүүдийн эрхийг баталгаажуулсан байна. Үүнээс гадна Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг тодруулах эхний шатны буюу Гүйцэтгэх зөвлөл хуралдсан билээ. Гүйцэтгэх зөвлөлийн хурлаас гурав хүртэлх нэр дэвшигчийн нэрийг ҮЗХ-ны хуралд оруулах бөгөөд нэр дэвшигчдийн мөрийн хөтөлбөр, намтартай танилцжээ. Санал хураалтад Р.Гончигдорж өөрийн саналаар оролцоогүй, нэрээ татав. Ингээд санал хураахад Э.Бат-

²⁴ Алтанхуяг.Н: Энэ сонгуульд ялах чин эрмэлзэл Ардчилсан намд бий (ярилцсан З.Оюунбилэг), -ӨС.№075 (2009.03.30)

Үүл, Ц.Элбэгдорж, Г.Батхүү нар Гүйцэтгэх зөвлөлийн олонхийн саналыг авчээ.



Энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд АН, ИЗН, МНН хамтран оролцохоор болсон байна. Өөрөөр хэлбэл, ардчиллыг үнэт зүйл, үзэл баримтлалаа болгодог намууд нэгдсэн хүч, зорилгоор хамтрах болсон юм. Цааш үргэлжилсэн Үндэсний зөвлөлдөх хорооны хурлын үеэр Г.Батхүү нэрээ татсанаар Ц.Элбэгдорж, Э.Бат-Үүлийн хооронд нууц санал хураалт явагдах болжээ. Нийт 219 гишүүн санал хураалтанд оролцсоноос Ц.Элбэгдорж 143, Э.Бат-Үүл 76 хүний санал авснаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн тав дахь удаагийн сонгуульд Ардчилсан намаас Ц.Элбэгдорж нэр дэвших боломжтой болсон билээ. Тэрбээр өөрийн мөрийн хөтөлбөрийг “Шударга ёс тогтоогч Ерөнхийлөгч байна. Орон нутагт эрх олгодог, орон нутгийн эрхийг дэмждэг Ерөнхийлөгч байна. Ард түмэнтэйгээ амь нэг Ерөнхийлөгч байна. Байгаль орчинд ээлтэй бодлого хэрэгжүүлдэг Ерөнхийлөгч байна. Монгол Улсыг дэлхийтэй холбосон Ерөнхийлөгч байна”²⁵ гэж маш товчоор танилцуулжээ.

²⁵ Навч.Д. Элбэгдорж.Ц Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшлээ,-ӨС..№080 (2009.04.04)

АН-ын VI их хурал



Намын дүрмийн дагуу АН-ын Их хурал 878 төлөөлөгчийн бүрэлдэхүүнтэй Төрийн ордны их танхимд хуралдав. Намын дарга Н.Алтанхуяг хурлыг нээж, ҮЗХ-ны шийдвэрийг танилцуулж, МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигч болон мөрийн хөтөлбөрийг нь соёрхон батлах, ардчилсан Ерөнхийлөгчтэй болохыг тулд хамтран, нэгдэн ажиллахыг нийт гишүүддээ уриаллаа.



АН-аас Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчийг батлах нууц санал хураалтаар төлөөлөгчдийн 99,3 хувь нь нэр дэвшигч Ц.Элбэгдоржийн төлөө саналаа өгчээ. Чингэснээр энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд МАХН-аас Н.Энхбаяр, АН-аас Ц. Элбэгдорж нар өрсөлдөх боллоо.

Ийнхүү Ц.Элбэгдорж “Н.Энхбаярыг зарим хүн зөвхөн нэр нэр дэвшигч гэж хараад байна. Энэ бол Монголын нийгэмд бугшсан олон хорт үзэгдлийн биежсэн төлөөлөл”²⁶ гэж мөн оны хоёрдугаар сард мэдэгдсэн, зарласан хүнтэйгээ өрсөлдөх болов. Ийнхүү Ц.Элбэгдорж “Үнэндээ тэр Монголынхоо ядарсан иргэдийн төлөө хуруугаа ч хөдөлгөөгүй. Хөдөлгөсөн бол өөрийгөө л бодож хөдөлгөсөн байх”, “Түүнийг өнөөдрийн хашиж буй албанаас нь сонгуулийн замаар зайлуулах нь Монголын улс төрийн амьдрал дахь хамгийн тулгамдсан асуудал”, “Улс төрийн өндөрлөгт байхдаа заан байдаг, салангуут юу ч биш болдог”, “Энхбаярын их улс төррүү орж ирсэн эхний үе нь ардчилсан засгийн анхны жилийн ойтой давхцадаг. Тэр хүртэл манай улс төр үнэхээр цэвэр, ариун гэгээн байсан юм шиг санагддаг. Тэр үед ардчилал дөнгөж л долоо хүрч нялх хүүхэд шиг дэрвэж байсан. Тэгээд л 1997 оны намраас Монголын нялх ардчилал Энхбаяраар самардуулж, самруулж эхэлсэн. Гурвын гурван засгаараа туг тахиулсан. Зоригоо алуулсан. Гурван гишүүнээ шоронд барьж өгсөн. Үйл явдал болж, тоос намжсаны дараа харахад тэр бүгдээс Энхбаяр, түүний хамсаатнууд хожсон байдаг”, “Н.Энхбаяр бол амжилтаа ч муу аргаар бүтээдэг, алдаагаа ч муу аргаар хаадаг хүн”, “Энхбаяр бол асар аймхай, хүний санаанд оромгүй муу аргатай. Өөрийн хүч гэж түүнд байхгүй. Төрийн институтийг л сар өдрийнхөө хоолныхоо цэс, заримдаа мэс болгож ашиг сонирхлоо гүйцэлдүүлдэг”, “2000-2004 онд Энхбаяр энэ төр улсыг бүр тийрэгдэж дуусгах шахсан. Энхбаяр биднийг засаг барьж байхад байсан төрийн зардлыг хоёр дахин илүү өсгөөд авч ирсэн. Ядуурлыг бол нэг ч хувь бууруулаагүй. Авлигыг бол ярилтгүй. Тарьж ургуулаад, тахал болгож хувиргаад 2004 оны сонгуульруу авчирсан”, “Дээлтэй мангас” гэж мэдэгдсэн, тодорхойлсон хүнтэйгээ өрсөлдөх болов.

Ардчилсан намын дарга Н.Алтанхуягийг дүрмийн бус дарга гэсэн явган яриаг таслан зогсоож, Намын дүрмийн дагуу их хурлаар баталгаажуулах ёстой гэсэн санал бүхий гишүүд цөөнгүй байв.

²⁶ ӨС.№041, 042 (2009.02.16)

Сэлэнгэ аймгийн Хөтөл сумын төлөөлөгч н.Энхтайван Ардчилсан намын ҮЗХ-ны 29 дүгээр хурлаас сонгогдсон Н.Алтанхуяг хууль ёсны намын дарга мөн, эсэх талаар хэлэлцэх тухай санал хураалгахад Их хурлын 878 төлөөлөгчийн 38-аас бусад нь шаардлагагүй гэж үзлээ. Ингэснээр нэг ёсондоо Н.Алтанхуяг АН-ын хууль ёсны дарга гэдгийг АН-ын их хурал нь баталгаажуулав.

Ерөнхийлөгчийн сонгуулийн төв штабыг Н.Алтанхуяг удирдана



2009.04.07-нд Ардчилсан намын “4-11” уулзалт болж, АН-ын дарга Н.Алтанхуяг намынхаа их хурлын талаар сэтгүүлчдэд дэлгэрэнгүй мэдээлэл өглөө. Үдээс хойш нь АН-ын Гүйцэтгэх зөвлөл хуралдаж, Ерөнхийлөгчийн сонгуулийн ажиллагааг гардан удирдах хүмүүсээ томилов. Штабын даргаар намын дарга Н.Алтанхуяг, орлогч дарга болон Сонгуулийн байгууллагуудтай харилцах албаны даргаар УИХ дахь намын бүлгийн дарга Ч.Сайханбилэг, ерөнхий менежер ба Зохион байгуулалтын албаны даргаар намын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Эрдэнэбат, Олон нийт, хэвлэл мэдээлэлтэй харилцах албаны даргаар Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн Д.Дорлигжав, Санхүүгийн албаны даргаар З.Энхболд тус тус томилогдсон байна.

МУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд Ардчилсан намаас нэр

дэвшигч Ц.Элбэгдоржийг дэмжиж ажиллах гэрээнд АН-ын дарга Н.Алтанхуяг, Иргэний Зориг намын дарга С.Оюун, Монголын Ногоон намын дарга Д.Энхбат нар 8-ны өдөр гарын үсэг зурлаа.



Баабар: Элбэгдоржид найдаж байна. Миний сүүлчийн горьдлого

Ардчилсан нам тус сонгуульд нэн хариуцлагатай, эв нэгдэлтэй орсон нь нэг талаасаа түүхэн үүргээ ухамсарласан, нөгөө талаасаа түүхэн хариуцлагаа ухаарсан явдал байв.

Ц.Элбэгдоржтой өрсөлдсөн, УИХ-ын гишүүн Э.Бат-Үүл “Энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгуульд манай нам ялах хэрэгтэй. Элбэгдорж заавал ялах ёстой. Олигархийг дарахаар би Элбэгдоржтой хамт явна”²⁷, “Энэ удаагийн Ерөнхийлөгчийн сонгууль бол төрийн байгууламжийн олигархи дүрсийг халахын төлөө тэмцэл юм. Өөрөөр хэлбэл олигархийг “устгах” ажлын эхлэл. Үүнийг манай намын гишүүд, дэмжигчид, ард иргэд маань тун хариуцлагатайгаар ойлгох хэрэгтэй. Тэгээд Элбэгдоржийг ялуулахын төлөө бид бүгдээрээ алд биеийг алдартал гүйх ёстой. Эс тэгвэл олигархиуд намайг унагаж дөнгөсөн шигээ Элбэгдоржийг бас хийнэ. Элбэгдорж ялах ёстой. Өөр сонголт

²⁷ Бат-Үүл.Э. Бархирмаар санагдсан хором,-ӨС.№082 (2009.04.07)

бидэнд байхгүй ээ!”²⁸ хэмээн удаа дараа сануулж, уриалж, мэдэгдсэн юм.

Түүнчлэн Б.Батбаяр “Одоо тонуулчид нэг талдаа гарч, тоногдогсод нь нөгөө талдаа ялгарч байна. Торны аалзнууд нэг талдаа гарч, торонд орооцолдон баригдаж идэгдэж байгаанууд нь нөгөө талдаа гарчээ. Гэвч идсэн эрүү хувхайрч идүүлсэн дов ногоордог юм шүү! Тэвчээр барагдлаа! Энэ торыг зад татацгаая. Би Элбэгдоржид найдаж байна. Түүнийг би эх орноо эгшин зуур хөгжүүлж шууд л цэнгэлийн манлайд аваачина гэж итгэж байгаа юм биш ээ. Тэр хоёр удаа Ерөнхий сайдаар томилогдсон авч эхнийхэд нь Эрдэнэтийг ухлаа гэж, дараагийнхад нь авлигачдыг илрүүлж эхэллээ гэж аалзнууд нийлж байгаад түлхэн унагасан юм. Тэр одоо аалзнуудаар томилогдох биш ард түмнээр сонгогдоод гараад ирвэл манай нийгмийг боомилон ороосон торноос чөлөөлж өгөх болов уу л гэж горьдож байна. Магадгүй миний сүүлчийн горьдлого”²⁹ гэж бичсэн билээ.

Сонгуулийн сурталчилгааны явцад нэр дэвшигч Ц.Элбэгдоржийг эсрэг гүжир гүтгэлгийг ихээр тарааж байв. Тухайлбал, АН сонгуулийн сурталчилгаандаа 11 тэрбум төгрөг зарж байна, харийн шашны харгис байгууллагаас хандив авсан, хамтран ажиллагсад нь зуурдаар бие бардаг, монгол хүн биш гэх мэт гүтгэлэг цөөнгүй гарч, гаргаж, тарааж байв. Гэсэн хэдий ч монголын ард түмэн, сонгогчид элдвийн гүжир гүтгэлгийг огтхон ч тоогоогүй юм. Энэ нь ч Ц.Элбэгдоржийн сонгуулийн сурталчилгааны хугацаанд эх орноо тойрч сонгогчидтой хийсэн уулзалтаас тод харагдаж байсныг тухайн үеийн хэвлэл мэдээллийн хэрэгслийн шарлаж амжаагүй хуудсууд бүрэн гэрчлэх билээ.

²⁸ Бат-Үүл.Э. Олигархийг устгахын тулд Элбэгдорж ялах ёстой,-ӨС.№084 (2009.04.09)

²⁹ Баабар. Тэвчээр барагдлаа,-ӨС.№116 (2009.05.13)

“АРДЧИЛСАН ЕРӨНХИЙЛӨГЧТЭЙ ӨГЛӨӨНИЙ МЭНД”

2009.05.25



Тавдугаар сарын 24-ний даваа гарагийн өглөөний 06.00 цагийн орчимд Ардчилсан намын дарга Н.Алтанхуяг тэргүүтэй намын удирдлагууд ард түмэндээ хандан ардчилсан Ерөнхийлөгчтэй өглөөний мэндийг дэвшүүлсэн юм. Харин МАХН-аас мөн өдрийн 12 цагт хэвлэлийн хурал зарлаж, нэр дэвшигч Н.Энхбаяр “Сонгуулийн дүн хэдийгээр албан ёсоор зарлагдаагүй ч урьдчилсан дүн мэдээгээр Ерөнхийлөгчид Ардчилсан намаас нэр дэвшигч Ц.Элбэгдорж олонхийн санал авсан гэсэн дүн гарч байна. Би санал хураалтын дүнг хүндэтгэж байгаа гэдгээ юуны өмнө илэрхийлье. Энэ сонгуульд намайг дэмжиж саналаа өгсөн олон мянган сонгогчиддоо баярлалаа” гэж мэдэгдсэн байна. Сонгуулийн урьдчилсан дүнгээр МУ-ын Ерөнхийлөгчид АН-аас нэр дэвшигч Ц.Элбэгдорж улсын хэмжээнд 51,24 хувийн санал авч ялалт байгуулсан байна. Улсын хэмжээнд 1097738 сонгогч санал өгсөн нь нийт сонгогчдын 73,52 хувь байсан нь харьцангуй өндөрт тооцогдож байв. 2009 оны сонгууль 73,59 хувийн ирцтэй байлаа. УИХ-ын зургадугаар сарын дөрөвний чуулганаар Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

хуулийн төсөл болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх тов тогтоох асуудлыг хэлэлцжээ. Төрийн байгуулалтын байнгын хороо дүгнэлтээ танилцуулснаар шинэ Ерөнхийлөгчийг 6-р сарын 18-ны өдөр тангараг өргүүлэн, бүрэн эрхийг нь баталгаажуулах санал дэмжигджээ. Товлосон өдрийн 12 цаг 06 минутанд Монгол Улсын тав дахь Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдорж тангараг өргөн, бүрэн эрх нь хэрэгжиж эхэлсэн билээ. Энэ бол зөвхөн Ц.Элбэгдоржийн биш, зөвхөн Ардчилсан намын биш, монголын ардчиллын ялалт байсан билээ.

ОЮУ ТОЛГОЙН ГЭРЭЭ



Монгол Улсын язгуур эрх ашиг, эдийн засгийн хөгжилтэй шууд холбогдох Оюу толгойн төслийн гэрээнд ахиц гарч эхлэв. Тодруулбал, долдугаар сарын 6-нд УИХ дахь Ардчилсан намын бүлэг хуралдаж Засгийн газраас санал болгосон 34 хувийг Монголын төр эзэмших эсвэл бүх төрлийн татварыг зуун хувь авах гэсэн хоёр хувилбараас эхнийхийг нь дэмжихээр шийдвэр гаргасан байна. Улмаар Оюу толгойн гэрээнд гарын үсэг зурж батлах эрхийг Засгийн газарт өгөх нь зүйтэй гэж тогтжээ. Энэхүү гэрээг байгуулснаар Монгол Улс тус ордын 34 хувийг эзэмших ба 1,7 тэрбум ам.долларын хөрөнгө оруулах юм. Эрдэс баялаг, эрчим хүчний яамны дэргэдэх Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр Оюу толгойн ордын нөөцийг (тухайн үеийн төвшин)

2,7 тэрбум тонн хүдэр, 25,4 сая тонн зэс, 1028 тонн алт, 5144 тонн мөнгө гэж бүртгэсэн байдаг билээ.

УИХ-ын 7-р сарын 17-ны өдрийн нэгдсэн чуулганаар Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулах эрхийг Засгийн газарт олгосон юм. Энэ эрхийг дөрвөн заалт бүхий УИХ-ын тогтоолоор баталсан билээ: УИХ-ын тогтоолд:

1. Оюу толгойн ордын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хувьцааны төрийн эзэмших доод хэмжээг 34 хувиар тогтоосугай.
2. Оюу толгойн ордыг ашиглахтай холбогдуулан хөрөнгө оруулалтын гэрээг Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж болох Улсын Их Хурлын 40 дүгээр тогтоолоор батлагдсан үндсэн зарчим, удирдамж, Эдийн засгийн байнгын хорооны 2009 оны тавдугаар сарын 8-ны өдрийн санал дүгнэлтэд тус тус нийцүүлэн байгуулахыг Засгийн газарт зөвшөөрсүгэй.
3. Эрх зүйн орчныг бүрдүүлэх замаар анхны хөрөнгө оруулалтыг нөхсөний дараа төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг 50-иас доошгүй хувьд хүргэж нэмэгдүүлэх асуудлыг хөрөнгө оруулагчтай тохиролцон шийдвэрлэхийг Засгийн газарт үүрэг болгосугай.
4. Энэ тогтоолын биелэлтэл хяналт тавьж ажиллахыг Эдийн засгийн байнгын хороонд даалгасугай.

Оюу толгойн асуудлаар олон судлаач, төр нийгмийн олон зүтгэлтэн байр сууриа илэрхийлсэн байна. Тухайлбал, Монгол Улсын Ерөнхий сайд асан Д.Бямбасүрэн “Манай тал 1,7 тэрбум ам.долларыг өндөр хүүтэй зээлж өрөнд орж хувь эзэмших гээд, ашгийн зөвхөн 30 хувийг хүртэх гээд илүү сэтгэхгүй эргэлдээд байгаа нь дэндүү харалган алхам. Энэ төрд эдийн засгийн тооцоо хийдэг хүмүүс баймаар л юм. 1,7 тэрбум ам.долларын жилийн хүү нь 12 орчим болох юм байна лээ. Өөрийнхөө баялгийг хүнд ашиглуулаад авах ашгаасаа хүнд мөнгө төлөх гээд байгааг мулгуу гэхээс өөр юу хэлэх вэ”³⁰ гэсэн байдаг билээ.

УИХ-ын ээлжит бус чуулган наймдугаар сарын 19-нд нээлтээ хийсэн ба чуулганаар хэлэлцэх гол асуудал нь Оюу толгойг ашиглахтай холбогдуулан УИХ-ын 57 дугаар тогтоолоор Засгийн

³⁰ Бямбасүрэн.Д: Засгийн газарт эдийн засгийн бодлого алга (ярилцсан Д.Доржпагма), -ӨС.№189 (2009.08.06)

газарт даалгасан гэрээг хуульд нийцүүлэх асуудлыг хэлэлцэх байв.

Асуудал дагуулсан 68%

Оюу толгойн олборлолт, ашиглалтын гэрээний гол гацаа нь гэнэтийн ашгийн 68 хувийн татвар байлаа. Хөрөнгө оруулагч тал татварын нөхцөл, орчныг бүрэн зөвшөөрч, хөнгөлөлт шаардаагүй хэдий ч 68 хувийн татварыг хүлээн зөвшөөрч чадахгүй байсан билээ. Монгол Улсын Ерөнхий сайд асан Д.Содном “Ашгийн хувьд нэг хэсэг хугацаанд жаахан мөнгө хуримтлуулсан байх. Гол хуримтлалыг “Эрдэнэт”-ээс авсан. Хор хөнөөл гэвэл үүнээс болж гадны хөрөнгө оруулагчидтай гэрээ байгуулахад хүндрэлтэй болсон. Дотоодын компаниуд үүнийг эсэргүүцээд ил явж байх бизнес далд болсон”³¹ гэж 68 хувийн татварын эерэг, сөрөг талыг дүгнэжээ. Харин нийтлэлч Б.Батбаяр “Алдарт 68 хувийн татвар бол үнэндээ улсаа баяжуулах гэсэндээ биш Монголд гадаадын хөрөнгө оруулалтыг мухарлах гэсэн хэн нэг “сонирхогчийн” захиалгат тоглоом юм. 950 тэрбум төгрөг шинээр орсон юм шиг ярьдаг. Нэг талаас алтны бизнесийг гэмт хэргийн тогтолцоо болгож хуучин авдаг байсан татварыг нь үгүй болгож орхисон, нөгөө талаас Эрдэнэт хэмээх ганц саалийн үнээг маань нүдийг нь аниулсан. Тэртэй тэргүй 68 хувийн татваргүйгээр ердийн 25 хувийн татвар, ногдол ашгаараа Эрдэнэт энэ хооронд 600 тэрбум төгрөг өгөх байжээ”³² гэсэн бол Монголбанкны дэд ерөнхийлөгч Б.Энххуяг “Монголбанкинд тушаасан бохир алтны хэмжээ 2005 онд хамгийн их буюу 15.2 тонн байсан. 2006 онд 68 хувийн татвар авах болсноор энэ тоо 6.9 тонн болж буурсан. 2007 онд 10.5 тонн, 2008 оны эхний улирлын байдлаар 0.7 тонн бохир алтыг манайд тушаасан байна. Алт тушаагч аж ахуйн нэгжүүдийн тоо 2006 онд 133, 2007 онд 120, 2008 оны эхний улиралд 13 болжээ”³³ гэсэн байдаг. Үнэндээ ч Монголын төр өөрийн мэдлийн “Эрдэнэт” үйлдвэрээс 68 хувийн өндөр татварыг авч чадаж байсан бол бусад орд газрын ашиглалтаас бараг авч

³¹ Содном.Д: Арай эрт төрчихсөндөө жаахан харамсдаг (ярилцсан З.Оюунбилэг), -ӨС.№204 (2009.08.24)

³² Баабар. Татвар төлөгч бидний биесээ хөө., -ӨС.№224 (2009.09.16)

³³ Туул.С. Монголбанкинд тушаасан алтны хэмжээ тав орчим тонноор буурчээ, -Ө.№094 (2008.04.23)

чадаагүй, хувийн хэвшил болоод гадны хөрөнгө оруулалтыг цааш түлхсэн, эдийн засгийн далд тогтолцоог цэцэглүүлсэн, гэмт хэргийг гааруулсан гээд эерэгээсээ илүү сөрөг үр дагавар авчирсан билээ.

Гэрээг үзэглэв



Хэлэлцээр, уулзалт үргэлжилсээр эцсийн бүлэгт шийдэлд хүрлээ. “Хөрөнгө оруулалт, урьдчилгаа төлбөр болох 250 саяам. долларын, мөн хувь нийлүүлэгчдийн гэрээнд манай талаас Сангийн сайд С.Баярцогт, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүх, хөрөнгө оруулагч талаас “Рио Тинто”-гийн Зэс, очир эрдэнийн бүлгийн ерөнхий захирал Брейт Клейтон, “Айвенхоу майнз Монголиа Инк” ХХК-ийн ерөнхий захирал Кийт Маршал, “Айвенхоу майнз лимитид” компанийн ТУЗ-ийн дэд дарга Питер Мередит нар гарын үсэг зурна. Харин хувь нийлүүлэгчдийн гэрээнд Монголын талыг төлөөлж, “Эрдэнэс MGL” ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Энэбиш, хөрөнгө оруулагчдыг төлөөлөн “Айвенхоу Оюу толгой (Би Ви Ай) лимитед” компанийн эрх зүйн асуудал хариуцсан гүйцэтгэх дэд ерөнхийлөгч Жон Фоннани, “Оюу толгой Нидерланд Би Ви” компанийн ТУЗ-ийн дэд дарга Питер Мередит, “Айвенхоу майнз Монголиа инк” ХХК-ийн ерөнхий захирал Кийт Маршал нар, урьдчилгаа төлбөрийн гэрээнд Сангийн сайд С.Баярцогт, “Айвенхоу майнз Монголиа инк” ХХК-ийн ерөнхий захирал

Кийт Маршал нар гарын үсэг зурах юм байна. Гэрээнд гарын үсэг зурах ёслолд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, УИХ-ын дарга Д.Дэмбэрэл, Ерөнхий сайд С.Баяр болон УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүүд, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөл оролцох ажээ”³⁴. Ингэснээр ямартаа ч Оюу толгойн гэрээ байгуулагдаж, томоохон ордыг ашиглах, олборлох, эдийн засгийн эргэлтэнд оруулах нөхцөл бүрдсэн билээ. Гэсэн хэдий ч зургаан жил хэлэлцэж байж гарын үсэг зурагдан баталгаажсан тус гэрээ, хэрүүл тэмцлийн талбар, дүр эсгэгчдийн тодордог боломж, хэн бүхний мэддэг ч мэддэггүй сэдэв болсоор мөн л хэдэн зургаан жил элээсэн бөгөөд элээх учиртай байв аа. Үүний нэгэн шалтгаан нь Монгол Улсын хэмжээнд 1993 оноос хойш хориодхон жилийн хугацаанд ашигт малтмалын хайгуулын 15 мянга орчим зөвшөөрөл өгсөн нь нийт газар нутгийн 46 хүрсэн байв. Харин энэ хориод жилийн дөрөвхөн жил л АН засгийн эрхийг хагас дутуу барьсан боловч ачааны хүндийг, аашлуулах, баалуулахын ихийг үүрч байжээ.

Эдийн засгийн байдал хүндэрсэн, эдийн засгийг эрчимжүүлэх, мөнгөний зузаатгал хийх, инфляцийг хязгаарлах шаардлагатай үед Оюу толгой л аминд орж байв. Тухайлбал, Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээг баталснаас хойш, хөрөнгө оруулагчаас 250 сая ам.долларын урьдчилгаа төлбөрийг үе шаттайгаар авахаар тохиролцсон, авсан байдаг. Басхүү, “Оюу толгой” ХХК-ийн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, албан татварын тодорхой хэсгийг урьдчилан авах гэрээ байгуулж 160 сая ам.доллар авчээ. Үүнээс гадна шууд ба шууд бус хөрөнгө оруулалт, үр дүн, үр ашгийг тооцох аргагүй байлаа.

Сангийн сайд С.Баярцогт 2011 онд “Хөрөнгө оруулагч талтай Засгийн газархоёртөрлийн гэрээ байгуулсан. Хувь нийлүүлэгчдийн болон Хөрөнгө оруулалтын гэсэн. Хувь нийлүүлэгчдийн гэрээнд өөрчлөлт оруулахаар бүтэн жил шахуу хэлэлцээр хийсэн. Түүний үр дүнд нэлээд өөрчлөлт оруулсан юм. Хүмүүст ойлгомжгүй байсан зүйлийг тодорхой болгосон. Тодруулж хэлбэл, Монголд ашиг авчрах заалтуудыг нэмж тусгасан байгаа. Дор хаяж нэг тэрбум ам.долларын ашгийг авчирсан өөрчлөлт оруулсан. Хөрөнгө оруулагч өөрийнхөө талын хувьцааг гадаадын төрийн оролцоотой компанид худалдахаар бол Монголын Засгийн газрын зөвшөөрлийг бичгээр авна гэсэн нэмэлт заалт

³⁴ Билэгт.О. Оюу толгойн гэрээг өнөөдөр үзэглэнэ, -ӨС.№241 (2009.10.06)

оруулсан”³⁵ гэж УИХ-ын 2009 онд баталсан 57 дугаар тогтоолын дагуу оруулсан буюу оруулах нэмэлт, өөрчлөлтийг тайлбарлан таниулжээ.

УИХ-ЫН НӨХӨН СОНГУУЛЬ БОЛОВ

2008 оны УИХ-ын ээлжит сонгуулиар 24 дүгээр тойрог буюу Нийслэлийн Чингэлтэй дүүргээс Ц.Элбэгдорж сонгогдож байв. Харин Ц.Элбэгдорж Монгол Улсын Ерөнхийлөгчийн тав дахь удаагийн сонгуульд Ардчилсан намаас нэр дэвшин ялалт байгуулсны маргаашнаас эхлэн нөхөн сонгуулийн таамаг хөвөрч эхэлсэн билээ.

2009 оны есдүгээр сарын 4-нд Ардчилсан намын “4-11” арга хэмжээ болж сэтгүүлчдэд мэдээлэл хийх үеэр намын дарга Н.Алтанхуяг “Ирэх аравдугаар сарын 18-ны өдөр Чингэлтэй дүүрэгт УИХ-ын нөхөн сонгууль болно. Энэ нөхөн сонгуульд манай нийслэлийн намын байгууллага, Хэрэг эрхлэх газраас тодорхой хэмжээгээр бэлтгэж байна. Нөхөн сонгуульд хэн нэр дэвших вэ гэдгийг хүмүүс асууж сонирхож байгаа юм билээ. Одоогоор яригдаж байгаа дөрвөн хүний нэрийг хэлье. 2008 оны УИХ-ын сонгуульд Чингэлтэй дүүрэгт нэр дэвшсэн Р.Бурмаа, 2008 онд Баянгол дүүрэгт нэр дэвшсэн, одоо Чингэлтэй дүүргийн намын даргаар ажиллаж байгаа Б.Батбаатар, Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Эрдэнэбат, Нийслэлийн Засаг даргын орлогчоор ажиллаж буй Да.Ганболд нарын нэр яригдаж байгаа. Гэхдээ дүүргийн намын байгууллага болон ҮЗХ-ны хурлаар сонгон шалгаруулдаг журмынхаа дагуу нэр дэвшигчээ тодруулна”³⁶ гэсэн байна.

СЕХ-нд нөхөн сонгуульд оролцохоо илэрхийлж есөн нам материалаа ирүүлснээс АН, МАХН, МУНН, ИЗН, Эрх чөлөөг хэрэгжүүлэгч намыг бүртгэж, хуулийн шалгуур, болзлыг хангасан гэдэг үүднээс нөхөн сонгуульд оролцуулах тогтоолыг гаргажээ. Есдүгээр сарын 25-нд хуралдсан АН-ын ҮЗХ-ны хурлаар Р.Бурмааг нэр дэшлүүлэхээр шийджээ. Өмнө нь нэр дэвших

³⁵ Баярцогт.С: Оюу толгойн хөрөнгө оруулалтын гэрээнд өөрчлөлт оруулахаар хэлэлцээрээ эхлүүлнэ ээ (ярилцсан Д.Доржпагма), -ӨС.№225 (2011.09.20)

³⁶ Навчаа.Д. Алтанхуяг.Н: Нөхөн сонгуульд Д.Эрдэнэбат, Р.Бурмаа, Б.Батбаатар, Да.Ганболд нарын нэр яригдаж байгаа, -ӨС.№214 (2009.09.04)

тухай яригдаж байсан АН-ын ЕНБД Д.Эрдэнэбат, Нийслэлийн Засаг даргын орлогч Да.Ганболд нар одоогийн хийж байгаа ажлынхаа үр дүнг үзэх сонирхолтой гэсэн шалтгаанаар нөхөн сонгуульд нэр дэвшихээс татгалзсан бол Чингэлтэй дүүргийн АН-ын дарга Б.Батбаатар өөрийн хүсэлтээр нэрээ татсан байна. Ингэснээр Чингэлтэй дүүргийн АН-ын хороо хуралдан Р.Бурмааг 99,04 хувийн саналаар УИХ-ын 24 дүгээр тойрогт нэр дэвшүүлэх шийдвэр гаргасныг ҮЗХ дэмжжээ. Энэ удаагийн нөхөн сонгуульд МНН, ИЗН түүнийг дэмжин, нэгдсэн байдлаар сонгуульд оролцох болов. Харин МАХН-аас намын анхан шатны байгууллагаасаа дэмжлэг авч чадаагүй Д.Зоригтын нэрийг дэвшүүлсэн билээ.

УИХ-ын нөхөн сонгуулийн дүн

1. Д.Зоригт (МАХН) 26592 санал буюу 60.37 хувь
2. Р.Бурмаа (АН) 13027 санал буюу 29.57 хувь
3. Г.Уянга (бие даагч) 2010 санал буюу 4.56 хувь
4. С.Жавхлан (бие даагч) 1690 санал буюу 3.84 хувь
5. Г.Арслан (бие даагч) 300 санал буюу 0.68 хувь
6. Д.Төмөрбаатар (бие даагч) 159 санал буюу 0.36 хувь
7. Ш.Төмөрсүх (Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам) 124 санал буюу 0.28 хувь
8. Л.Жаргалсайхан (МУНН) 114 санал буюу 0.26 хувь

II. Тойргийн хэмжээнд санал хураалтын дүнг нэгтгэн гаргахад сонгогчдын нэрийн жагсаалтад бүртгэгдсэн 71742 сонгогчоос 44563 сонгогч буюу 62,12 хувь нь санал хураалтад оролцсон тул санал хураалтыг хүчинтэйд тооцсугай.

Д.Зоригтын ялалт нь Эрдэс баялаг, эрчим хүчний сайдын хувиар Оюу толгойн гэрээг урагшлуулсанд оршиж байсан бол Ардчилсан намын ялагдал нь Да.Ганболд, Д.Эрдэнэбат нарын хүчтэй нэр дэвшигчдийг бодвол харьцангуй сул өрсөлдөгчийг нэр дэвшүүлсэнд оршиж байв.

2009 оны аравдугаар сарын 23-ны УИХ-ын хуралдаан дээр Д.Зоригт тангараг өргөж, бүрэн эрх нь баталгаажсан билээ. Чингэснээр 2008 оны сонгуулиар шинээр бүрдсэн УИХ анх удаагаа, бас арай гэж л бүрэн бүрэлдэхүүнээрээ үйл ажиллагаагаа хэрэгжүүлэх бололцоотой болжээ.



С.БАЯР АЖЛААС ЧӨЛӨӨЛӨГДӨХ ХҮСЭЛТ ГАРГАВ БУЮУ ӨГӨВ, АВАВ

МАХН-ын Удирдах зөвлөлийн хурлаар Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр эрүүл мэндийн шалтгааны улмаас ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргасныг хэлэлцсэн талаар МАХН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга У.Хүрэлсүх 2009 оны аравдугаар сарын 26-нд мэдэгдлээ. Тэрбээр “Намын Удирдах зөвлөлийн хурал болж, МАХН-ын Бага хурлыг зарлан хуралдуулах шийдвэр гаргаж байна. Мөн Монгол Улсын Ерөнхий сайд С.Баяр эрүүл мэндийн шалтгаанаар үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх асуудлаа албан ёсоор танилцуулсан. Одоо УИХ хуралдах асуудал л хүлээгдэж байна” гэж³⁷ мэдэгдсэн юм. Ийнхүү Атрын III аяныг амжилттай хэрэгжүүлж, эх орныхоо улаан буудайн хэрэгцээний наян хувийг дотоодоосоо хангадаг болгосон, бүртгэлийн тогтолцоог шинэчлэн, сайжруулсан, Оюу толгойн гэрээг батлуулсан, МАХН-ыг удирдан зохион байгуулж УИХ-ын ээлжит сонгуульд ялалт байгуулсан, хамтарсан Засгийн газар байгуулж эв нэгдлийг сахин хамгаалж, бэхжүүлсэн, хоёр Засгийн газар дараалан удирдсан С.Баяр ажлаа өгөх боллоо.

Огцрох асуудлаас өөр

Хамтарсан Засгийн газрын тэргүүн эрүүл мэндийн улмаас чөлөөлөгдөх өргөдлөө өгсөн тохиолдолд танхимаараа огцорч, өөрчлөгдөнө, тэр ч бүү хэл АН-ын зүгээс хамтрах эсэх асуудал ч яригдаж магадгүй гэсэн яриа гарсантай холбогдуулан УИХ дахь АН-ын бүлгийн дарга Ч.Сайханбилэг мэдээлэл хийсэн байдаг. Тэрбээр, “УИХ дахь АН-ын бүлгийн хуралдааны үеэр манай намын дарга, МУ-ын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг хаалттай мэдээлэл хийсэн. Ерөнхий сайд С.Баяр МАХН-аас сонгогдсон тул намынхаа дүрэм журмын дагуу энэ асуудлыг хэлэлцээд явах байх. Ингэхэд Ерөнхий сайдын албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтийг өөрөө гаргаад байгаа бол түүний орны хүнийг томилоод явах асуудал яригдана. Үүнийг хуулиар заагаад өгчихсөн байгаа. Энэ чинь огцрох асуудлаас огт өөр зүйл шүү

³⁷ Навчаа.Д, Мөнгөнцэцэг.Я, Доржпагма.Д. Баяр.С Ерөнхий сайдын ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт гаргалаа, -ӨС.№259 (2009.10.27)

дээ. Ингэсэн тохиолдолд асуудлыг УИХ 30 хоногийн дотор шийдвэрлэх, тэр болтол Тэргүүн шадар сайд орлох хуультай юм” гэв.

Өгөв, авав



УИХ-ын аравдугаар сарын 28-нд хуралдсан нэгдсэн хуралдаанаар Ерөнхий сайд С.Баяр албан тушаалаас чөлөөлөгдөх хүсэлтээ илэрхийлж хэлсэн үгэндээ “Өнөөдөр би Ерөнхий сайдын албаа өгч байна. Эзний алба ээлжтэй гэдэг эцэг дээдсийн сургаалыг санан, өндөр албанаас бууж байгаадаа харамсах юм алга гэдгээ хэлье. Харин төлөвлөсөн ажлынхаа дийлэнхийг нь хийж амжилгүй явж буйдаа харамсч байна”³⁸ гэсэн юм. Мөн өдрөө МАХН-ын Х Бага хурал хуралдлаа. Тус хурлаар Ерөнхий сайд С.Баяр эрүүл мэндийн шалтгаанаар албан үүргээсээ чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан учир орны хүнийг нь сонгох асуудлыг хэлэлцэв. Ерөнхий сайдад нэр дэвших хүний нэрийг МАХН-ын дарга С.Баяр танилцуулсан юм. “С.Баяр Ерөнхий сайдын ажлыг өгсөнтэй холбогдуулан түүний орны хүнийг томилох асуудлыг МАХН-ын Удирдах зөвлөл Бага хурлынхаа өмнөхөн хэлэлцжээ. С.Баярын санал нь Сү.Батболд байсан бол Ц.Нямдорж

³⁸ Навчаа.Д. УИХ С.Баярыг Ерөнхий сайдын албан тушаалаас нь чөлөөллөө, - ӨС.№261 (2009.10.29)

өөрөө нэрээ дэвшүүлэв. Ц.Нямдорж Удирдах зөвлөлийн гишүүдээс гурван хүний л дэмжлэгийг авч чадсан байна”³⁹. МАХН-ын Бага хурлын 180 гишүүний 179 хүний дэмжлэгээр Сү.Батболдын нэрийг Ерөнхий сайдад нэр дэвшүүлэхээр тогтож, Ерөнхийлөгч, УИХ-д өргөн мэдүүлэхээр тогтлоо. Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг нэг хоног Ерөнхий сайдын үүрэг гүйцэтгэгчээр ажилласны дараа буюу 29-нд УИХ-ын гишүүн Гадаад харилцааны сайд Сүхбаатарын Батболд МУ-ын 26 дахь Ерөнхий сайдаар томилогдов.

Тэрбээр цаашид хийх ажлынхаа тухай тодорхойлохдоо, “Хамтарсан Засгийн газрыг одоо байгаа бүтэц бүрэлдэхүүнээр нь ажиллуулж, Монгол хүн бүрт хөгжлийг нь тэтгэсэн, ижил тэгш боломжийг төрөөс олгож, иргэн бүрээ чадавхижуулж, боловсролтой, эрүүл чийрэг, дэлхийн хэмжээнд өрсөлдөх чадвартай “Монгол хүн”-ийг төлөвшүүлэх нөхцөлийг бүрдүүлж, улмаар нийгмийн дундаж давхарга өргөжих бодит хөрс суурийг тавихын төлөө чармайн ажиллах болно” гэлээ. Үүнийхээ дараа тэрбээр Тэргүүн Шадар сайд Н.Алтанхуягаас Засгийн газрын тамгыг гардаж авав.

Бүтэц, бүрэлдэхүүнээ хадгалж үлдэхээр тогтлоо

АН-ын Гүйцэтгэх зөвлөл Төрийн ордон дахь Тэргүүн шадар сайдын өрөөнд хуралдлаа. Тэд МАХН дангаараа Засгийн газраа байгуулахгүй гэдэг нь нэгэнт тодорхой болсон үед АН ямар алхам хийх вэ гэдгээ нухацтай ярилцсан байна. Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, МАХН-ын зүгээс Сангийн яамныхаа сайдын суудлыг өгөөд Гадаад харилцааны яамны сайдын суудлыг авах уу. Ерөөсөө хамтарсан Засгийн газарт жаахан өөрчлөлт оруулбал яасан юм бэ гэсэн санал тавьж байгааг Гүйцэтгэх зөвлөлийнхөө гишүүдэд уламжиллаа. Ингээд хэлэлцсэний эцэст Ардчилсан нам энэ Засгийн газарт байгаа одоогийн бүтэц бүрэлдэхүүнээ хадгалж үлдэхээр тогтлоо.

³⁹ Далай.Д. Удирдах зөвлөл Сү.Батболдыг Ерөнхий сайдад санал болгов,-
ӨС.№261 (2009.10.29)

Н.Алтанхуяг: Аль болохоор зовлон тоочихгүйг хичээж байгаа

Шинээр томилогдсон Ерөнхий сайд Сү.Батболдын хамтарсан Засгийн газрын танхимын гишүүдийг баталгаажуулах УИХ-ын хуралдаан (2009.11.13) боллоо. МУ-ын тэргүүн шадар сайд Н.Алтанхуягийн ээлж ирэхэд УИХ-ын гишүүн С.Бямбацогт, “Ардчилсан нам Засгийн газраас хөөсөн ч гарахгүй юм аа” гэсэн нь гишүүдийг талцуулав. АН-ын Г.Баярсайхан гишүүн “За болиорой та нар. Гуйж, гуйж оруулчихаад одоо ингэж ярьдаг болсон уу. Гарна гэвэл гарна шүү” гэв. Маргаан ширүүсэх үед Н.Алтанхуяг тайвшруулж, “Хамтарсан Засгийн газарт зовлон бий. Нэгэнт хамтарсан юм чинь гээд аль болохоор болгохын төлөө л явж байна. Биднийг ямар нэг зовлон тоочихоор битгий гоншигноод бай гэдэг учир аль болохоор зовлон тоочихгүйг хичээж байгаа” гэхүйд Д.Тэрбишдагва гишүүн “Хэнийг гоншигносон гээд байгаа юм” хэмээн мөчөөрхөв. Н.Алтанхуяг, “Өөрийгөө хэлж байна аа” гэснээр уур амьсгалыг бүрэн намжаав. УИХ-ын хуралдаанаар АН-ын дарга Н.Алтанхуяг 94.4 хувийн санал авч, Тэргүүн шадар сайдаараа батлагдав. Харин Засгийн газарт бага зэргийн өөрчлөлт орж, Гадаад харилцааны сайдаар Г.Занданшатар, ЗГХЭГ-ын даргаар Ч.Хүрэлбаатар нар МАХН-аас сонгогдлоо.

20 ЖИЛИЙН ОЙГООРОО “АРДЧИЛСАН ХУВЬСГАЛ” БОЛОВ

2009 онд Монгол оронд ардчилал, хүний эрх, эрх чөлөө, шударга ёсыг хүлээн зөвшөөрч, эрх зүйт төр, зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжих үндэс суурийг тавих улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны, үнэт зүйлийн шилжилт хийсэн их үйл өрнөж, бодитойгоор хэрэгжиж эхэлсний хорин жилийн ойг Монголын төр, улс төрийн намууд, иргэний нийгмийн байгууллагууд, ард түмэн тэмдэглэн өнгөрүүлэх болсон нь Ардчилсан хувьсгалын түүхэн үнэ цэнийг өргөсөн, хүлээн зөвшөөрсөн хэрэг болжээ.

Энэ хамтарсан засгийн үед Монголын нийгэмд Ардчилсан хувьсгал гэсэн нэр томъёог анх хүлээн зөвшөөрч хэрэглэж эхэлсэн юм. Өмнө нь ач холбогдлыг нь бууруулж ардчилсан



хөдөлгөөн төдий ярьдаг байлаа. Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн баярын нээлтийн ажиллагаа арванхоёрдугаар сарын 10-нд Төрийн ордны Их танхимд болж, Ардчилсан намын дарга, Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, МАХН-ын дарга, Ерөнхий сайд Сү.Батболд нар илтгэл тавилаа. Сү.Батболд 1990 оны ардчиллын төлөөх тэмцэл нь хувьсгал байсан гэснээр “Ардчилсан хөдөлгөөн”, үгүй “Ардчилсан хувьсгал” байсан гэх хүмүүсийн мэтгэлцээнд цэг тавьсан гэж хэлж болно.

Ардчилсан хувьсгалын баярыг тэмдэглэн өнгөрөөх ажлын хүрээнд арванхоёрдугаар сарын 10-нд УИХ-ын хүндэтгэлийн чуулган хуралдсан юм. Хүндэтгэлийн чуулганд Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, Ерөнхий сайд С.Батболд, Засгийн газрын гишүүд, төрийн агентлаг, газрын дарга нар, манай улсад суугаа Элчин сайд болон консулууд оролцсон билээ.

Түүхэн ойг тохиолдуулан Э.Бат-Үүлийг Монгол Улсын Баатар цолоор шагнасан байна. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж, “Ардчилсан хувьсгал бол баатартай. Тэр баатар нь Монголын ард түмэн. Манай ард түмний Ардчилсан хувьсгалд оруулсан гавьяат үйлс, түүхэн тэмцэл зүтгэлийг хамгийн сайн төлөөлж чадах хүн Э.Бат-Үүл юм. Э.Бат-Үүлдээ баяр хүргэе. Баатартаа баяр хүргэе” гэв. Харин Э.Бат-Үүл, “Уг нь энэ шагнал МоАХ, түүний зохицуулагч С.Зориг, анх ухуулах хуудас нааж, ард түмнээ “Хонх”-ны дуугаар

сэрээсэн С.Цогтсайхан нарт очих ёстой байлаа. МоАХ-ны анхны цуглаан дээр ирсэн 300 гаруй хүн бүгд баатрууд шүү” гэлээ.

НАМЫН ДОТОР “ХОЛБОО” БАЙГУУЛАГДАВ.



АН-ын хэсэг гишүүд “Ардчилсан хүчний холбоо” гэсэн нэртэй төрийн бус байгууллага байгуулсанаа 2010 оны нэгдүгээр сарын 25-нд албан ёсоор хэвлэлийн хурал хийн зарлалаа. Тухайлбал, УИХ-ын гишүүн З.Энхболд Д.Ганхуяг, С.Эрдэнэ, Г.Баярсайхан болон Ерөнхийлөгчийн зөвлөх Ц.Оюунгэрэл нар мэдээлэл хийсэн байна. Холбооныхоо анхны хурлыг тухайн өдөр Чингис зочид буудалд, 92 үүсгэн байгуулагчийн бүрэлдэхүүнтэйгээр хийсэн тухайгаа, түүнчлэн “Монголоо шинэчилье” гэсэн зорилготойгоо зарлав.

Мөн Ерөнхийлөгчөөр нь УИХ-ын гишүүн З.Энхболд сонгогдсоноос гадна зургаан дэд ерөнхийлөгтэй байхаар тогтсон тухайгаа, тэдгээрийн үүргийг ч тодотгов. Тухайлбал, дэд ерөнхийлөгч УИХ-ын гишүүн Н.Батбаяр Монгол улсын хөгжил шинэтгэлийн бодлого, дэд ерөнхийлөгч УИХ-ын гишүүн Р.Амаржаргал Ардчилал Шударга ёс шинэтгэлийн бодлого, дэд ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн С.Эрдэнэ Дотоод зохион байгуулалт, дэд ерөнхийлөгч УИХ-ын гишүүн Д.Ганхуяг Эдийн засаг, гадаад бодлого, дэд ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн Г.Баярсайхан

Залуучууд, байгаль орчин, аялал жуулчлал, дэд ерөнхийлөгч, УИХ-ын гишүүн Д.Одхүү Сургалт, сурталчилгаа, нийгмийн бодлогоыг тус тус хариуцахаар болсон байна. Тус ТББ-ын чуулган нь 108 хүнтэй байх бол өдөр тутмын үйл ажиллагааг явуулах 30 хүний бүрэлдэхүүнтэй ерөнхий зөвлөл ажиллах ажээ.

УИХ-ын гишүүн З.Энхболд хэлэхдээ, “Өнөөдөр ардчилсан үзэл бодолтой хүмүүсийг үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхах явдал их боллоо. Саяхан Өвөрхангай аймгийн Төгрөг сумын нэгэн удирдах ажилтныг АН-ын гишүүн байсан гэдгээр нь ялгаварлан халсан.Тэр энэ асуудлаараа Ардчилсан намд хандан өмгөөлөл эрсэн боловч нэгэнт төрийн албан хаагч болж намаас гарсан тул туслах боломжгүй хэмээн буцаасан байгаа. Энэ маягаар Ардчилсан намын хийж чадахгүй байгаа зүйлийг хийхийн тулд энэхүү байгууллагыг байгууллаа. Ийм хэлбэрээр л төрийн албанд орсон ч ардчилсан үзэл бодлоороо ялгаварлагдаад хохирсон иргэдийн ашиг сонирхлыг хамгаалахаас өөр арга алга” гэв. Мөн Ардчилсан хүчний холбоо нь ардчилсан үзэл бодолтой иргэдийн дотор 10-аас дээш гишүүнтэй сонирхлын бүлгүүдийг бий болгон ажиллуулж, тэдгээр нь орон нутгийн салбар холбоодоороо дамжуулан өнөөгийн нийгэмд шинэчлэл хийх боломжийг иргэн бүрт хүргэнэ гэдгээ зарласан юм.

Э.Бат-Үүл: Ардчилсан хүчний холбоо чинь МАХН-ын захиалгаар явж байгаа урвагч нар юм биш үү



Ийнхүү Ардчилсан хүчний холбоо байгуулагдаж байх үед УИХ-ын гишүүн Э.Бат-Үүл, "...Сонгуулийн өмнө намыг маань хоёр хуваачихлаа шүү дээ. Сонгуулиар тус тусдаа сонгуулийн штабтай оролцоно. Хоорондоо өрсөлдөнө. Харахад нэг нам. Хэрэг дээрээ сонгуульд хоёр нам шиг л оролцох нь. Тэгээд л дуусна. Би ойлгохдоо МАХН-ын захиалгаар явж байгаа урвагч нар юм биш үү гэж бодож байна..." гэсэн байдаг.

АРДЧИЛСАН НАМЫН ҮЗХ-НЫ РОТАЦИ БОЛОО

Намын дүрмийн дагуу жил бүр ротацийн сонгууль болж орон нутгийн намын хороо, Үндэсний зөвлөлдөх хорооны гишүүдийн гуравны нэг нь шинэчлэгддэг. Тухайн жилийн ротацийн сонгуулийг 2010 оны гуравдугаар сарын 1-14, 15-21-нд хоёр шаттайгаар явуулах болсон байна.

Дөрөвдүгээр сарын найманд болсон "4-11" уулзалтад Ардчилсан намын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Эрдэнэбат, УИХ дахь АН-ын бүлгийн дарга Ч.Сайханбилэг, УИХ-ын гишүүн, Нийслэлийн АН-ын дарга С.Эрдэнэ нар оролцсон ба Ардчилсан намын ЕНБД Д.Эрдэнэбат саяхан болж өнгөрсөн Үндэсний зөвлөлдөх хорооны сонгуулийн талаар мэдээлэл хийсэн юм. Тэрбээр "АН-ын ҮЗХ-ны суудлын гуравны хоёрыг жил бүр шинэчлэн сонгууль явуулдаг уламжлалтай. Ер нь манай дотоод сонгууль УИХ-ын сонгууль шиг өрсөлдөөнтэй болдог" гэв. Үндэсний зөвлөлдөх хорооны 76 суудлын төлөө өрсөлдсөнөөс 52-т нь шинэ гишүүд сонгогдов. Харин Гүйцэтгэх зөвлөлийн 33 суудлын 11-д нь шинэ хүн сонгогдов"⁴⁰ гэжээ. Мөн сарын 17-нд АН-ын ҮЗХ-ны хурал Төрийн ордонд боллоо. Монгол Улсын Тэргүүн шадар сайд, Ардчилсан намын дарга Н.Алтанхуяг "Бид энэ хурлаараа гурван асуудал авч хэлэлцэхээр товлосон. Нэгдүгээрт, жил бүхэн нам дотор болдог ҮЗХ-ны гишүүдийн шинэчлэлийн асуудал байлаа. Шинээр орж ирж буй ҮЗХ болоод Гүйцэтгэх зөвлөлийн гишүүдээ батламжилсан. Түүнчлэн намын даргын илтгэлийг сонсч, Засгийн газраас хэрэгжүүлэх гэж байгаа бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг ЗТБХБ-ын сайд Х.Баттулга танилцууллаа. Эдгээр

⁴⁰ Дорж.Д. Х.Баттулга, Х.Тэмүүжин нар яагаад сонгогдсонгүй вэ?, -ӨС.№084 (2010.04.09)

асуудлын хүрээнд үндсэндээ хуралдаж шийдвэрүүдээ гаргасан”⁴¹ гэжээ.

АРДЧИЛСАН НАМЫН МӨРИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙГ ЭРЧИМЖҮҮЛЭХ ҮҮРЭГ



АН-ын ҮЗХ-ны 31 дүгээр хурал дөрөвдүгээр сарын 17-нд Төрийн ордны их танхимд болов. Энэ хурлаар АН-ын дарга Н.Алтанхуяг “Ардчилсан нам-өнөөдөр, маргааш”, УИХ дахь АН-ын бүлгийн дарга Ч.Сайханбилэг “УИХ дахь АН-ын үйл ажиллагаа”, Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Эрдэнэбат “АН-ын хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны талаар”, ЗТБХБ-ын сайд Х.Баттулга “Засгийн газраас хэрэгжүүлэх бүтээн байгуулалтын төслүүд” зэрэг илтгэлийг хэлэлцүүлээ.

Чингэснээр УИХ дахь АН-ын бүлэг, АН-ыг төлөөлөн Засгийн газарт байгаа гишүүдэд АН-ын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай тогтоол гаргасан байна. Үүнд:

1. Хамтарсан Засгийн газраас боловсруулсан “Монгол Улсын Засгийн газрын 2008-2012 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэхийн төлөө


⁴¹ Дорж.Д. Х.Баттулга, Х.Тэмүүжин нар яагаад сонгогдсонгүй вэ?, -ӨС.№084 (2010.04.09)

- үлдэж байгаа хугацаанд илүү шуурхай, идэвхи санаачлага, үр бүтээлтэй ажиллах,
2. Хүний хөгжил сангийн тухай хуулийн хэрэгжилтийг хангахад стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордны төрийн мэдлийн хувьцааг эзэмших төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, иргэдэд уг хуулийн этгээдийн хувьцааг өмчлүүлэн, “Эрдэнийн хувь”-ийг хүртээх ажлыг улам эрчимжүүлэх,
 3. 0-16 насны хүүхдэд сар бүр 20 мянган төгрөг олгох асуудлыг судлаж, шийдвэрлэх ажлыг зохион байгуулах,
 4. 2008 оны УИХ-ын сонгуулийн Ардчилсан намын мөрийн хөтөлбөрт тусгагдсан үйлдвэржилт, хөдөөгийн бодлого, Томоохон бүтээн байгуулалтуудын арга хэмжэг дэмжин, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлд шуурхай ажиллах,
 5. Нийгэмд шударга ёсыг тогтоох, шүүх хяналтын байгууллагын эрх зүйн орчныг шинэчлэх талаар МУ-ын Ерөнхийлөгчийн гаргаж буй санаачлагуудыг дэмжиж ажиллахыг даалгалаа.

НАМАА СӨРСӨН АРДЧИЛСАН ХҮЧНИЙ ХОЛБООНЫ ЧУУЛГАН

Ардчилсан намаас “Ардчилал-20” аяны хүрээнд 21 аймгийг дөрвөн бүст хуваан чуулга уулзалт хийхээр болсон билээ. 8-р сарын 9, 10-нд Архангай аймагт болсон анхан шатны байгууллага, ард иргэдийн санал бодлыг сонсох, судлах хойд бүсийн уулзалт, 21-22-нд Завхан аймагт баруун бүс, 9-р сарын 11, 12-нд Сүхбаатар аймагт зүүн бүс, 19-20-нд Өмнөговь аймагт төвийн бүс гэхчлэнгээр чуулсан байна. Чуулганы гол зорилго нь намын орон нутаг дахь анхан шатны нэгжүүдийн санал хүсэлтийг сонсож, цаашид намын болон орон нутаг, төрийн бодлогод тусгахад чиглэж байв. Наймдугаар сарын 21, 22-ны өдөр Завхан аймгийн Улиастайд болсон баруун бүсийн чуулга уулзалтыг нээж намын дарга Н.Алтанхуяг хэлсэн үгэндээ:

“Ардчилсан нам аливаа зүйлийг санаачлан хийхээс гадна, иргэд юу хийгээсэй гэж хүсч байна, түүнийг зохион байгуулах нь чухал гэж үздэг. Өнгөрсөн хугацаанд бид Ардчилсан нам гэж ярихаасаа илүү ардчилсан хүчин хэмээн ярьж иржээ.





Үнэхээр ч тийм байсан. МҮАН, МСДН 1996 оны сонгуулиар Ардчилсан холбоо эвсэл байгуулж УИХ-д 50 суудал авч, Засгийн эрхийг анх удаа барьсан. Бид маш их зүйл хийсэн ч түүнтэй зэрэгцээд алдаа бас байсан байх. Ардчилсан хүчинд 1996 онд итгэсэн сонгогчид 2000 онд ганцхан суудалтай үлдээсэн. Эл суудлыг Ж.Наранцацралт агсан авч байсныг та бүхэн сайн мэднэ. Харин одоо бол бид Ардчилсан нам гэж ярина. Эвсэл байгуулаад амжилт олдог ч араас нь сөрөг зүйл маш их дагалддаг. Түүнээс бид ангид байх ёстой. Ардчилсан нам 2008 оны УИХ-ын сонгуульд дангаараа оролцоод 27 суудал авлаа. Энэ бол бидний үзүүлсэн амжилт. Цаашдаа УИХ-ын сонгууль болгонд дангаараа оролцоно. УИХ-ын сонгуулиас гадна хамгийн чухал нь орон нутгийн сонгууль байдаг. Ирэх 2012 онд УИХ-ын болон орон нутгийн сонгууль хамт болно. Ардчилсан нам дангаараа оролцоно”⁴² гэж хариуцлагатайгаар мэдэгджээ.

Намын явуулсан чуулга уулзалтын дараагаар “Ардчилсан хүчний холбоо” мөн чуулга уулзалт зохион байгуулсан нь олон түмэнд Ардчилсан намыг хагаралтай, эв нэгдэлгүй, удирдлагууд нь хагаралтай мэт сэтгэгдэл төрүүлсэн юм.

⁴² Эрдэнэбат.Г. Ардчилсан намын баруун бүсийн чуулган Завханд боллоо,- ӨС.№203 (2010.08.27)

НИЙСЛЭЛИЙН АРДЧИЛСАН НАМЫН ДАРГА С.ЭРДЭНИЙГ ЧӨЛӨӨЛӨВ

Нийслэлийн Ардчилсан намын Зөвлөлдөх хороо есдүгээр сарын 27-нд хуралдаад нийслэлийн АН-ын дарга С.Эрдэнийг үүрэгт ажлаас нь чөлөөлж, МоАХ-ны Нарийн бичгийн дарга Ш.Түвдэндоржийг нийт гишүүдийнхээ 91 хувийн саналаар нийслэлийн АН-ын даргаар сонгосноор С.Эрдэнэ намынхаа тамга, тэмдгийг хүлээлгэж өглөө. Ингэхэд С.Эрдэнэ чөлөөлөгдөх өргөдлөө АН-ын ЕНБДарга Д.Эрдэнэбатад өгсний дагуу Зөвлөлдөх хороо хуралдаж энэ шийдвэрийг гаргасан байна. Мөн хуучин, шинэ дарга нар тамга тэмдгээ хүлээлцсэний дараа АН-ын ЕНБДарга Д.Эрдэнэбат, “Манай нам дотор асуудлууд бий. Гэхдээ өнөөдөр эв нэгдлээ хамгийн их дээдлэх ёстой. Хэдийгээр үзэл бодлоороо зөрчилдөх явдал гардаг ч бидний эцсийн зорилго нэг байдаг. Эв нэгдлийнхээ асуудал дээр бат зогсдог. Монгол Улсад Ардчилсан нам байхгүй бол ардчилал байхгүй гэж би ойлгодог. Ардчилсан нам 20 жилийн турш ардчиллын амин сүнс болж ирлээ. Мөн ард түмэн ч биднийг эв нэгдэлтэй байгаасай гэж хүсдэг. Энэ удаагийн хурал бидний эв нэгдлийн бас нэг илэрхийлэл боллоо” гэв.

ҮЗХ-ООР “МОНГОЛ ХҮН 2020” ХӨТӨЛБӨРИЙГ БОЛОВСРУУЛАХ ШИЙДВЭР ГАРГАВ



2010.11.19-нд Ардчилсан намын ҮЗХ-ны ээлжит 32-р хурал Төрийн ордонд болж, ҮЗХ болоод ГЗ-ийн нөхөн сонгуулийн дүнг батлаад, намын дарга Н.Алтанхуягийн улстөрийн илтгэлийг сонсов. АН-ын ЕНБДарга Д.Эрдэнэбатын “Анхан шатаа сонсох аян” болоод АН-ын Хэрэг эрхлэх газрын тайлан, УИХ дахь АН-ын бүлгийн даргын тайлан, АН болон МАХН-ын хамтран ажиллах гэрээний эхний хоёр жилийн тайланг хэлэлцлээ. Энэхүү ҮЗХ-ийн энэ хурлаас хожим АН-ын Сонгуулийн мөрийн хөтөлбөр болох, улсын эдийн засгийн цогц хөтөлбөр “Монгол хүн-2020”-ийг боловсруулах Ажлын хэсгийн ахлагчаар намын дарга Н.Алтанхуяг, АН-ын Үндсэн дүрэмд өөрчлөлт оруулах ажлын хэсгийн ахлагчаар намын ЕНБДарга Д.Эрдэнэбат, орлогчоор нь УИХ-ын гишүүн З.Энхболд, АЭХ-ны тэргүүн Ц.Оюунгэрэл нарыг томиллоо.

Намын ээлжит бус Их хурал хуралдуулахыг гишүүд дэмжсэнгүй

Хуралдааны өмнө “Ардчилсан хүчний холбоо”-ны зүгээс ээлжит бус их хурал хуралдуулах, хамтарсан Засгийн газрыг тараах, Ардчилсан намын дарга, удирдлагыг өөрчлөх шаардлага тавьж байв.

АН-ын ээлжит бус Их хурлыг хуралдуулах санал хураалт явуулж өгнө үү гэсэн ҮЗХ-ны гишүүн П.Батаагийн өргөдлийн дагуу санал хураалт явуулахад ҮЗХ-ийн 203 гишүүний 30-аас бусад нь дэмжсэнгүй. Гэтэл Онц их хурал хуралдуулъя гээд тун идэвхтэйгээр уриалж байсан З.Энхболд, Ж.Батзандан нар үг хэлэхдээ энэ асуудлын талаар огтхон ч үг дуугарсангүй. Харин С.Эрдэнэ, Н.Батаа нарын гишүүд л энэ асуудлыг нэлээд шургуу тавьж байлаа.

Намын дарга Н.Алтанхуяг мэдэгдэхдээ “Манай намын дийлэнх гишүүд намын ээлжит бус хурлыг хуралдуулах тал дээр эсрэг байр суурьтай байна. Санал хураалтад нийт 203 хүн оролцсоноос 30 нь л дэмжсэн. Харин 72,5 хувь нь буюу үлдсэн хүмүүс нь намын ээлжит бус их хурлыг хуралдуулах шаардлагагүй гэж үзэж байна. Тэгээд ч ойр ойрхон намын их хурлыг хуралдуулаад байх шаардлагагүй. Манай нам дөрвөн жилд нэг удаа их хурлаа хийх дүрэмтэй. Гэхдээ сүүлийн гурван жилд хоёр ч удаа их хурлаа хуралдуулсан байна. Намын их хурал хэн нэгний хатгаасаар

явагддаг тоглоом биш”⁴³ гэж хэвлэлийн хурлын үеэр мэдэгджээ. УИХ-ын гишүүн Э.Бат-Үүл 2012 онд өгсөн нэгэн ярилцлагадаа “Манай намд нэг нөхөр байдаг юм. Нэрийг нь хэлээд яах вэ. 1990 онд манай нам байгуулагдсан цагаас эхлэн намын даргатайгаа сөргөөцөлдөж байлаа. Түүний хийдэг ажил нь ердөө энэ. Манай намын дарга хэн болно түүнтэй тэр л үзэлцдэг юм. Түүнийг улс төрд ороод Хувьсгалт намтай үзэлцэж байгааг нь ерөөсөө хараагүй. Намын дарга Э.Бат-Үүл байвал надтай үзнэ. М.Энхсайхан байхад түүнтэй үзэлцсэн. За тэгээд Д.Дорлигжав, Р.Гончигдорж гээд хэн л болно, тэр бүхэнтэй үзэж тарна. Үгүй ээ, мөн их гай чирсэн дээ. Гэтэл одоо түүний энэ өвчин хэсэг бүлэг нөхдөд халдсан бололтой. Энэ балай зүйлээс салах хэрэгтэй”⁴⁴ гэсэн байдаг. Хэдийгээр Э.Бат-Үүл нэрийг нь хэлээгүй ч намын даргатай буюу намын бодлоготой мөнхийн зөрчилдөөнтэй байдаг тэр хүн нь С.Эрдэнэ гэж олон нийт уншиж байв.

⁴³ Мөнхтөр.Л. Ардчилсан намынхан ээлжит бус их хурлаа хийх шаардлагагүй гэж үзжээ,-ӨС.№280 (2010.11.22)

⁴⁴ Бай-Үүл.Э: Манай нам тэнэг л биш бол сонгуульд зангидсан гар шиг эв нэгдэлтэй орох ёстой (ярилцсан Я.Мөнгөнцэцэг),-ӨС.№008 (2012.01.11)

ХАМТАРСНЫ ҮР АШИГ

Хамтарсан Засгийн газрын хамгийн чухал тогтоолын нэг хэмээн тооцогддог Монгол Улсын мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого, “Монгол улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөр”-ийг 2009 оны 9-р сарын 30-нд баталсан юм.

Хөтөлбөрт тусгагдсан зорилт, үйл ажиллагаа болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэл, улсын болон орон нутгийн төсөвт тусгах, зээл, тусламж, төсөлд хамруулах, бусад хөрөнгийн эх үүсвэрийг ашиглаж хэрэгжүүлэхийг Монгол Улсын Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Сангийн сайд С.Баярцогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригт, Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хорооны дарга Ч.Хашчулуун, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгожээ. Мөн Монгол Улсыг үйлдвэржүүлэх хөтөлбөрийг орон нутгийн онцлогт тохируулан хэрэгжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг даалгасан байна.

Хамтарсан Засгийн газрын ололт



Хамтарсан, өөрөөр хэлбэл нэгдсэн, ойлголцсон Засгийн газрын үйл ажиллагааны үр дүнд Монгол орны хөгжилд чухал үүрэгтэй олон шийдвэр, шийдэл ажил хэрэг блдслн юм. *Оюутолгойн* ордын ашиглалттай холбоотой гэрээг байгуулснаас гадна *Атрын III* аяныг өрнүүлж, сүүлийн 20 жилийн түүхэнд гараагүй хамгийн өндөр ургацыг 2009 онд хураан авчээ.

Хамтарсан Засгийн газрын үед жижиг дунд үйлдвэрлэлийг хамгийн их дэмжсэн он жилүүд байсан билээ. Өмнөх Засгийн газрууд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжихэд жилдээ нэг тэрбум орчим төгрөг төсөвлөдөг байсан бол хамтарсан Засгийн газрын үед дээрх мөнгө 300 тэрбум болж өссөн юм. Нэг аймагт 3-4 орчим тэрбум төгрөг төсөвлөгдөж, зээлийн нь эргэн төлөлт ч сайжирсан байдаг. Хамгийн гол нь жижиг, дунд үйлдвэрлэлийн чиглэлээр өгсөн зээлийн жилийн хүү 12% байсныг 7% болгож бууруулсан нь аж ахуй эрхлэгчдийн талархалыг хүлээж байлаа. Энэ ажлыг Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг гардан хариуцаж байсан бөгөөд тэрбээр энэ хугацаанд ихэнх аймаг, дүүргүүдийн нийт 150 гаруй аж ахуй нэгж дээр биечлэн очиж ажил байдалтай нь танилцсан байдаг.



Мөн газар тариалан эрхэлж байгаа болон мал аж ахуйн ферм байгуулсан бол зээлийн эргэн төлөх хугацааг нь таван жил

уртасгасан юм. “Сум хөгжүүлэх сан”-гаас барьцаа хөрөнгө шаардалгүй зээл олгодог болсон нь барьцаа хөрөнгөгүй ч хөдөлмөрлөх, зүтгэх, ахуй амьдралаа өөд нь татах, өөрийн болоод цаашдаа эх орны ирээдүйн төлөө гэсэн түмэн олны итгэл, сэтгэлийг бадраав.

2008 оны УИХ-ын сонгуулийн будлианы шалтаг, шалтгааны нэг нь иргэний бүртгэл мэдээллийн тогтолцооны сул байдалтай шууд холбоотой нь туйлын үнэн. Тэгвэл хамтарсан Засгийн газрын үед тусдаа саланги байсан иргэний болоод эд хөрөнгө, аж ахуйн нэгжийн бүртгэлийг нэгтгэв. Мөн нийт хүн амын 98% иргэний шинэчилсэн бүртгэлд хамрагдаж, хүн бүрийн хурууны хээ нэгдсэн бүртгэлд оров. Ингэснээр төрийн үйлчилгээ хүртээмжтэй болж, төрийн үйлчилгээ түмэнд нээлттэй боллоо.

Олон жил зөвхөн яригдсан чөлөөт бүсийн асуудал бүтээн байгуулагдаж эхлэв. Алтанбулагт дэд бүтцийн нь асуудлыг шийдэв. Замын-Үүдэд БНХАУ-аас авч байгаа 300 сая ам.долларын зээлийн 30 сая ам. доллараар нь дэд бүтцийг цогцоор шийдэх шийдвэр гаргалаа.

1960-аад оноос хойш мөрдөгдөж байгаа стандартуудыг өөрчилж, зөвлөмжийн стандарт гаргаад, заавал мөрдөх стандартыг орон нутаг өөрөө шийдэж байх хуулийн төслийг хамтарсан Засгийн газраас санаачлан УИХ-д өргөн барьж байв. Өөрөөр хэлбэл даяаршилж хөлд нийлэхийн сацуу тусгаар улсынхаа онцлог аливаа жишгийг тогтоохыг эрмэлзэж байв.

Ардчилсан нам Хамтарсан Засгийн газарт орсноор Монгол Улс анх удаа уул уурхайн ашиг орлогоос иргэн бүртээ хувьцаа хэлбэрээр хувь эзэмшүүлэн, цаашид түүнийхээ ногдол ашгийг авах эрх зүйн цоо шинэ орчин болсон “Хүний хөгжил сан”-гийн тухай хууль УИХ-ын 11-р сарын 18-ны өдрийн хуралдаанаар батлагдав. Ингэснээр Монгол Улсын иргэн бүр өөрийнхөө сонголтоор “Хүний хөгжил” сангаас:

- Тэтгэврийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн төлбөр,
- Орон сууц худалдаж авсаны бэлэн төлбөр,
- Эрүүл мэнд,
- Боловсролын үйлчилгээний төлбөр гэсэн дөрвөн үндсэн хэлбэрээр хувь хишиг хүртэх боломж гарлаа.



Ардчилсан нам 2008 оны Сонгуулийн мөрийн хөтөлбөртөө ойрын 10 жилд хэрэгжүүлэх 10 бодлогоо тусгасан байлаа. Энэхүү "Иргэн бүрт-Эрдэнийн хувь" нэртэй мөрийн хөтөлбөрт "Эзэн монгол хүн", "Ажилтай, орлоготой, амгалан амьдрал", "Монголдоо үйлдвэрлэе", "Эрдэнийн хувь", "Эрүүл бие, саруул ухаан", "Шударга ёс, иргэний нийгэм", "Шинэ хөдөө, Шинэ Улаанбаатар", "Хавтгай Монгол, дэд бүтэц", "Байгаль ээж", "Манайд ирээрэй" гэсэн 10 багц бодлогын хүрээнд асуудлуудыг дэвшүүлсэн байдаг. Намын мөрийн хөтөлбөр, нэг талаасаа Засгийн газрын бодлогын үндэс суурь болсон бол нөгөө талаасаа Ардчилсан нам, түүний удирдлагын зоригтой бөгөөд ард олны төлөө гаргасан засаглалын түвшинд хамтрах шийдвэрийн үр дүнд мөрийн хөтөлбөр хэрэгжих нөхцөл боломж бүрдсэн билээ.

Хамтарсан Засгийн газар эдийн засгийг эрчимтэй хөгжүүлэх зорилгоор үндсэн дөрвөн төслийг хэрэгжүүлэх шийдвэр гаргалаа. Энэ нь "Таван толгой"-н орд газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах, "Иргэн бүрт 1,5 сая төгрөг"-ийг тэтгэвэрийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, эрүүл мэнд, боловсрол, орон сууцны төлбөрийн эрх, бэлэн мөнгө өгөх хэлбэрээр олгох төсөл, "Шинэ төмөр зам" буюу баруун хязгаараас зүүн хязгаар хүрэх хөндлөн тэнхлэгийн төмөр замын төсөл, "Утаагүй Улаанбаатар" төсөл байв. Гэвч эдгээр төслүүд ихэнх нь цаасан дээр үлдсэн

билээ. Хэрэгтэй юу хэрэгтэй, хэрэгжээгүй юу мэдэхгүй байдлаар гацаасаар, гацсаар Улаанбаатар хот утаатай хэвээр, хөрсний бохирдол даамжирсаар, шинэ төмөр зам төслийн ТЭЗҮ хуучирсаар. УИХ-ын гишүүн Н.Ганбямба, УИХ-ын зургадугаар сарын 25-нд хуралдсан чуулганы үеэр “Энэ төсөл сайн төсөл болжээ. Харин үүнийг яаж санхүүжүүлэх нь анхаарал татаж байна. Байсхийгээд баахан төсөл, хөтөлбөр батлаад байдаг. Санхүүжилтийг нь яах юм гэхээр улсын төсвөөс, гадаадын зээл тусламжаар, бусад эх үүсвэрээс гэсэн жижүүрийн үг хэлж ам тагладаг. Өнөөдөр 420 хөтөлбөр баталсан байна. Аль нь ч хэрэгжээгүй. Тийм байтлаа дахиад л хөтөлбөр батлуулах гээд оруулж ирсэн байна”⁴⁵ гэсэн нь оргүй биш байсан билээ.

Төмөр замын тухай асуудал

“1949 оны 11 дүгээр сарын 7-нд хуучнаар Октябрийн баярын өдөр анхны галт тэрэгний цуваа Улаанбаатар хотноо ирж ёслол төгөлдөр хүлээж авчээ. Түүнээс хойш төмөр замын талаар ямар ч тодорхой төрийн бодлогогүй байсныг нь бодлоготой болгоод УИХ-аар 2010 онд батлуулж чадсан ч, өнөөг хүртэл нэг цент ч тэр ажилд өгдөггүй ээ. Тэгэхээр би одоо яах вэ? Сайншандын аж үйлдвэрийн парк зүүн зүгт тавих төмөр зам гээд өчнөөн л ярьсныг минь цөмөөрөө л мэдэж байгаа. Өмнөд хилээр цөмрөөд найман газраар нүх гаргаж түүхий нүүрс хямд зөөх гээд байна шүү гэдгийг ойлгуулах гээд өчнөөн л хичээлээ. Аанай л бүтсэн, төр засгаас дэмжигдсэн юм одоогоор алга”⁴⁶ гэсэн цөхөрсөн үгсийг салбарын хоёр яам толгойлж, УИХ-д хэд хэдэн удаа сонгогдсон Х.Баттулга хэлсэн юм.

Хамтарсан Засгийн газар хамтарсныхаа үр дүнд их ч олон ажил хийсэн, басхүү гадны нөлөөгөөр их ч олон ажлаа хааж боолгуулж гацаалгуулсны нэгэн жишээ дээрх байв.

⁴⁵ Доржпагма.Д. Улсын жилийн төсвөөс долоо дахин их санхүүжилт шаардсан төслийг хэлэлцэв, -ӨС.№152 (2010.06.26)

⁴⁶ Төрмөнх.Д “Миний мэдэх “Женко” Баттулга”. УБ.,2016.х.67

МАХН “МОНГОЛ АРДЫН НАМ” БОЛОВ



МАХН-ын XII Бага хурал 2010 оны есдүгээр сарын 7-нд хуралдлаа. Бага хурлаар үндэсний ардчилсан үзэл баримтлалтай болох, намын нэр, тунхагийг сэргээх тухай санал гаргасан бөгөөд шийдвэрлэх эрхийг МАХН-ын XXVI Их хуралд үлдээсэн байна. МАХН-ын Их хурал 2010 оны 11 дүгээр сарын 4-нд Төрийн ордонд эхэллээ. Хоёр дахь өдрийн хуралдаанаар төлөөлөгчдийн олонхийн саналаар МАХН, МАН болж нэрээ өөрчлөн, уугуул нэршилээ сэргээсэн байна. Намын дарга С.Батболд “МАХН-ын XXVI их хурал түүхэн шийдвэр гаргасныг танилцуулахад таатай байна. Мянга мянган гишүүн хурал зөвлөгөөнөөр хэлэлцэн судалж байж МАХН-ын уугуул нэр, манай намын зүй ёсны эхлэл МАН-ын нэрийг сэргээлээ. Үүгээр манай намын их хурлын төлөөлөгчид бахархаж байна. Бид МАН гэсэн нэрээ сэргээж, хувьсгалт гэдэг үгээ халлаа. МАХН түүхэн үүргээ гүйцэтгэсэн. Хийх ёстой хувьсгалаа хийсэн. Улсаа улс шиг улс байлгахын төлөө зүтгэсэн. Харин МАН-д ард түмнийг үсрэнгүй хөгжилд манлайлах үүрэг ногдож байна”⁴⁷ гэжээ. Ингэж МАХН, МАН нэрээ сэргээснээр Ерөнхийлөгч асан Н.Энхбаяр тэргүүтэй нөхөд шинээр МАХН байгуулах шалтаг, шалтгаан болж, үндэс тавигдсан байна. Энэхүү намын шинэчлэлийн асуудал нь зөвхөн нэр

⁴⁷ Мөнгөнцэцг.Я. Үүр цайтал хуралдаж, С.Батболдыг МАН-ын анхны даргаар сонгов, -ӨС.№268 (2010.11.08)

сэргээсэн төдий хэрэг биш “олон жил хуримтлагдсан авилга, хээл хахууль, дарамт шахалт гэх мэт шударга бус байдлыг нураах”⁴⁸ зорилготой гэж МАН-ын ЕНБД У.Хүрэлсүх мэдэгдсэн нь бий.

ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙДЫГ ОГЦРУУЛАХ САНАЛ ДЭМЖИГДСЭНГҮЙ

Он солигдохын алдад буюу 12-р сарын 27-ны өдөр УИХ-ын гишүүн Ц.Батбаяр, С.Эрдэнэ, Ц.Сэдванчиг нар Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтыг огцруулах саналыг УИХ-ын дарга Д.Дэмбэрэлд өргөн барив. Ингэхдээ Гол мөрний урсац бүрэлдэх эх, усан сан бүхий хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг баталж гаргаснаас хойш 192 ширхэг хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон, ТЭЦ-2 дулааны станцыг түшиглэн байгуулах хагас коксжсон түлшний үйлдвэр байгуулах тендерийг зохих шаардлагын дагуу шалгаруулаагүй зэрэг долоон зүйлийг үндэслэл болгон огцруулах санал гаргажээ. Үнэндээ бол Д.Зоригт сайд, харин ч УИХ-аар баталсан хуулийн дагуу 250 лиценз цуцалсан төдийгүй, 1150 орчим лиценз цуцлахаар бэлтгэж байжээ. УИХ-ын нэгдүгээр сарын 20-ны өдөр хуралдсан чуулганаар ЭБЭХ-ний сайд Д.Зоригтыг огцруулах эсэх тухай асуудлыг хэлэлцээд гишүүдийн 72 хувь нь огцруулахгүй гэж санал өгчээ. Өнгөн талдаа урт нэртэй хууль байгаль орчныг хамгаалсан ач холбогдолтой мэт харагдаж байлаа. Гэвч Монгол Улсын Засгийн газар урт нэртэй хуулийг хэрэгжүүлснээрээ нөхөн төлбөрийн өрөнд унасан юм. Өөрөөр хэлбэл, урт нэртэй хуульд хамрагдсан буюу хамрагдах олон аж ахуйн нэгж эрсдэлээ өөрснөө үүрэн хайгуул хийж байв. Гэтэл дээрх хууль батлагдан хэрэгжсэнээр олон арван лиценз цуцлагдсанаар, Монгол Улсын Засгийн газар нөхөн төлбөрт автоматаар орсон билээ.

УИХ-ын шийдвэр нэгэнт гарсан хэдий ч УИХ-ын гишүүн С.Эрдэнэ, Д.Ганхуяг, Г.Баярсайхан нар ЭБЭХ-ний сайд Д.Зоригтыг огцруулах саналыг 2011 оны тавдугаар сард дахин гаргасан байна. УИХ дахь намын бүлгүүд, Эдийн засгийн байнгын хороо, УИХ дээрх асуудлыг дэмжээгүй ба сайд Д.Зоригтыг огцруулаагүй

⁴⁸ Хүрэлсүх.У: Шантаажны улс төр гэдэг байж боломгүй зүйл (ярилцсан Б.Энхцэцэг), -Ө.№017, 018 (2011.01.20)

юм. Харин УИХ-ын гишүүн Ц.Батбаярын эл үйлдлийг намын удирдлагуудтай таарамж муутай байсан, Ерөнхийлөгч асан Н.Энхбаяртай холбоотой байсан үеийнх нь асуудал сөхөгдөн гарч эхлэх магадлалтай байсантай холбон тайлбарлаж болох билээ.

ТАВАН ТОЛГОЙН ОРДЫГ АШИГЛАХ ЭХНИЙ ШИЙДЭЛД ХҮРЛЭЭ



2007 оны 3-р сарын 21-нд “Энержи ресурс” концерциум хууль ёсоор эзэмшиж байсан Таван толгойн үндсэн орд газраа МУ-ын Засгийн газарт шилжүүлсэн байдаг. Ингэхдээ эзэмшиж байсан зургаан лицензийн нэгд хамаарах “Ухаа худаг” орд газрыг өөрийн мэдэлд үлдээх тохиролцоонд хүрсэн бөгөөд энэхүү зургаан лиценз, түүнийг тойрсон асуудал, ТТ-н ордыг олборлох, зах зээлийн эргэлтэнд оруулах, цаашлаад иргэн бүрт оногдох эрдэнийн хувийн асуудал хэн нэгний ашиг сонирхол, хэтэвч халаас нэгтэй бүлэглэлийн нөлөөнөөс болж урагшлахгүй байсаар олон оныг элээсэн юм.

Хамтарсан Засгийн газрын нэг давуу тал нь аливаа асуудлыг нэг нь дэвшүүлдэг, нөгөө нь гацаадаг чөтгөрийн тойргоос ангид байж чадсанд оршиж байв. Үүний тод жишээ нь “Оюу толгой”-н зэс, алтны орд газрын хөрөнгө оруулалтын гэрээг баталсан

байсан бол басхүү “Таван толгой”-н нүүрсний ордыг ашиглах үзэл баримтлалд шийдэлд хүрсэн явдал байлаа.

Тухайн ордыг Монголын төр, “Эрдэнэс МГЛ” төрийн өмчит хувьцаат компаниар дамжуулан эзэмших болсон юм. 2009 онд “Эрдэнэс МГЛ” компани олон улсын байгууллагаар судалгаа хийлгэхэд 7,5 тэрбум тонн нүүрсний нөөцтэйгөөс 3,5 тэрбум тонн нь коксжих нүүрс гэж тогтоожээ. Тус ордыг төр мэдэлдээ авах нь хэр оновчтой талаар олон янзын байр суурь гарч байв. Тухайлбал, УИХ-ын гишүүн Э.Бат-Үүл “Таван толгойн ордыг төрийн өмч болгочихвол тэр өмчийг хяналтдаа авахын тулд манай улс төрийн бүлэглэлүүд тулалдана. Худал үнэн зүйл ярьж үймүүлэн гоё сайхан популист амлалт амлаж татаж оруулна. Энэ дэлхий дээр болсон улс орны иргэний дайны шалтгааны 90 хувь нь баялгийн төлөөх тэмцлээс үүдэлтэй” гээд төрийн муу менежментийн жишээнд “МИАТ”, “Эрдэнэт”-ийг дурдаж байжээ.

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар (7-р сарын 7-ны өдрийн) Таван толгойн нүүрсний ордыг ашиглах зарим асуудлын тухай УИХ-ын тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж, нийт гишүүдийн 88,7 хувийн саналаар баталлаа. Ингэснээр төрийн өмчийн “Эрдэнэс МГЛ” компанийн охин компани болох “Эрдэнэс-Таван толгой”-г байгуулж, ашиглалтын зөвшөөрлийг шилжүүлэн, хувьцааны 10 хувийг Монгол Улсын иргэдэд эзэмшүүлж, 10 хувийг нь үндэсний аж ахуйн нэгжүүдэд дотоодын хөрөнгийн биржээр дамжуулан нэрлэсэн үнээр арилжаалж, 30 хүртэлх хувийн хувьцааг гадаад, дотоодын хөрөнгийн биржээр арилжаалах нөхцөл бололцоо бүрдлээ.

АРДЧИЛСАН ХУВЬСГАЛЫН 20 ЖИЛИЙН ОЙН ХААЛТЫН ХУРАЛ

Ардчилсан нам Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойг бүтэн нэг жилийн турш орон даяар ард түмэнтэйгээ хамт тэмдэглэсний хаалтын ажиллагаанд зориулсан баярын хурлаа 2010 оны арванхоёрдугаар сарын 10-нд Төрийн ордны Их танхимд хийлээ. Хурлын эхэнд Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн мэндчилгээг Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга Д.Баттулга хүргэж, дараа нь намын дарга Н.Алтанхуяг, МоАХ-ны ерөнхийлөгч Х.Баттулга,



Ардчиллын төлөөх намуудын анхны даргаар ажиллаж байсан Да.Ганболд, Б.Батбаяр, (Баабар), Монголын оюутны холбооны ЕНБД-аар ажиллаж байсан Д.Баясгалан нар илтгэл тавив.

Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж ирүүлсэн мэндчилгээндээ “Монголын ардчилагчид цасны жавар, цагийн жавар хоёрыг хамтад нь сөрж боссон тэр цагаас хойш 20 жил улирлаа. Цасанд шургаж ургасан цэцэг, мөс өргөж үндэслэсэн нахиа шиг эмзэг, гэхдээ гарцаагүй ирэх цагийн бэлгэдэл байсан. Монголын ардчилал нэгэнт 20 хавар, 20 намрыг үджээ. Ардчиллыг анхны өдөр нь арчих гэж тэмүүлсэн тэр хүчин, тэр үзэл санаа өнөөдөр өөрсдөө тэр түүхнээс арчигдан арилж байна. Монголын ардчилал ачаагаа даах тэнхээтэй, араа даах хариуцлагатай болж, эрийн цээнд хүрлээ” гэсэн байв.

Ардчилсан намын дарга Н.Алтанхуяг “Хонх”-ны дуугаар эхэлсэн Ардчиллын хоёр дахь шатны хувьсгал эхэлснийг дурдаад “Өнөөдөр бидний дунд сууж байх ёстой, монгол түмнийхээ сэтгэл зүрхэнд хонгор залуугаараа хоногшсон, ардчилсан нийгмийг авчрахын төлөө түнэр харанхуйг гэрэлтүүлж явсан, үсний сор нь мөнгөрч, духны толио нь хээтэж амжаагүй тэнгэрт одсон идэрхэн андуудаа энэ мөчид хүндэтгэн дурсацгаая. МоАХ-ны анхны зохицуулагч, Ардчилсан хувьсгалын түүчээ С.Зориг, МУ-ын Ерөнхий сайд агсан Ж.Наранцацралт, Анхны өлсгөлөн

зарлагчдын нэг Б.Галсандорж, ШДХ-г үүсгэн байгуулагч Д.Батсүх, УИХ-ын гишүүн агсан Г.Ганхуяг, Хууль зүйн сайд агсан С.Батчулуун, “Алдарт “Хонх”-ны С.Цогтсайхан, МоАХ-ны Тамгын дарга агсан Самбараазана, саяхан бидэнтэйгээ 70 жил ноёрхсон бул хар хүчний эсрэг улаан гар, цогтой үгс, хоёргүй сэтгэлээр зүтгэж, өрөөлийг ирлэж, өөрсдөө элэгдсэн олон нөхдийнхөө гэгээн дурсгалыг хүндэтгэж, нэг минутын хүндэтгэл үзүүлцгээе” гэсэн үгээр илтгэлээ эхэлж байв. Тэрбээр “Ойр зуурын үл ойлголцол, цаг үеийн толхилцооноос эв эвдэрч, сэтгэлээ сэвтээж, олон боломжийг алдаж гээсэн гашуун үйлдэлд үе үеийн удирдлага, журмын нөхдийнхөө өмнөөс хүлцэл өчье. Бизнес хийх боломжоо намын харьяаллаар хаалгуулж, төрөөс төрсөн тэрбумтан, эрх баригч намын дэмжлэгтэй олигархиудад шахагдан орон зайгүй болсон жирийн олон монголчуудыг бид харж, бэрхшээлийг нь мэдэрч байна. Энэ бүхнийг эрс өөрчлөхөд улс орондоо эдийн засгийн шинэчлэл хийх, ард түмнээ ажилтай амьдралтай, цалинтай орлоготой болгохын төлөө тайван хувьсгал хийх шаардлагатай болжээ. Улс орноо хөгжлийн зөв гольдролд оруулах, түмэн олноо сайн сайхан амьдруулахын төлөө хийх зөв зорилготой хувьсгалаас эмээх хэрэггүй, ухрах ёсгүй. Ийм хувьсгалыг даргын суудал, мөнгөний хүүдийнд толгойгоо мэдүүлсэн тураалтай тархи, тушаатай сэтгэлгээтнүүд хийхгүй. Ийм хувьсгалыг ардчиллыг дээдэлж, шударга ёсыг эрхэмлэсэн Та бүхэн, мянга мянган эгэл жирийн монголчуудынхаа хамтаар хийж чадна” гэлээ.

Баабар, “Би итгэж байна, тиймээс би амьдарч байна” гэсэн илтгэлээ Францын философич Вольтэрийн “Таны ярьж байгаа надад огт таалагдахгүй байна, гэхдээ хэлэх эрхийн чинь төлөө амиа ч өгөхөд бэлэн байна” алдарт үгээр эхлүүлж “Одоогоос 25 жилийн өмнө БНМАУ хүнсний зорилтот программ дэвшүүлж, ирээдүйд монгол хүн бүр жилд 88 килограмм мах иддэг болгохоор төлөвлөж байсан юм. Гэтэл энэ тоо өнөөдөр 120 килограмм болтлоо давж биелээд байгаа. Үр дүнд нь манай гурван хүн тутмын нэг нь илүүдэл жинтэй болжээ. Энэ бүхнийг дэвшил гэх үү, доройтол гэх үү. Энэ талаар манай 2,7 сая толгой өөрийнхөөрөө дүгнэж байгаа” хэмээн үргэлжлүүлжээ.

Ардчилсан хувьсгалын удирдагчдын нэг Да.Ганболд “Эдийн засгийн хувьсгалыг боловсролоос эхэлье. 1990 онтой харьцуулахад өнөөгийн бидний гарааны нөхцөл байдал өөр

болсон. Тэр нөхцөл байдлыг тэс өөр болгож чадах хоёр чухал хүчин зүйл бий. Нэг нь Монгол улсын газар доорхи байгалийн баялаг, нөгөө нь Эрдэнэт хүн, монгол хүн...Нэгэнт бид 20 жилийн ойгоо тэмдэглэн үдэж, ирэх 10 жилийн хөгжлийн чиг хандлагыг томъёолох мөчид ирээд байгаа тул дээрхи хоёр хүчин зүйлийг хэрхэн, яаж “чулуу” болгохоо маш сайн бодох хэрэгтэй” гэв.

МОХ-ны анхны ерөнхийлөгч Д.Баясгалан “Энэ үгийг уг нь манай Оюутны холбооны анхны Ерөнхий нарийн бичгийн дарга Л.Болд хэлэх ёстой байсан ч ажлын шаардлагаар хуралд оролцох боломжгүй болсон тул АН-ын дарга надад энэ хүндтэй үүргийг санал болгосон юм. Би ер нь үг бэлдэж сураагүй. Тиймээс энд сэтгэлийнхээ үгийг хэлье гэж бодож байна. Ардчилсан хувьсгалыг Монголын ардчилсан холбоо, Ардчилсан социалист хөдөлгөөн, Шинэ дэвшилт холбоо, Монголын оюутны холбоо дөрөв удирдсан. 1989 оноос эхлээд байнга хамтарч ажилласан. Ардчилсан намд өнгөрсөн хугацаанд алдсан зүйл нэлээд бий. Алдсан зүйлүүдээ тунгааж үзээч ээ. Өөрсдийнхөө ялгарлыг бий болгооч. Ардчилсан намыг хүмүүс алдаа гаргахыг нь зөвшөөрдөг. Ардчилсан нам дотроо өчнөөн асуудалтай ч гэсэн Монголын ард түмэн Ардчилсан намд хайртай. Ардчилсан намыг уучилж чаддаг. Та нар эв нэгдлийг чухалчилж, өмч хөрөнгийг зөв хуваарилахгүй бол бид гадаадад очихоороо ядуу орны баян бизнесмэн баймааргүй байна. Та нар ч гэсэн ядуу орны баян сайд, УИХ-ын гишүүн байхыг хүсдэггүй байлгүй дээ” гэлээ.

МоАХ-ны дарга Х.Баттулга “Нэгдэл нягтрал, ардчилал, шинэчлэлийн төлөө тууштай тэмцэснийхээ үр дүнг бид бага боловч харж байна. Монголын ард түмэн ардчилсан үзэл санааг хүлээн зөвшөөрдөг, сонгогчдын талаас илүү хувь нь биднийг ямагт дэмждэг. Бид ч сонгогчдын асар их дэмжлэг, итгэл найдварыг тээж, үүрэг хариуцлагаа ухамсарлаж, чадах бүхнээ хийхээр чармайж явна.Нийгэмд эдийн засгийн дорвитой өсөлт, хангалттай орлого, хуримтлалыг зөвхөн үйлдвэржилт, ажлын байр л авчирч чадна. Ингэж байж ардчиллын эдийн засгийн баталгаа бий болно. Үгүй бол даарсан хүмүүс сүхээ бариад ой мод руугаа явсаар л байх болно. Өлссөн хүн амраар нь эх байгалиасаа хоолоо залгуулсаар л байх болно. Орлогогүй сонгогчид саналаа цөөн хэдэн төгрөгөөр арилжсаар л байх болно. Ажилгүй орлогогүй хүмүүс орлоготой нэгнээ сааж, дарамталж, хуурч, хулгайлсаар байх болно” гэсэн юм.

Баярын хурлын төгсгөлд УИХ-ын гишүүн Р.Амаржаргал, С.Ламбаа, Нийслэлийн АН-ын дарга Ш.Түвдэндорж, Сүхбаатар аймгийн Засаг дарга Ж.Батсуурь, МОХ-ны анхны ерөнхийлөгч Д.Баясгалан нарыг “Чингис хааны одон”-гоор шагнажээ. Орой нь Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойд зориулсан хүчит 128 бөхийн барилдаан Монгол бөхийн өргөөнд болж, Улсын арслан Д.Ганхуяг түрүүлэн, Аймгийн хурц арслан Р.Пүрэвдагва үзүүрлэв. Маргааш өдөр нь Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойд зориулсан орчин үеийн хөгжмийн “Их тэсрэлт” тоглолт “УВ палас” цогцолборын концертын Их танхимд болсноор нэгэн жилийн турш тэмдэглэсэн Ардчилсан хувьсгалын 20 жилийн ойн баяр өндөрлөсөн билээ.

ХӨГЖЛИЙН БОДЛОГО: “МОНГОЛ ХҮН-2020”

Эхлэл тавигдсан нь



Нэгэнтээ АН-ын дарга Н.Алтанхуяг “Өнгөрсөн хугацаанд манай нам эрх барьж ч, барилцаж ч үзлээ. Энэ бүгдээс онцгой ажиглагдсан нэг зүйл бол манай нам ялсан үедээ “За одоо яах вэ, юу хийх вэ, юунаас ажлаа эхлэх вэ” гээд ерөнхийдөө нүдэн баримжаагаар урагшаа явдаг. Тэгвэл энэ явдалд цэг тавьж, намынхаа маш тодорхой хөтөлбөртэй болъё. Ардчилсан

нам сонгуульд ялсан тохиолдолд юу хийхээ тодорхой болгоё” гэсний дагуу өнгөрсөн жилийн арваннэгдүгээр сарын 19-ний өдөр АН-ын ҮЗХ хуралдаад Монгол Улсын хөгжлийг хурдасгах, иргэдийнхээ ахуй амьдралыг дээшлүүлэхийн тулд Ардчилсан нам юу хийх ёстой вэ гэдгээ хэлэлцэв. Мөн өнгөрсөн 20 жилийн хугацаанд гаргасан ололт амжилт гэхээсээ илүү алдаа оноогоо ч илэн далангүй ярилцсан байна. Ингэхдээ Ардчилсан хувьсгалын хоёр дахь давалгаа буюу “Эдийн засгийн хувьсгал хийе” гэдэг дээр санал нэгдсэн юм. Гэхдээ улс орны хөгжлийг эдийн засгийн өсөлтийн хувь хэмжээгээр тогтоох нь өрөөсгөл ойлголт, харин энэ бүхний төвд хүний хөгжил байх ёстой гэж үзээд Ардчилсан нам Монгол Улсынхаа иргэнийг, хүнийг дээдэлсэн “Монгол хүн-2020” хөтөлбөрийг боловсруулах шийдвэр гаргаснаа тус намын дарга Н.Алтанхуяг шинэ оны анхны “4-11” (2011.01.06) уулзалтаараа мэдээлсэн юм. Ингэснээр Ардчилсан намын хувьд Эдийн засгийн хувьсгалаа эхлүүлээ.

Хөгжлийн бодлого

Ардчилсан нам 2011 оны нэгдүгээр сарын 6-нд болсон “4-11” уулзалтаар “Монгол хүн-2020” хөтөлбөрийг ард нийтээр хэлэлцүүлэх болсноо зарлалаа. Хөтөлбөр бүрэн хэрэгжвэл 2020 он гэхэд:

- Эрх чөлөөтэй
- Эрүүл чийрэг
- Эрдэм боловсролтой
- Ажил орлоготой
- Аюулгүй орчинтой монгол хүн төлөвших, болох учиртай байв. “Монгол хүн-2020” хөтөлбөрийг бүтэн жилийн хугацаанд ард нийтээр хэлэлцүүлэх ба 2012 онд намын ээлжит бус их хурлыг хуралдуулах төлөвлөгөөтэй байгаагаа Ардчилсан намын удирдлагууд танилцуулжээ. “Монгол хүн-2020” хөтөлбөр нэг талаасаа хүний хөгжил, нийгмийн хөгжлийг дэмжсэн ажил, зорилго байсан бол нөгөө талаасаа Ардчилсан намын нэр хүндийг өргөх, намын дотоод хагарлаас зайлсхийсэн, цаашлаад УИХ-ын ээлжит сонгуулийн бэлтгэл болсон ажил, хөтөлбөр, хэлэлцүүлэг байсан юм.

АРДЧИЛСАН НАМЫН АНХНЫ ВИДЕО ХУРАЛДААН



Ардчилсан нам 2010 оныг “Анхан шатаа сонсох жил” болгон зарлаж, 21 аймгийн намын удирдлагуудтайгаа сард нэг удаа телефон хурал хийж ажил байдалтай нь танилцан санал хүсэлтийг нь сонсдог байв. Техник технологи хурдацтайгаар хөгжиж буй цаг үетэйгээ уялдан сар бүрийн хоёр дахь долоо хоногийн Пүрэв гарагт видео хурлыг зохион байгуулахаар болж, эхний хурлаа (2011.01.13) Мэдээлэл холбооны сүлжээ ТӨК-ийн хурлын танхимд хийлээ. Хуралд Ардчилсан намын дарга Н.Алтанхуяг, ЕНБДарга Д.Эрдэнэбат болон намын нарийн бичгийн дарга нар оролцож 15 аймаг, хоёр дүүргийн намын дарга, гишүүдтэй онлайнаар холбогдон, мэдээ мэдээлэл солилцож, тухайн онд хийгдэх ажлын талаар чиглэл өглөө.

Хурлын эхэнд намын дарга Н.Алтанхуяг хэлсэн үгэндээ “Ардчилсан нам 2010 оныг Ардчилсан хувьсгалын 20 жилийн ой, Анхан шатаа сонсох жил болгон зарлаж улс орны хэмжээнд томоохон арга хэмжээнүүдийг зохион байгуулсан нь үр бүтээлтэй болсон”-ыг онцолжээ. Мөн өнгөрөгч ҮЗХ-ны ээлжит 32-р хурлаас “Монгол хүн 2020” эдийн засгийн цогц хөтөлбөрийг боловсруулах ажлын хэсэг байгуулагдан ажилдаа орсон. Хөтөлбөрийг намын хүрээнд бус ард түмнээрээ хэлэлцүүлж байж батлах зорилго

тавьсанаас хамгийн түрүүнд Монгол орны наран мандах зүг Дорнод аймгаас хэлэлцүүлгээ эхлүүлж байгааг танилцууллаа. Энэ хөтөлбөрийн үр дүнд аймаг бүрээс дэд хөтөлбөрүүд гаран, үндсэндээ нэгтгэгдэж “Монгол хүн 2020” гэсэн хөтөлбөр бий болох бөгөөд орон нутгийн намууд идэвхитэй оролцож өөрийн аймгийн хөтөлбөрийг боловсруулах тал дээр эртнээс бэлдэж ажиллахыг үүрэг болголоо.

Үүний дараа аймгийн намууд өнгөрсөн оныхоо амжилт бүтээлийг намын удирдлагууд болон бусад аймгийн намууддаа тайлагнаж, санал хүсэлтээ хэлсэн юм.

Уг видео хурлын үеэр аймгийн намуудын удирдлага сонгуулийн холимог тогтолцоог дэмжих, УИХ болон Засгийн газрын гишүүдийг видео хуралд оролцуулж байх, Ардчилсан намаас хэрэгжүүлж байгаа “Сум-330” сургалтын захиалгат хөтөлбөрт хамрагдаж байгаа гишүүдийнхээ тоог нэмэгдүүлэх, Дорнод аймагт зохион байгуулагдах “Монгол хүн-2020” ард түмний хэлэлцүүлгийг нийтэд өргөн мэдээлж, бусад аймгуудад туршлага болгох, анхан шатны гишүүдийг чадавхижуулахад илүүтэйгээр анхаарч ажиллах, намын дэргэдэх байгууллагууддаа анхаарал хандуулан, үйл ажиллагааг нь сэргээх зэрэг асуудлуудыг дэвшүүлж байсан юм. Мөн Ардчилсан нам сар бүрийн тогтмол өдрийг аймгийн намын удирдлагуудтайгаа холбогдон мэдээлэл хийж, санал хүсэлтийг нь сонсдог өдөр болгож байгаад орон нутгийн намын удирдлагууд сэтгэл өндөр байгаагаа илэрхийлсэн билээ.

ЭДИЙН ЗАСГИЙН ХУВЬСГАЛ

Ардчилсан намын ҮЗХ-ны 32-р хуралдаан нэгдүгээр сарын 28-нд Төрийн ордонд болов. “Өнгөрөгч оны 11-р сард хуралдсан АН-ын ҮЗХ-ны хуралдаанаар ардчилал хөгжсөнөөс хойшхи 20 жилийн үйл явдлыг дүгнэн хэлэлцсэн бөгөөд дараагийн 20 жилд хийх ардчиллын хоёр дахь давалгааг эхлүүлэхээр шийдвэрлэсэн тухай Ардчилсан намын дарга Н.Алтанхуяг илтгэлийнхээ эхэнд дурдав. Энэхүү давалгааг “Эдийн засгийн хувьсгал” хэмээн нэрлэсэн байна. Тиймээс монгол хүн эх орондоо сайхан амьдрах нөхцөл бий болгосон эдийн засгийн хувьсгалыг хийхийн тулд



“Монгол хүн-2020” хэлэлцүүлгийг орон даяар явуулж, цаашдын зорилгоо тодорхойлохоор болсон аж”⁴⁹.



Ардчилсан намаас дэвшүүлсэн эдийн засгийн шинэчлэл, хувьсгалын гол зорилго нь Монгол Улсын тусгаар тогтнол, аюулгүй байдлыг бэхжүүлэх, эдийн засгийг тогтвортой, эрчимтэй хөгжүүлэхэд чиглэж байв. МУ-ын Тэргүүн шадар сайд, АН-ын дарга Н.Алтанхуяг “Нэгдүгээрт уул уурхай дээр түшиглэн амьдарч байгаа хэв маягаа өөрчлөх шаардлагатай байна. Хоёрт манай экспорт, импорт нэг орноос хамаарсан хэвээрээ байна. Гуравт баян ядуу орлогын түвшний ялгаа улам бүр нэмэгдэж байна. Дөрөвдүгээрт бэлэнчлэх сэтгэлгээ өсч хүмүүсийн ажил хийх сонирхол буурч байна. Тавдугаарт хүний хөгжлийн асуудал орхигдож байна”⁵⁰ хэмээн эдийн засгийн шинэчлэл хийх шалтгааныг тайлбарлажээ.

Анхны лекц

Ардчилсан хувьсгалын хоёрдахь давалгаа буюу “Эдийн засгийн хувьсгал эхэллээ” цуврал лекцийн анхных нь Төрийн ордны Их

⁴⁹ Гэрэлмаа.Т. Намын Ерөнхий нарийн бичгийн даргыг солих эсэх асуудлыг хөндсөнгүй,-ӨС.№032 (2011.01.29)

⁵⁰ Алтанхуяг.Н: Засгийн газар огцорвол иргэдэд л муу (ярилцсан Л.Мөнхтөр),-ӨС.№256 (2011.10.25)

танхимд болж, АН-ын дарга Н.Алтанхуяг “Эдийн засгийн хувьсгал эхэллээ”, Баабар “21-р зууны улстөр, эдийн засгийн хувьсгал улс орнуудад”, Сүхбаатар аймгийн Засаг дарга Ж.Батсуурь “Эдийн засгийн хувьсгал орон нутгаас” зэрэг илтгэл тавилаа. Лекцийг “Сум 330” тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдан Удирдлагын академид суралцаж буй 2 болон 4 дүгээр ээлжийн суралцагсад урилгаар ирж сонссон байдаг.

“Монгол хүн-2020” хэлэлцүүлгийн хаалтын ажиллагаа болов



Оны эхэнд наран ургах зүг Дорнод аймгаас эхэлж, өмнийн говьд өндөрлөсөн “Монгол хүн -2020” хэлэлцүүлгийн хаалтын ажиллагаа болох “Монгол хүн-2020-Улаанбаатар” хэлэлцүүлэг Буянт-Ухаа дахь Спорт цогцолборт 2011 оны арванхоёрдугаар сарын 9-нд болж, Намын дарга Н.Алтанхуяг, ЕНБДарга Д.Эрдэнэбат, Нийслэлийн Ардчилсан намын дарга Ш.Түвдэндорж, УИХ дахь АН-ын бүлгийн ахлагч Ч.Сайханбилэг, УИХ-ын гишүүн Э.Бат-Үүл нар илтгэл тавилаа. Энэхүү хаалтын арга хэмжээнд УИХ-ын Дэд дарга Г.Батхүү, УИХ-ын гишүүн П.Алтангэрэл, Н.Батбаяр, Кекушюзан Д.Батбаяр, Г.Баярсайхан, Р.Гончигдорж, Л.Гүндалай, Д.Зоригт, С.Ламбаа, Д.Одхүү, З.Энхболд, С.Эрдэнэ нар болон нийслэл, дүүргийн ИТХ-ын төлөөлөгчид, Нийслэлийн төвийн зургаан дүүргийн 7000 гаруй гишүүн дэмжигчид оролцжээ.

АРДЧИЛСАН НАМ, ДЭЛХИЙН АРДЧИЛСАН ХОЛБООНЫ БҮРЭН ЭРХТ ГИШҮҮН БОЛОВ



Ардчилсан нам, Дэлхийн Ардчилсан хүчний холбоонд арав гаруй жил албан бус гишүүний статустай байсны эцэст 2011 онд албан ёсны бүрэн эрхт гишүүн болов. АН-ын дарга, Тэргүүн шадар сайд Н.Алтанхуяг, УИХ-ын гишүүн, Их Британи-Монголын Парламентын бүлгийн дарга Р.Амаржаргал, Гүйцэтгэх зөвлөлийн гишүүн Л.Эрдэнэчимэг, намын нарийн бичгийн дарга М.Жадамбаа нар Английн Лондон хотноо “21-р зуунд эрх чөлөө, ардчиллыг бэхжүүлэх нь” сэдвийн дор зохион байгуулагдсан Дэлхийн Ардчилсан хүчний холбооны хуралд оролцож, улмаар Монголын Ардчилсан нам Дэлхийн Ардчилсан хүчний холбооны бүрэн эрхт гишүүн болсон юм. Энэ үеэр АН-ын дарга Н.Алтанхуяг Их Британийн Консерватив намын лидер, Ерөнхий сайд Дэвид Камеронтой албан өрөөнд нь уулзаж, намуудын болоод хоёр улсын цаашдын хамтын ажиллагааг өргөжүүлэх талаар яриа өрнүүлжээ.

РОТАЦИ ӨНЖИХ ҮЗХ-НЫ ШИЙДВЭР

ҮЗХ-ны 34-р хурал 2011 оны гуравдугаар сарын 9-нд болсон ба намын дүрмэнд заасны дагуу жил бүр явагддаг дотоод сонгуулийг өнжихөөр шийдвэрлэжээ. ҮЗХ-ны гишүүдийн дийлэнх олонхи намын дүрмийг өөрчлөх, шинэчлэх асуудал хэлэлцэгдэж байгаа үед ротаци явуулах нь дотоодын хагаралд хүргэнэ гэж үзсэн байна. ҮЗХ-ны 228 гишүүний 172 нь оролцсон билээ.

АН-ын дүрмээр жил бүр Ротацийн сонгууль явуулж, ҮЗХ-ны гишүүдийн 1/3 нь шинэ гишүүдээр ээлбэгддэг нэг сайн талтай ч ротаци тойрсон дагалдаад маргаан үүсдэг сөрөг тал бас бий юм. Тиймээс сонгуулийн өмнөх жил ҮЗХ-ны Ротацийн сонгууль явуулах нь хэр оновчтой вэ гэдгийг гишүүдээрээ хэлэлцүүлэхээр АН-ын дарга шийдсэн байдаг. Угтаа УИХ-ын сонгуулийн жилд Ротацийн сонгууль явуулахгүй дүрэмтэй боловч АН-ын дарга энэ удаад өөрчлөх санал дэвшүүлэхээр шийдвэрлэсэн гэсэн үг юм. Энэ нь ч цаг үеийн байдалд тулгуурлаж намын дотоод эв нэгдлийг хангах, цаашлаад намын бодлогын залгамж чанарыг хадгалах ач холбогдолтой асуудал байв. Мөн УИХ, НИТХ, аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга ҮЗХ-ны гишүүн байна гэсэн заалт нь АН-ын дотоод эв нэгдлийг хамгаалж байгаа мэт харагдавч намын анхан шатны байгууллагын хувьд таатай нөхцөл огт биш гэсэн шүүмжлэлийг нухацтай хэлэлцэх шаардлага байв.

Намын дүрмийг өөрчлөхөд ҮЗХ-ны гишүүдийн 2/3 нь зөвшөөрсөн байх ёстой бөгөөд тиймдээ ч дүрэм журманд өөрчлөлт оруулан тухайн нөхцөлд Ротацийн сонгууль явуулахгүй байх саналыг тойрон ширүүн маргаан, мэтгэлцээн өрнөсөн юм.

ҮЗХ-ны гишүүн Д.Нямхүү:

Дүрмийн өөрчлөлтийн шалтгаан тодорхойгүй байна. Н.Алтанхуяг дарга сая нэгийг нь нөгөөтэй нь холиод асуудлаа тодорхой бус тайлбарлалаа. Шалтгаан нь юу вэ? Сонгуулийн өмнө хэний өмнө хаалгыг хааж байгаа юм бэ? УИХ-ын сонгуульд зөвхөн ҮЗХ-ны гишүүн нэр дэвшинэ гэвэл яах болж байна?

АН-ын дарга Н.Алтанхуяг:

- Нямхүү буруу ойлгоод байна. Эсвэл дутуу ойлгосон байна. Ротаци хийхгүй гэж яриагүй. Одоо байгаа ҮЗХ-ны гишүүдэд энэ өөрчлөлт нөлөөлөхгүй. 2012 оны УИХ-ын сонгууль болох гэж

байхад ротаци явуулж бужигнаад яах вэ гэж байгаа юм. Нөхөн сонгууль явуулах боломж байгаа учир ҮЗХ-нд орох асуудал нээлттэй. Энэ нь АН-д эерэг зүйл болно.

Н.Пүрэвдорж (Ховд):

- УИХ-д нэр дэвших гэж байгаа хүмүүс маань ҮЗХ-д энэ жилийн ротациар орж ирэх бодолтой байсан. Гэтэл тэр нь энэ өөрчлөлтөөр хаагдчихлаа.

Д.Эрдэнэбат (ЕНБД):

- Намын дүрмийн өөрчлөлт үүгээр дуусч байна. АН ард түмний нам байя гэж байгаа юм. Нэр дэвших эрх бүх гишүүдэд бий. Хэн нэгний өмнөх хаалгыг хаах гээд байгаа юм огт биш.

Энэ мэт яриа өрнөсний дараа Ротацийн сонгуулийг тухайн жил явуулахгүй байх саналыг дэмжих эсэх дээр санал хураах болж дэмжинэ гэдгээ бичгээр илэрхийлсэн зургаан гишүүний саналыг хүчинтэйд тооцохоор болов. Эцсийн дүн гарахад 172 гишүүний гурваас бусад нь энэ жил Ротацийн сонгууль явуулахгүй байхыг дэмжжээ.

Ингээд АН-ын Үндсэн дүрэм болоод журманд өөрчлөлт оруулах тогтоолыг батлав. Үндсэн дүрмийн 6.4.1-р заалтын “Жил бүр Дотоод сонгуулийн хорооноос тогтоосон квотоор, тогтсон хугацаанд ҮЗХ-ны гишүүний эргэлтэнд хамрагдах (ротаци) сонгууль явагдана” гэснийг, 6.4.2-р заалтын “эргэлтэнд орсон” гэснийг, мөн 5.2 заалтын “Жил бүр нийт гишүүдийн 1/3 дээр эргэлтэнд хамрагдах (ротаци) сонгууль явагдана” гэснийг тус тус хүчингүй болгов. Мөн АН-ын үндсэн дүрмийн 5.2.1-ийн Нийслэлийн АН-ын Зөвлөлдөх хороон нь “120” гэснийг “135” гэж өөрчилсөн тул Намын орон нутгийн байгууллагуудын үйл ажиллагаа, зохион байгуулалтыг зохицуулахтусгай журмын 3.1.1-ийн Нийслэлийн АН-ын Зөвлөлдөх хороо нь “120” гэснийг “135” гэж, 3.1.1-р заалтын “Жил бүр нийт гишүүдийн 1/3 дээр эргэлтэнд хамрагдах (ротаци) явагдана” гэснийг хүчингүй болголоо. Эдгээрээс гадна АН-ын анхан шатны байгууллага, удирдах бүрэлдэхүүнийг сонгох сонгуулийн журмын 3.2 ба 3.4-р заалтыг хүчингүй болгоод ҮЗХ-ны бүрэн эрхээс “Ардчилсан намын гишүүний татварын тухай журам”-ын 2.2, 6.1 дэх заалтуудад өөрчлөлт оруулах эрхийг намын Гүйцэтгэх зөвлөлд шилжүүлсэн билээ.

АН-ын Гүйцэтгэх зөвлөл хуралдаад (2011.03.22) Үндсэн

дүрмийнхээ өөрчлөлтийн эцсийн найруулгаар зассан төсөл, УИХ-ын сонгуульд нэр дэвшихээ илэрхийлсэн гишүүний төлөх татварын хэмжээ, төлөх хугацаа зэрэгт оруулах өөрчлөлтийн талаар хэлэлцэв. Ингэснээр УИХ-ын сонгуульд нэр дэвших хүн намд 50 сая төгрөгийн татвар төлөх болгон баталсан байна.

Дотоод хагарал, тэмцлээс хэдий сэргийлсэн ч хагарал хэдийнэ явагдаж эхэлсэн байв. Хамтарсан Засгийн газраас Ардчилсан намыг гаргах, гарах, МАН дангаараа засгийн эрх барих, бариулах тухай асуудал 2011 он гаруут эрчимтэй яригдаж эхлэв. АН-аас З.Энхболд, С.Эрдэнэ, Р.Амаржаргал, МАН-аас Э.Мөнх-Очир, Ж.Энхбаяр нар дээрх яриаг оройлж байлаа. З.Энхболдын хувьд намын дарга болох, цаашлаад Засгийн газрын тэргүүн болох сонирхол давамгайлж байсан бол, С.Эрдэнийн хувьд мөн л намыг тэргүүлэх, үгүй гэхэд шийдвэр гаргах түвшинд очих, ингэснээрээ Засгийн газрын кабинетад багтахыг хүсч байсан нь нууц биш байв.

М.ОЛБРАЙТ: АРДЧИЛСАН НАМТАЙ ХАМТАРЧ АЖИЛЛАНА



АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан, Үндэсний ардчиллын хүрээлэнгийн захирлуудын зөвлөлийн дарга М.Олбрайт 2011 оны дөрөвдүгээр сарын 21-нд АН-ын дарга Н.Алтанхуяг, УИХ-

ын гишүүн Э.Бат-Үүл, Р.Амаржаргал, намын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Эрдэнэбат нартай уулзаж ярилцлаа. Тэрбээр “Монголын ардчилал Азид загвар болсон. Тиймээс цаашид энэ ололт амжилтаа улам боловсронгуй болгох хэрэгтэй. Миний удирдаж буй хүрээлэн АН-тай хамтарч ажиллахад хэзээд бэлэн” хэмээжээ. Хатагтай М.Олбрайт Ардчилсан хувьсгалын удирдагчдын нэг С.Зориг агсны хөшөөнд хүндэтгэл үзүүлэн цэцэг өргөөд, АН-ынхантай дурсгалын зураг татуулсан юм.

МАН ДОНДОГ ГИШҮҮНЭЭ ХАМГААЛЖ ҮЛДЭВ

Мөн оны зургадугаар сарын 28-нд УИХ-ын гишүүн Д.Дондогийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай албан бичгийг Улсын Ерөнхий Прокурорын газраас УИХ-ын дарга Д.Дэмбэрэлд хүргүүлжээ. УИХ-ын гишүүн Д.Дондогт Эрүүгийн хуулийн 148.4 буюу залилангийн хэрэг үйлдсэн үндэслэлээр хэрэг үүсгэсэн байна. Харин, Хууль зүйн байнгын хорооны дарга Д.Одбаяр “УИХ-ын тухай хуулийн 6.9.1-д “УИХ-ын гишүүнийг гэмт хэрэг үйлдэх явцад эсвэл гэмт хэргийн газар эд мөрийн баримттай баривчилсан улмаар Ерөнхий прокурорын газраас бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх санал оруулсан бол УИХ хэлэлцэнэ” гээд заачихсан байгаа. Тиймээс энэ асуудлыг УИХ хэлэлцэх боломжгүй болчихож байна. Ийм хариу өгсөн”⁵¹ гэж хэлжээ. Өөрөөр хэлбэл, МАН хүч түрэмгийлсэн, эрдсэн, намын нэр хүндээ бодсон алхам хийсэн байдаг. Улсын Ерөнхий Прокурорын газраас ХЗБХ-ны дарга Д.Одбаярын ирүүлсэн хариуг хангалтгүй гэж үзсэн тул Д.Дондог гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх асуудлыг 7-р сарын 1-нд УИХ-ын даргад дахин тавив. Шалтгаанаа Монгол Улсын Үндсэн хуулийн 29 дүгээр зүйлийн гурав дахь хэсэгт “УИХ-ын гишүүн гэмт хэрэгт холбогдсон тухай асуудлыг УИХ-ын чуулганаар хэлэлцэж, бүрэн эрхийг нь түдгэлзүүлэх эсэхийг шийдвэрлэнэ” гэсэн заалтыг зөрчсөн хэмээн тайлбарлажээ. Гэвч ХЗБХ-ны дарга Д.Одбаяр өмнө хэлсэн шалтгаанаа давтаад, УЕП-ын илгээсэн бичгийг хууль зүйн үндэслэлгүй, иймд хүлээн авах боломжгүй хэмээсэн тайлбараа давтан илгээлээ. УЕП-ын газар ес хоногийн дараа гурав дахь удаагаа хандав. “Таван тэрбум

⁵¹ Одбаяр,Д.: УИХ-ын гишүүнийг гэмт хэргийн газар нь баривчилсан бол эрхийг нь түдгэлзүүлдэг (ярилцсан Я.Мөнгөн), -ӨС.№159 (2011.06.30)

орчим төгрөгийн хохирол учруулсан олон яллагдагчтай энэ хэргийн мөрдөн байцаалтын ажиллагаа зогсч, яллагдагч нар ял завших байдал үүсч байгааг УИХ анхааралдаа авч Д.Дондог гишүүний бүрэн эрхийн түдгэлзүүлж өгөхийг дахин хүсчээ”⁵². Харин УИХ-ын ХЗБХ-ны дарга Д.Одбаяр 7-р сарын 19-нд өмнөх байр сууриа баталсан мэдэгдэл хийлээ.

УИХ-ЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА

Not secure | legalinfo.mn/law/details/351?lawid=351

ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛИЙН НЭГДСЭН СИСТЕМ

Хууль зүйн акт | Нэмэлт өргөмтөл | Жагсаалт руу буцах

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2011 оны 12 сарын 15 өдөр

Төрийн ордон, Улаанбаатар хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ
Шинэчилсэн найруулга

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дугаар зүйл Хуулийн зорилт

1.1 Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн үндсэн зарчим, журмыг тодорилгойт, Монгол Улсын иргэний сонгох, сонгогдох эрхийг хангах, сонгуулийг зохион байгуулж явуулдагтай холбогдон үүсэн харьцахад зориулагдаж оршино.

2 дугаар зүйл Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтооход

2.1 Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль тогтооход нь Монгол Улсын Үндсэн хууль[1], энэ хууль болон өдгөө хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад өгтээс бүрдэнэ.

3 дугаар зүйл Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

3.1 Энэ хуульд өргөтсөн дэвшил нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1 "иргэн" гэж Монгол Улсын сонгуулийн эрх бүхий иргэнийг;

3.1.2 "сонгуулийн эрх бүхий иргэн" гэж арван найман нас хүрсэн, Иргэний хуулийн[2] 15.1-д заасан эрх зүйн бүрэн чадвартай иргэнийг;

3.1.3 "нэр дэвшил" гэж энэ хуульд заасан журмын дагуу Монгол Улсын Их Хурлын гишүүд нэр дэвшиж бүртгүүлэн Улсын Их Хурлын гишүүд нэр дэвсгэлийн үнэмлэх авсан иргэнийг;

3.1.4 "арван найман нас хүрсэн" гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдөрөө тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байгааг;

3.1.5 "хорин таван нас хүрсэн" гэж тухайн иргэний төрсөн он, сар, өдөрөө тоолоход сонгуулийн санал авах өдөр буюу түүнээс өмнө тухайн насанд хүрсэн байгааг;

3.1.6 "нашын гишүүн" гэж улс төрийн альянст нэгдэж гишүүнээр элсэн бүртгүүлсэн иргэнийг;

3.1.7 "төрийн өмчт хуулийн этгээд" гэж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн[3] 13, 15 дугаар зүйлд заасан төрийн байгууллага, албан газар, төрийн өмчт үйлдвэрийн газраг;

3.1.8 "төрийн өмчийн оролцогчтой хуулийн этгээд" гэж Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан төрийн өмчийн хуучинтай буюу төр хувь хөрөнгөө оруулсан хуулийн этгээдийг;

УИХ-ын ээлжит сонгууль болохоос бараг хоёр жилийн өмнөөс эхлэн УИХ-ын сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын тухай асуудал хэлэлцэгдэж эхэлжээ. УИХ-д олонхи суудалтай, улс төрийн гол хоёр хүчин сонгуулийн холимог тогтолцоон дээр санал нэгдсэн ч харьцаан дээр зөвшилцөж чадахгүй байв.

⁵² Дорж.Д. Д.Дондог гишүүний бүрэн эрхийг түдгэлзүүлэх бичгийг гурав дахь удаагаа илгээв, -ӨС.№170 (2011.07.18)

Тоглоомын дүрмийг тогтоох хувилбарууд

АН-ын хувьд 26 суудал нь мажоритар, 50 суудал нь пропорциональ хувилбарыг дэмжиж байсан бол МАН мажоритар нь 52, пропорциональ нь 24 гэсэн хувилбарыг түлхүү дэмжиж байв. Өөр нэгэн сонголт, боломжит хувилбар нь 38:38 гэсэн хувилбар байлаа. “УИХ дахь АН-ын бүлгээс томилогдсон Сонгуулийн хуулийн төсөл дээр зарчмын зөрүүтэй санал, зүйл заалтын талаар МАН-ын бүлэгтэй зөвшилцөх ажлын хэсэгт Ч.Сайханбилэг, Э.Бат-Үүл, Л.Гантөмөр, Г.Батхүү, З.Энхболд нар оржээ. МАН-ын бүлгээс байгуулагдсан ажлын хэсэгт УИХ-ын гишүүн Н.Энхболд, Д.Лүндээжанцан, Ц.Даваасүрэн, Ж.Сүхбаатар, Ч.Хүрэлбаатар нар орж ажиллаж байна”⁵³. Ажлын хэсэг байгуулагдсан, хуралдсан, зөвшилцсөн хэдий ч ямар нэгэн үр дүнд хүрээгүй тул АН-ын зүгээс УИХ-ын чуулганы хуралдаан, байнгын хорооны болон бүлгийн хуралдаанд суухгүй, бүлгийн хуралдаан зарлахгүй байх шийдвэр гаргажээ. “Бүлгийн дарга Ч.Сайханбилэг “Сонгуулийн тухай хуулийг өнгөрсөн долоо хоногийн УИХ-ын чуулганы хуралдаанаар оруулан хэлэлцсэн. Ийн хэлэлцэх явцад зарчмын зөрүүтэй болон гишүүдийн гаргасан 300 орчим саналаар санал хураалт явуулж дэмжээд байсан. Энэ хуулийн эцсийн хэлэлцүүлгийг хийхэд ердөө хоёр гуравхан асуудлыг л харилцан тохиролцож, шийдвэрлэх үлдээд байсан юм. Гэтэл МАН-ын зүгээс манай гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрсөнгүй. Бид ч МАН-ын дэмжиж буй хувилбартай эвлэрч чадахгүй. Учир нь Сонгуулийн тухай хуулийг шинэчлэн батална гэдэг тойрог өмчилсөн, хувийн эрх ашиг хайсан байдлыг устгаж улс орны эрх ашгийн асуудлыг нэн тэргүүнд тавих явдал. Гэтэл МАН-ын зүгээс ингэхийг хүсэхгүй байна. Хуучин 76 жижиг тойргоор сонгууль явуулдаг байсныг 26 том тойрог болгон өөрчилсөн. Гэтэл 26 том тойргийг МАН-ынхан буцаагаад 52 жижиг тойрог болгох гээд байна. Үүнийг бид яавч хүлээн зөвшөөрөхгүй. Тиймд бид МАН-ыг ямар нэгэн эерэг шийдвэр гаргатай өнөөдрөөс эхлэн УИХ-ын чуулган, байнгын хороо, намын бүлгийн хуралд оролцохгүй байхаар боллоо”⁵⁴ гэсэн байна.

Байдал даамжирч УИХ-ын чуулганы зургадугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаар Ардчилсан намын бүлгийн дарга

⁵³ Дорж.Д. Хоёр нам зөвшилцлөө эхлүүлэв, -ӨС.№152 (2011.06.22)

⁵⁴ Мөнхтөр.Л. Ардчилсан намынхан УИХ-ын ямар нэг үйл ажиллагаанд оролцохгүй гэж мэдэгдлээ, -ӨС.№153 (2011.06.23)

Ч.Сайханбилэг намынхаа байр суурийг илэрхийлж завсарлага авлаа. Харин МАН-ын бүлгийн дарга Д.Лүндээжанцан “Асуудалд миний хувь хүний байдал нөлөөлж байна гэж бусад нөхөд минь бодож байгаа бол би бүлгийн даргын суудлаа албан ёсоор өгөх хэрэгтэй гэж бодож байна. Тиймд би МАН-ын бүлгийн даргын суудлаа албан ёсоор тавьж өглөө хэмээн мэдэгдсэн юм”⁵⁵. УИХ-ын гишүүн Д.Лүндээжанцан, Сонгуулийн тухай хуулийн ажлын хэсгийг ахалж байхдаа 100 хувь пропорциональ хэлбэрт түшиглэсэн хуулийн төсөл өргөн барьж байсан нь ч ийм шийдвэрт хүрэхэд хувь хүнийх нь зүгээс нөлөөлсөн нь лавтай. Мөн УИХ дахь МАН-ын бүлгийн дэд дарга Д.Дондог ажлаа сайн дураар өгсөн ба МАН-ын бүлгийн ээлжит бус хуралдаанаар УИХ-ын гишүүн Ө.Энхтүвшинг бүлгийн даргаар, дэд даргаар Су.Батболдыг сонгосон байна.

УИХ-ын гишүүн З.Энхболд “Тойргийн тоог жижигрүүлэх тусам мөнгөтэй хүмүүс л орж ирэх магадлал нэмэгдэнэ. 1990 онд 340 тойрогтой байсныг дараагаар нь өөрчлөөд 76 болгосон бол өнгөрсөн сонгуулиар 26 болгож системтэйгээр бууруулаад байгаагийн учир нь мөнгөөр биш үзэл баримтлал, мөрийн хөтөлбөрөөрөө уралддаг, мөнгөний хамаарлыг багасгахыг зорьж байгаа хэрэг. Уг нь пропорциональ сонгууль явуулбал намыг дугуйлдаг. Гэвч АН зөвхөн нам дугуйлна гэдгээсээ бууж өгөөд нам, хүн хоёрыг зэрэг дугуйлж болох юм гэсэн байр сууриа илэрхийлж байгаа. Хүний нэр дугуйлах нь намын гаргасан жагсаалтыг шинээр эрэмбэлэхэд хэрэгтэй. Сонгуулийн дараа сонгогчдоос авсан саналаар нь дахин эрэмбэлнэ. Намын гаргасан 50 хүний жагсаалтын хамгийн сүүлд бичигдсэн ч байлаа сонгогчдын саналаар нэгдүгээрт орж ирэх бололцоотой. Ингэснээр намын даргыг тойрон хүрээлдэг хүмүүс парламентад сууна гэсэн хардлага гарахгүй. Намуудын авсан саналын тоогоор суудал хуваарилна”⁵⁶ гэж тайлбарласан байдаг.

Бүх нийтийн санал асуулга явуулах боломжгүй

УИХ дахь МАН-ын бүлгийн дарга Ө.Энхтүвшин, АН-ын бүлгийн дарга Ч.Сайханбилэг нар 6-р сарын 30-нд хамтарсан мэдэгдэл

⁵⁵ Мөнхтөр.Л. Ардчилсан намын бүлэг завсарлага авав,-ӨС.№154 (2011.06.24)

⁵⁶ Энхболд.З: Бүр болохгүй бол санал асуулга явуулж ард түмнээсээ асууя (ярилцсан Д.Доржпагма),-ӨС.№154 (2011.06.24)

хийлээ. Хоёр нам ерөнхийдөө Сонгуулийн тухай хуулийг хэрхэн шийдвэрлэхийг бүх нийтийн санал асуулгаар тодруулах, чингэхдээ Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал асуулгыг давхар авах тохиролцоонд эхний ээлжинд хүрсэн байна. “Сонгуулийн хуулийн тогтолцооны талаарх ард нийтийн санал асуулгыг ирэх есдүгээр сарын сүүлийн долоо хоногийн ням гарагт орон даяар нэгэн зэрэг явуулна. Харин намрын чуулганы нээлт буюу аравдугаар сарын 3-ны үеэр дүнг гаргахаар төлөвлөжээ. Тиймээс Сонгуулийн тухай хууль, Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах зэрэг асуудлууд ирэх намрын чуулганаар нэг мөр шийдэгдэх нь. Ард нийтийн санал асуулга явуулах тухай хуулийн төслийг ирэх долоо хоногт УИХ-д өргөн барихаар болжээ. Энэхүү хуулийн төслийг УИХ-ын гишүүдийн гуравны хоёр нь дэмжсэнээр хүчин төгөлдөр батлагдах юм байна”⁵⁷ гэсэн хэдий ч 7-р сарын 4-нд УИХ дахь АН-ын бүлэг хуралдан ард нийтийн санал асуулга явуулах нь цаг хугацааны хувьд ч, эдийн засгийн хувьд ч, үүрэг хариуцлагын зарчмын хувьд ч боломжгүй, 38:38 харьцаатай хувилбараар сонгууль явуулах нь зүйтэй хэмээсэн санал дэвшүүлжээ. Гол шалтгаан нь санал асуулга явуулахад 6-8 тэрбум төгрөг шаардлагатай, нөгөөтэйгүүр санал асуулгаар Үндсэн хуулийн өөрчлөлт, шинэчлэлт дэмжигдэхгүй бол хуулийн дагуу ойрын найман жилд шинэчлэл хийх боломжгүйд оршиж байв.

Хэлэлцээр үргэлжилсээр

МАН-ын бүлгийн 10-р сарын 10-ны өдрийн хуралдаанаар 28:48 гэсэн хувилбарыг дэвшүүлэхээр тогтлоо. “Үүнээс өөр тоог ямар ч нөхцөлд хөндөхгүй гэдэг дээрээ бүлгийн гишүүд тохирсон”⁵⁸ гэж МАН-ын бүлгийн дарга Ө.Энхтүвшин мэдэгдэв. Харин 11-р сарын 7-нд хуралдсан бүлгийн хурлаараа АН-ын санал болгосон хоёр асуудлыг хүлээж авах болжээ. “Энэ тухай бүлгийн дарга Ө.Энхтүвшин мэдэгдэхдээ “Сонгуулийн тухай хуулийг батлах зайлшгүй шаардлага байгаа. Уг хуулийг батлах хугацаа ч хомс болсоор байна. Тиймээс манай бүлэг өнөөдрийн хуралдаанаараа

⁵⁷ Мөнгөн.Я. Ардчилсан намын бүлэг ард нийтийн санал асуулгыг дэмжжээ, - ӨС.№161 (2011.07.02)

⁵⁸ Төр.Л. МАН-ын бүлэг 28:48 гэсэн хувилбар дээр хатуу зогсох гэнэ, - ӨС.№243 (2011.10.11)

АН-ын тавьж буй хоёр асуудлыг хүлээж авах нь зөв юм гэдэг дээр санал нэгдлээ. Энэ тухай ч хоёр нам хамтарсан хамтарсан Засгийн газрыг байгуулах үедээ зөвшилцлийн гэрээндээ тусгасан байгаа. Тэгэхээр Сонгуулийн тухай хуулийг нэн даруй гаргахын тулд АН-ын гаргасан 48 мандаттай 26 тойрог байна гэсэн саналыг хүлээн авлаа. Мөн хүн ам, газар нутгийн байрлалыг харгалзан үзэж Улаанбаатар дахь мандатын тоог нэмэх шаардлагатай гэсэн саналыг ч хүлээн авахаар болсон. Ингэхдээ бүр тодорхой болгож орон нутагт 34, нийслэлд 14 мандаттай байна гэж тусгаж өгсөн”⁵⁹ гэсэн байна.

Сонгуулийн хууль батлагдав

Асуудал гацсаар, асуудлыг хэлэлцсээр, зөвшилцсөөр бүр 12-р сарын 13-нд л ямар нэгэн гарц, шийдэлд хүрэх эхлэл тавигдлаа. Учир нь Төрийн байгуулалтын байнгын хороо мөн өдөр хуралдаж “хэлэлцсэн гол зүйл нь Сонгуулийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл байв. Хоёр нам тохиролцохгүй байсан асуудлаа шийджээ. Тэд тойрогт 28-аас дээш хувийн санал авсан намаас нэр дэвшигч болон бие даагч УИХ-ын гишүүн болно. Харин сонгогчдын 28 хувийн санал авч ялагдсан бол намын жагсаалт руу шилжихээр болж тохирчээ. Мэдээж энэ нь намгүй бие даагчдад хамаагүй болж байгаа юм... Аливаа нам, эвсэл сонгуульд 76 нэр дэвшигчийг нэг жагсаалтаар оруулах юм байна. Тэдний 48 нь тойрогт, 28 нь намын жагсаалтаар сонгогдоно... Улсын хэмжээнд 26 тойрог байгуулах ажлыг сонгуулиас зургаан сарын өмнө хийнэ. Тэгэхээр ирэх нэгдүгээр сарын 1-нээс 26 тойрогтоо байгуулах болох нь”⁶⁰.

УИХ-ын чуулганы 12-р сарын 15-ны өдрийн хуралдаанаар Сонгуулийн тухай хуулийн нэгтгэсэн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж санал хураалтад 42 гишүүн оролцсоноос 85,7 хувийн саналаар Сонгуулийн тухай хууль батлагдлаа. УИХ дахь АН-ын бүлгийн дарга Ч.Сайханбилэг “АН-ын бүлгийн хүсч байсан тогтолцоо хуульд бүрэн тусч чадсангүй. Бид пропорциональ тогтолцоог давамгайл оруулах ёстой гэж үзэж

⁵⁹ Мөнхтөр.Л. МАН-ын бүлэг АН-ын саналыг хүлээн авав,-ӨС.№269 (2011.11.08)

⁶⁰ Мөнгөнцэцэг.Я. Нэр дэвшигчийн үнэмлэхээ авсан хойноо нэрээ татахыг хориглоно,-ӨС.№300 (2011.12.14)

байсан. Гэвч мажоритар хувилбар давамгайллаа. Гэхдээ бодот байдлыг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Ардчилсан нам 27 суудалтай болохоор 100 хувь биелэхгүй нь эхнээсээ мэдэгдэж байсан”⁶¹ хэмээн дүгнэв. Цааш нь Сонгуулийн хуулийн ач холбогдол, шинэчлэл, өөрчлөлтийн тухай “Нэг сонгогч нэг санал гэсэн зарчим биеллээ олно. Хэсгийн хороо зөвхөн санал авах байр болон хувирснаар сонгогчдын нэрийг хасах гэх мэтийн элдэв булхай луйвар гарах үүд хаагдлаа. Гадаадад байгаа монголчууд анх удаа сонгуульд оролцоно. Сонгууль луйвардахаар завдсан этгээдэд эрүүгийн хариуцлага ногдуулахаар боллоо. Хэвлэл мэдээллийн байгууллага, сонгуульд оролцож байгаа субъектүүд ч хариуцлагатай байхыг хуулиар нарийн заагаад өгчихлөө. Ингээд яриад байвал чансаатай өөрчлөлтүүд орсон”⁶² хэмээн тайлбарласан байдаг.

Цэцийн шийдвэрийг хүлээж авахгүй

Үндсэн хуулийн Цэцийн дунд суудлын хуралдаан 2012 оны 3-р сарын 28-нд болж Сонгуулийн хуулийн зарим заалт хүчингүй болгосон юм. 26 тойргийн 48 нэр дэвшигчийг сонгох санал хураалт цэвэр мажоритар тогтолцоогоор явагдах бөгөөд олонхийн санал авсан нэр дэвшигч шууд сонгогдохоор болсон байна. Өөрөөр хэлбэл, тойрогт ялалт байгуулаагүй ч сонгогчдын 28 хувийн санал авсан нэр дэвшигч намын жагсаалтруу шилжиж УИХ-ын гишүүн болохгүй болжээ. Чингэснээр нам өөрөө жагсаалтанд бичигдэх хүнээ сонгож, эрэмбэлэх болсон байна. Үндсэн хуулийн цэцийн шийдвэрийг УИХ-ын хаврын чуулганаар хэлэлцэж хүлээн авах эсэхийг шийдэх учиртай юм. АН-ын бүлгийн дарга Ч.Сайханбилэг “Үндсэн хуульд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү УИХ хэрэгжүүлнэ гэж заасан байдаг. Гэтэл Үндсэн хуулийн Цэцийн гаргасан шийдвэр нь өнөөдөр сонгуулийн ямар тогтолцоо, бодлогоор явахыг Цэц өөрөө УИХ-д заасан хэрэг боллоо. Энэ нь УИХ-ын өмнөөс бүх асуудлыг шийдсэн байдал болж байгаа юм. Ийм байдал нь эргээд Үндсэн хуулийн хамгийн суурь зарчим, хууль тогтоох эрх мэдэлрүү Цэц дэндүү халдаж

⁶¹ Билгүүн.А, Мөнхтөр.Л. Сонгуулийн тухай хууль батлагдлаа,-ӨС.№302 (2011.12.16)

⁶² Сайханбилэг.Ч: АН 22 настай ч 90-тэй намаасаа хамаагүй илүү туршлагатай болчихсон байхгүй юу (ярилцсан Я.Мөнгөнцэцэг), -ӨС.№307 (2011.12.22)

байгаагийн илрэл”⁶³ гэж мэдэгдсэн бөгөөд АН-ын зүгээс Цэцийн шийдвэрийг хүлээж авах боломжгүй гэж үзлээ. Харин УИХ дахь МАН-ын бүлэг Цэцийн шийдвэрийг хүлээж авах байр сууртай байв. Цэцийн дүгнэлтийг Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцээд, хүлээж авах нь зүйтэй гэсэн бол Хууль зүйн байнгын хороо хүлээж авах боломжгүй гэж үзэв.

Чингээд УИХ-ын 4-р сарын 12-ны чуулганаар УИХ-ын сонгуулийн тухай хуулийн зарим зүйл заалт Үндсэн хууль зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн Үндсэн хуулийн Цэцийн дүнэлтийг хэлэлцлээ. Ингээд мөн сарын 19-ний өдрийн чуулганаар Цэцийн дүгнэлтийг хүлээж авах боломжгүй гэж үзэв. Үндсэн хуулийн Цэцийн Их суудлын хуралдаан 5-р сарын 2-нд боллоо. Хуралдаанаас “УИХ-ын сонгуулийн 26 тойрогт 48 мандатын төлөө нэр дэвшигчдээс тус тусын тойрогтоо ялагдал хүлээсэн боловч тэдгээрээс 28 ба түүнээс дээш хувийн санал авсан нэр дэвшигч УИХ-ын гишүүнээр сонгогдох боломжийг олгож, улмаар зарим нэр дэвшигч нарт давуу байдал бий болгосон нь Үндсэн хуульд заасан иргэний сонгох, сонгогдох эрхэд харшилсан” хэмээн шийдвэрлэжээ.

ХАМТАРСАН ЗАСГААС ГАРАХ ДОХИО

УИХ-ын гишүүн Э.Бат-Үүл зургадугаар сарын 30-нд хийлгэсэн хэвлэлийн хурлынхаа үеэр Ерөнхий сайд С.Батболдыг огцруулах санал өргөн барихаар болсноо мэдэгдсэнээр хамтарсан Засгийн газрыг огцруулах, Засгийн газрын тэргүүнийг огцруулах, цаад утгаараа хамтарсан Засгийн газраас АН гарах асуудал дэгдэх эхлэл тавигдлаа.

УИХ-ын 57-р тогтоолыг буруу шаах нь

Аравдугаар сарын 3-нд нээсэн УИХ-ын намрын чуулганы үеэр АН-ын С.Эрдэнэ, З.Энхболд, МАН-ын Б.Бат-Эрдэнэ, Д.Тэрбишдагва нарын 20 гишүүн “Засгийн газар Оюу толгойн алдаатай гэрээгээ засагтун” хэмээсэн цаас өмнөө дэлгэсэн байв. УИХ-ын 57 дугаар тогтоолын дагуу Оюу толгойн хувьцааны эзэмшлийг тавиас

⁶³ Мөнх.Л. АН-ынхан Цэцийн гаргасан шийдвэрийг хүлээн зөвшөөрөхгүй, - ӨС.№090 (2012.04.10)

доошгүй хувьд хүргэнэ, чингэхэд ойролцоогоор гучин жил зарцуулагдах, өөрөөр хэлбэл техник технологи өдрөөс өдөрт хөгжиж байгаа өнөө цагт хөрөнгө оруулагч тал жилд олборлох хэмжээгээ нэмэгдүүлэх замаар Монголын баялгийг цөлмөх магадлалтай гэж тэд үзсэн байна. Үнэндээ энэ нь чадвал Засгийн газрыг огцруулах, ядвал Ерөнхий сайдыг огцруулах шалтаг л байлаа. Бас үнэндээ бол төр тухайн ордын 34 хувь, цаашлаад 50, 60, 70...хувь эзэмших нь төдий хэмжээний хариуцлага, хөрөнгө оруулалт шаардагдах ёстой болно. Төдий хэмжээний хөрөнгө оруулах эдийн засгийн бололцоо Монгол Улсад байхгүй тул зээл авна. Төдий хэмжээний зээл авч, зээлийн хүү төлж байхаар татвар, роялти авах нь зүйтэй бөгөөд илүү эрсдэлгүй, илүү ашигтай хувилбар байсан юм. Өөрөөр хэлбэл, даах ачаагаа үүрч, шингээх хоолоо зооглох л асуудал байлаа.

Нийтлэлч Б.Батбаяр “Монгол Улсын хуулиар газрыг 60 хүртэл жилээр түрээслүүлж болно. Монголын оролцоотой Оюу толгой компани ордын газрыг ашиглах эрхтэйгээр 30 жилээр түрээслэж авсан. Энд нийтдээ 5-6 тэрбум орчим долларын хөрөнгө оруулалт хэрэгтэй. Одоо 2.6 тэрбумын буюу тавин хувийн хөрөнгө оруулалт хийгдчихээд байгаа. Төлөвлөсөн ёсоор хойтон ашиглалтанд орох ба тэр үеэсээ бүтээгдэхүүнээ гарган борлуулж эхэлнэ. Нэг үгэндээ компани мөнгө хийгээд эхэлнэ. Энэ борлуулалт нь анхны хөрөнгө оруулалтыг нөхөж дууссан тэр өдрийн үдээс хойш Монголын тал 50 хувийг нь эзэмших гэрээ хийж болно. Ингэ гэж УИХ-ын 57 дугаар тогтоолд заасан. Энэ нь ойролцоогоор арав хүрэхгүй жилийн дотор (урьдчилсан тооцоогоор 2019 он, гэхдээ зэсийн үнэ яаж хэлбэлзэхийг хэн ч мэдэхгүй) болно. Оюу толгойгоос буй болох нийт баялгийн 60 хувь нь Монголын талд ногдоно. 66 хувийг эзэмшиж байгаа гадаадын компаниуд орлогын 40 хувийг авна. Зэсийн үнийг 4408 доллараар тооцоход зөвхөн энэ төслөөс 30 тэрбум доллар Монголд орж ирнэ. Зэсийн үнэ өнөөгийнх шиг 10 мянга байвал Монголын орлого ганц энэ төслөөс 70-80 тэрбум. Монголыг 20 гаруй жил тэжээсэн Зөвлөлтийн зээлийн өрийг төлөхөд 250 сая доллар зарцуулсан нь Оюу толгойгоос олох мөнгөний нэг хувьд ч хүрэхгүй байна. Монголчууд түүхэндээ ийм их баялагтай болж үзээгүй”⁶⁴ гэсэн байдаг. Дахин хэлэхэд энэ аварга төслийг урагшлуулсан нь хамтарсан Засгийн газрын гавьяа байсан бол

⁶⁴ Баабар. Улсаа нураачихалгүй сонгууль хүргэх юмсан, -ӨС.№244 (2011.10.12)

нөгөө талаасаа төр эзэмшлийн хувиа нэмэх бол илүү хөрөнгө оруулалт, илүү зээл, илүү цаг хугацаа шаардах байлаа.

Ерөнхий сайд Сү.Батболдыг огцруулах бичгийг өгөв

Байдал даамжирч долоо хоногийн дараа УИХ-ын гишүүн Н.Батбаяр, Ц.Батбаяр, С.Эрдэнэ, З.Энхболд, Д.Ганхуяг, Ц.Даваасүрэн, Б.Бат-Эрдэнэ, Ц.Шинэбаяр, Д.Балдан-Очир нарын гурван намын төлөөлөл болсон гишүүд Ерөнхий сайд С.Батболдыг огцруулах бичгийг УИХ-ын дарга Д.Дэмбэрэлд аваачиж өгөв. Аваачиж өгөв гэсний учир нь УИХ-ын дарга Д.Дэмбэрэл гишүүдийн өргөсөн бичгийг УИХ-ын тогтоол, шийдвэр, төслийн аль нь ч биш албан бичиг учир УИХ-ын Тамгын газарт очих ёстой гэж үзээд шилжүүлсэн байна. 11-р сарын 3-ны өдөр нэр бүхий есөн гишүүн Засгийн газрын тэргүүнийг огцруулах бичгийг УИХ-ын даргад дахин өргөн барив. Гэсэн ч УИХ-ын даргын байр суурь өмнөхтэйгээ адилхан байсан бөгөөд энэхүү зарчмыг АН-ын бүлгийн дарга Ч.Сайханбилэг “Ерөнхий сайдыг Засгийн газрын кабинетийн нэг гишүүнтэй адилгаж үзэж болохгүй. Ерөнхий сайд огцорвол кабинет огцордог. Энэ бол Үндсэн хуулийн зарчимтай нийцэж байгаа. Үүнийг нэг мөр болгоё гэсэн учраас сая УИХ-ын тухай хуульд өөрчлөлт оруулан 19 гишүүн Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг өргөн барина гэсэн хязгаарлалт хийсэн. Тэгэхгүй бол хэн дуртай нь Ерөнхий сайдыг огцруулах асуудал оруулж ирнэ. Бараг өдөр болгон ийм зүйл хэлэлцэх болно. 19 гишүүнийхээ босгыг давчихсан тохиолдолд энэ бол нээлттэй асуудал”⁶⁵ хэмээн хуулийн дагуу тайлбарлаж, дүгнэсэн нь бий.

Юутай ч ийнхүү Хүннү гүрэн байгуулсны 2220, Их Монгол Улс байгуулсагдсаны 805, Үндэсний эрх чөлөөний хувьсгалын 100, Ардын хувьсгалын 90 жил, Монгол Улс Нэгдсэн үндэстний байгууллагад элсч, албан ёсны гишүүн болсны 50 жилийн ой тохиосон, МУ ардчиллыг тууштай дэмждэг, бүс нутагтаа ардчиллын тулгуур болдог, уул уурхайг ашиглах замаар эдийн засгийн хувьд эрчимтэй хөгжих эхлэл тавигдсаны баталгаа болж томоохон гүрнүүдийн төрийн тэргүүнүүд айлчилсан (Энэтхэгийн Ерөнхийлөгч Пратибха Девисингх, БНСУ-ын Ерөнхийлөгч Ли Мён Бак, АНУ-ын дэд ерөнхийлөгч Жо Байден, Финляндын

⁶⁵ Сайханбилэг.Ч.: Ардчилсан нам 22 настай ч 90-тэй намынхаа дэргэд хамаагүй илүү туршлагатай болчихсон байхгүй юу (ярилцсан Я.Мөнгөнцэцэг), -ӨС.№307 (2011.12.22)

Ерөнхийлөгч Таржа Халонен, мөн ХБНГУ-ын канцлер Ангела Меркель, АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан Мадлен Олбрайт), МУ “Ардчилсан орнуудын хамтын нийгэмлэг”-ийг 2011-2013 онд даргалах болсон, АНУ-ын Ерөнхийлөгч Б.Обама МУ-ын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн нүүрийг санамсаргүйгээр гараараа таглаж патиар татуулсан, МАН-аас гарсан Н.Энхбаяр МАХН байгуулсан...нэгэн он улиран одлоо.

СОНГУУЛИЙН ЖИЛ: АРДЧИЛСАН НАМ ЗАСГИЙН ГАЗРААС ГАРАВ



Ардчилсан намын сэтгүүлчидтэй уулзах “4-11” уулзалт 2012 оны нэгдүгээр сарын 6-нд боллоо. Уулзалтанд АН-ын дарга Н.Алтанхуяг, Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Эрдэнэбат, УИХ дахь АН-ын бүлгийн дарга Ч.Сайханбилэг нар оролцсон юм.

Энэ үеэр АН-ын дарга Н.Алтанхуяг хамтарсан Засгийн газраас гарах болсон тухай албан ёсоор мэдэгдлээ. Н.Алтанхуяг хамтарсан Засгийн газар байгуулагдах болсон урьдач нөхцөл, хамтрах болсон шийдвэр, хамтарч засагласны түүхэн ач холбогдолыг дэлгэрэнгүй яриад Засгийн газраас гарах болсон шалтгаанаа “АН хамтарсан Засгийн газарт орж ажилласнаараа өөрт оногдсон түүхэн үүргийг хариуцлагатай, нэр төртэй хийж чадсан гэж би АН-ын даргын хувьд үзэж байгаа юм. Одоо 2012

он гарлаа. Өнөө жил онцлогтой. Энэ оны зургадугаар сард УИХ-ын болон орон нутгийн сонгууль хамтдаа болох ёстой. Сонгуульд мэдээж АН, МАН хоёр тусдаа орох нь гарцаагүй. Хоёр нам тус тусын үзэл баримтлал, ойрын хугацааны хөтөлбөр улс орныхоо хөгжлийг яаж төсөөлж байна, ямар асуудлуудыг яаж шийдье гэж үзэж байна түүгээрээ мөрийн хөтөлбөр боловсруулж тус тусдаа сонгуульд оролцох нь дамжиггүй юм. Тийм учраас АН-ын хувьд сонгуулийн жил нэгэнт гарлаа. АН хамтарсан Засгийн газарт орсноор өөрт оногдсон түүхэн үүргийг хангалттай сайн биелүүлж чадсан тул Засгийн газраас гарах цаг нь болсон гэж үзэж байна”⁶⁶ хэмээн тайлбарлажээ.

АН-ын ЕНБД Д.Эрдэнэбат “Хамтарсан Засгийн газраас АН гарч байгаа нь элдэв шалтгаангүй. Зөвхөн сонгууль эхэлсэн гэдгийг л зарлаж байгаа хэрэг. Өнгөрсөн 2009 онд ардчилсан Ерөнхийлөгчтэй болсон. Харин 2012 онд ардчилсан засаглалтай болох ёстой гэж бодож байна. Үүний тулд бид ийм шийдвэр гаргаж байгаа юм. Үүнийг ч ард түмэн хүсэн хүлээж байгаа байх. Ард түмэнрүүгээ зэвсэг барьдаг, төрийн томчууд, түшмэдүүд нь ард түмнээсээ зэвсгээр хамгаалуулдаг байхад ардчилсан засаглалтай орон байна гэж үзэж болохгүй. Иймд намын даргын хэлсэн хамтарсан Засгийн газраас гарч сонгуульд орно гэдэгтэй санал нэг байна. Ирэх сонгууль Монголын ард түмэнд ардчилсан, жинхэнэ засаглалыг авчрах ёстой. Ард түмэн хуучин суурин дээр популист, хэт төвлөрсөн маягийн, төр дамжиж баяждаг хүмүүсийн сүлжээг байхгүй болоосой гэж хүсч байгаа. Тиймээс АН үзэл баримтлалынхаа суурин дээр зогсч хамтарсан Засгийн газраас гарах шийдвэр гаргасан юм”⁶⁷ гэсэн билээ.

Зарим гоморхол

Нийслэлийн АН-ын дарга Ш.Түвдэндорж “Намын даргын мэдэгдлийг телевизээр л харлаа. Уг нь, би намын удирдлагад багтдаг гурван хүнийх нь нэг. Зарчмын хувьд Н.Алтанхуяг даргын мэдэгдлийг дэмжиж байна. Гэхдээ намын дарга асуудлаа намын Гүйцэтгэх зөвлөл болон ҮЗХ-гоор оруулж шийдвэрлүүлснийхээ

⁶⁶ Мөнхтөр.Л. АН хамтарсан Засгийн газраас гарахаа мэдэгдлээ, -ӨС.№004 (2012.01.06)

⁶⁷ Мөнхтөр.Л. АН хамтарсан Засгийн газраас гарахаа мэдэгдлээ, -ӨС.№004 (2012.01.06)

дараа зарласан бол процедурын хувьд зөв байх байсан болов уу”⁶⁸ гэсэн байдаг. Ардчилсан намыг гол өрсөлдөгч МАН-тай нь харьцуулахад дотоод ардчилал нэрээр сахилга батгүй, гишүүд нь эрх ашгийн дарааллыг баримталдаггүй, хувийн үзэл бодол, сэтгэлийн хөдөлгөөндөө хэт захирагддаг байдал нь ч Нийслэлийн АН-ын даргын гоморхлоос тод харагдана.

Хамтарсан Засгийн газраас гарах болсон АН-ын, тодруулбал АН-ын даргын шийдвэр нь нэг талаасаа хамтын удирдлагын зарчмыг алдагдуулсан байх талтай ч нөгөө талаасаа хариуцлагыг дангаараа үүрэх чадвар, олон нийтийн сэтгэл зүй болоод улс төрийн мэдрэмжийг харуулсан явдал байлаа. Үүнийг нь ч цаг хугацаа буюу УИХ-ын ээлжит сонгууль харуулсан билээ.

Ширүүн болсон ҮЗХ-ны 35 дугаар хуралдаан



Ардчилсан намын Үндэсний зөвлөлдөх хорооны ээлжит 35 дугаар хуралдаан боллоо. Хурлыг АН-ын дарга Н.Алтанхуяг даргалж, Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Эрдэнэбат, нийслэлийн АН-ын дарга Ш.Түвдэндорж нар эхлүүлэв. Гэтэл тэргүүн шадар сайд АН-ын дарга Н.Алтанхуягаар даргалуулах нь буруу хэмээн үзэж ҮЗХ-ны гишүүн, Ерөнхийлөгчийн тамгын газрын дарга Д.Баттулга

⁶⁸ Монголхүү.Б. Монгол ардын нам “матрын нулимс” бүү унага,-ӨС.№006 (2012.01.09)

буруушаан санал хураалт явууллаа. ҮЗХ-ны гишүүдийн олонхи нь Н.Алтанхуягаар удирдуулах нь зүйтэй гэж үзэв. Гэхдээ АЭХ-ны тэргүүн Ц.Оюунгэрэлийн хэлснээр 20 гишүүний санал, санал хураах явцад хаягдсан тухай хэлснийг хурал удирдаж байгаа хүмүүс тоосонгүй. Үүнтэй үл эвлэрсэн нийслэлийн АН-ын дарга Ш.Түвдэндорж хурлын тэргүүлэгчээс өөрийн саналаар татгалзлаа.

Энэ хуралдаанаар ҮЗХ-д шинээр сонгогдсон хүмүүсийн бүрэн эрхийг нь баталгаажуулах, АН-ын даргын илтгэлийг сонсох, Засгийн газрын зургаан сайдын илтгэлийг таван минутаас доошгүй хугацаанд танилцуулах, хамтарсан Засгийн газраас гарах гэх мэт асуудлыг хэлэлцэх байв. Хурлын эхэнд хамтарсан засаг дахь АН-ын сайд нар тус тус хийсэн ажлаа товчхон тайлагнах үеэр ЗТБХБ-ын сайд Х.Баттулга "... Хамтарсан Засгийн газрын хийсэн ажлын гүйцэтгэл 82 хувьтай гэдэг худлаа. Ажил хийе гэхээр төсвийг нь шийдэж өгдөггүйгээс болоод одоо ихэнх ажил цаасан дээр л буусан байгаа. Ц.Нямдорж сайд "Чиний төмөр зам барихыг чинь харна аа" гэж зандаг. 100 мянган айлын орон сууц төслийн хүрээнд хамгийн сайн явагдаж байсан ажлыг зогсоосон.Өнөөдрийн Засгийн газрын хуралдаанд л гэхэд "MCS" компанийнхан Хятад компанитай 70 жил хамтрах тогтвортой ажиллагааны гэрээ байгуулахаар оруулж ирсэн байна. Үүнийг Сангийн яамныхан тас нууж тулгаж оруулах гэж байна. Хамтарсан Засгийн газраас гарах гэж байсан юм бол намын дарга Н.Алтанхуяг сайд нартайгаа зөвшилцөх ёстой байсан. Бүлгийн хурлын дараа мэдээлэл хийхэд нь би намын даргаас асуусан. "Та хамтарсан Засгаас гарах гэж байгаагаа сайд нартайгаа зөвлөлдсөн үү" гэхэд Н.Алтанхуяг дарга "Тийм ээ" гэж байсан. Үнэн хэрэг дээрээ өмнөх өдөр нь хэн ч энэ тухай дуулаагүй. АН-ын дарга Н.Алтанхуяг ганцаарчилсан тоглолт хийж, Засгаас гарах болсныг мэдэгдсэн" гэлээ.

Хуралдааны төгсгөлд УИХ-ын гишүүн З.Энхболд хамтарсан Засгийн газарт ажилласан зургаан сайдыг жагсааж байгаад асуулт тавьж байцаасан нь уур амьсгалыг багагүй хурцатгав.

З.Энхболд: –Жил бүр 60 мянган ажлын байр бий болгоно гэсэн. Яг өнөөдөр хэдэн ажлын байр бий болсон бэ? Гэрээ байгуулаад дөрвөн жил болж байгаа болохоор 240 мянгад хүрч байгаа юу?



НХХ-ийн дэд сайд Д.Нямхүү:-Ерөнхий сайд 2011 онд 72 мянган ажлын байр бий болгосон гээд зарлачихсан. Өнгөрсөн жилүүдийн ажлын байртай нийлээд 200 орчим мянган ажлын байр бий болсон.

3.Энхболд: -Өрх бүрийн сарын дундаж орлого сая төгрөг болгоно гэсэн юу болсон бэ?

Сангийн сайд С.Баярцогт:-2008 оны есдүгээр сарын 28-нд Засгийн газар байгуулагдсан. Яг тэр үед дэлхий нийтийг хамарсан хямрал эхэлсэн. Бид хямралыг хамгийн богино хугацаанд давж гарсан. Хямрал болж байхад дэлхий нийтээрээ ажлын байраа алдаж, улс орнууд дампуурсан. Ийм хүнд нөхцлийг бид давж гараад 2010, 2011 онд манай улсын эдийн засаг сайжирсан. 2005 оноос хойш манай төсөв өссөөр байсан. Тэгэхээр 2008 онд энэ өсөлт цаашид ч үргэлжилнэ гэж тооцоод ийм амлалт хийсэн хэрэг. Тийм үед төсөөлж байсан мөрийн хөтөлбөрийг өнөөдөр асууж байгаа нь саран дээрээс бууж ирчихээд асууж байгаатай адил. Хамгийн хүнд хэцүү нөхцөлд бид амлалтаа биелүүлж ирсэн. 1.5 сая төгрөгийг уул уурхайгаа эргэлтэд оруулаад шийднэ гэсэн. 2012 оны төсвийг баталсан тогтоолоор энэ асуудлыг бүрэн шийдсэн гэв.

Хачирхалтай нь АН-ын ҮЗХ-ны хуралд УИХ-ын гишүүн, МАН-ын Бага хурлын гишүүн С.Бямбацогт сууж байгаад хөөгдөж гарлаа. Уг хурлыг телевизээр шууд дамжуулж байсан ч удалгүй хаалттай хуралдахаар шийдэн сэтгүүлчдийг гаргав.

Эцсийн дүндээ Ардчилсан нам хамтарсан Засгийн газраас гарах саналыг ҮЗХ-ны гишүүд 100 хувь дэмжлээ. Мөн энэ хурлаар ҮЗХ, ГЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийг батламжласнаас гадна МАХН, АН-ын хамтран ажиллах гэрээ, хамтарсан Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн биелэлтэд үнэлэлт, дүгнэлт өгөх ажлын хэсгийг байгууллаа.

Засгийн газраас гарах шийдвэрийг дэмжив

ҮЗХ-ны хурлаар хамтарсан Засгийн газраас гарах асуудлыг авч хэлэлцэн баталгаажуулсан билээ. Ингэснээр Ардчилсан нам албан ёсоор хамтарсан Засгийн газраас гарлаа. Хурлын маргааш нь АН-ын сайдууд Засгийн газраас гарах өргөдлөө Ерөнхий сайдад өгчээ.



ҮЗХ-ны хуралдааны маргааш буюу 2012 оны нэгдүгээр сарын 12-нд Төрийн ордны “Б” танхимд АН-ын дарга Н.Алтанхуяг, УИХ дахь АН-ын бүлгийн дарга Ч.Сайханбилэг, Намын ерөнхий нарийн бичгийн дарга Д.Эрдэнэбат нар хэвлэлийн бага хурал хийж, Ардчилсан намын ҮЗХ-ны 35 дугаар хурлаас АН-ыг хамтарсан Засгийн газраас гарах нь зүйтэй гэсэн гэж үзсэн шийдвэрийг танилцуулав.

МОНГОЛ УЛСЫГ 2020 ОН ХҮРТЭЛ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР “МОНГОЛ ХҮН-2020”



2012 оны хоёрдугаар сарын 2-нд Ардчилсан намын ээлжит “4-11” уулзалт Төрийн ордонд боллоо. АН-ын дарга Н.Алтанхуяг мэдээлэл хийв. Тэрбээр, АН-аас өнгөрсөн хугацаанд орон даяар зохион байгуулсан “Монгол хүн-2020” хэлэлцүүлгийн талаар дэлгэрэнгүй ярилаа.

Ардчилсан нам тус хэлэлцүүлгийг Монгол Улсынхаа 21 аймгийн бүх сум, баг, нийслэлийн есөн дүүргийн бүх хороонд амжилттай зохион байгуулж, монгол хүнээ эрүүл чийрэг, эрх чөлөө, эрдэм боловсрол, ажил орлого, аюулгүй орчинтой болгохын тулд юу хийх ёстойг иргэдийн санал санаачилгад тулгуурлан тодорхойлсон байна. Хэлэлцүүлэгт нийтдээ 60 мянга гаруй

хүн оролцжээ. Ийнхүү АН-ынхан үндэсний хэмжээнд зохион байгуулсан хэлэлцүүлгээ хааж онлайн хэлбэрт шилжүүлж байгаагаа мэдэгдлээ. Цахим хэлбэрээр үргэлжлэх “Монгол хүн-2020” хэлэлцүүлэг нь өнгөрсөн хугацаанд санал бодлоо илэрхийлж амжаагүй болон гадаадад ажиллаж, амьдарч буй иргэдэд үгээ хэлэх боломж олгож байгаа аж. Түүнчлэн, “Монгол хүн-2020” хэлэлцүүлгээр дэвшүүлсэн дээрх таван зорилтын хүрээнд хамгийн оновчтой санал, шийдлийг санал болгосон иргэдийг долоо хоног бүр шалгаруулж, урамшуулахаар болсон байна. Энэхүү шалгаруулалтыг явуулахад намын удирдлага бус, хөндлөнгийн шинжээч, судлаачид үнэлэлт өгөх зарчмаар явагдана гэдгээрээ онцлогтой аж. Мөн өмнө нь эрдэмтэн судлаачдын дунд зарласан 140 сая төгрөгийн шагналын сантай шилдэг бүтээлийн уралдаанд одоогийн байдлаар 34 бүтээл ирүүлсэн бөгөөд эдгээрээс эрүүл мэндийн салбарт чиглэсэн илтгэл, нийтлэл давамгайлжээ.

Хоёрдугаар сарын 3-наас “Монгол хүн-2020” хэлэлцүүлгийн нэгдсэн тайланг хэлэлцэж, улмаар үндэсний хэмжээний хөгжлийн хөтөлбөр болгон боловсруулах Ерөнхий хороог 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулах болсноо АН-ын дарга Н.Алтанхуяг хэллээ.

“Монгол хүн-2020” хөтөлбөр нь Монгол Улсын 2020 он хүртэлх хөгжлийн хөтөлбөр болох бөгөөд 2012-2016 он, 2016-2020 он гэсэн үндсэн хоёр үе шаттай байхаар тооцоолжээ. Энэ агуулгаараа “Монгол хүн-2020” хөтөлбөр нь Ардчилсан намын ирэх хоёр ч сонгуулийн мөрийн хөтөлбөр болох нь тодорхой боллоо.

“ШОНХОР” ФРАКЦИ МЭНДЛЭВ

2010 оны нэгдүгээр сарын 25 нд хэвлэлийн бага хурал хийж байгуулагдсанаа анх зарлаж байсан “Ардчилсан хүчний холбоо”-ныхон ийнхүү 2012 оны хоёрдугаар сарын 8-нд АН-ын дотор “Шонхор” нэртэй жигүүр (фракци) байгуулж буйгаа албан ёсоор зарлалаа.

Жигүүрийг УИХ-ын гишүүн З.Энхболд тэргүүлэхээр болов. Тэрбээр “Манай “Шонхор” бол хатуу үзэл бодолтой гишүүдийн жигүүр. Бид АН-ыг хамтарсан Засгийн газарт орохыг анхнаасаа

эсэргүүцэж байлаа. Цаашдаа ч эсэргүүцнэ. Ирэх сонгуульд АН, МАН тэнцүүхэн суудал авсан ч хамтарсан Засгийн газар байгуулахыг эсэргүүцнэ” гэлээ. УИХ-ын гишүүн Г.Баярсайхан,



“Манайхан тулаанд зөвхөн шонхрууд л нисдэг гэж ярьдаг. Ардчилсан хүчний холбооныхон УИХ-д өөрсдийг нь төлөөлөх жигүүртэй болж, үүнийгээ албан ёсоор байгууллаа. Ардчилсан намыг “Шонхор” өөрчилж, гартаа авна” гэж хэлж байлаа. Тэгвэл УИХ-ын гишүүн С.Эрдэнэ илтгэлдээ, “Нөхөдөө! “Алтангадасчууд”-аас зоригтойгоор салж Ардчилсан намаа шинэчилье. Одоо Ардчилсан намд жинхэнэ шинэчлэл хэрэгтэй гэдгийг би энд онцлон хэлэхийг хүсэж байна. Учир нь иргэдийн олонхи нь АН-ыг Монгол орныг хөгжүүлэх, улс төрийн түүчээ байж чадна гэдэг итгэлээ хараахан алдаагүй байх гэж би ойлгодог. Ардчилсан намдаа ч биш нийгэмд шударга ёс хэрэгжих боломж гарна гэсэн сүүлчийн найдлага юм. 2012 оны сонгуульд унаж, мөхөл сүйрлийн замруу алхахгүй л гэвэл шинэ үеэ түшиглэн Ардчилсан намд сэргэлт авах цаг гарцаагүй ирсэн” гэж уриалж байлаа.

Тэгвэл дээрх үйл явдлаас хоёр хоногийн дараа АН-ын хэсэг залуу “Мөнх тэнгэр” нэртэй жигүүр байгуулж буйгаа мөн зарлав. Тэргүүн нь УИХ-ын гишүүн асан Б.Батбаатар бөгөөд Хан-Уул дүүргийн Засаг дарга Ч.Ганхуяг нарын 30-аад залуу үүсгэн байгуулжээ. “Мөнх тэнгэр”-ийн тэргүүн Б.Батбаатар хоёрдугаар

сарын 24-нд хэвлэлийн хурлынхаа үеэр “АН-ын 2012 оны сонгуулийн мөрийн хөтөлбөрт гурван санаа тусгуулах зорилт тавьсан. УИХ-д залуучуудыг нэр дэвшүүлэх, тэднийгээ дэмжин, улмаар ялалт байгуулахын төлөө бид ажиллана. АН-ыг хагалан бутаргах бус эв нэгдлийн төлөө манай жигүүр явах болно” гэсэн байдаг.

АН-ЫН ДАРГА Н.АЛТАНХУЯГ: СОНГУУЛЬ БУДЛИАНТУУЛАХГҮЙ БАЙХЫГ АНХААРУУЛАВ



Дээрх үгийг АН-ын дарга Н.Алтанхуяг 2012 оны дөрөвдүгээр сарын 1-ний өдөр хийсэн хэвлэлийн бага хурлынхаа үеэр хэлсэн юм. “МАН-ынхан ирэх сонгуулиар 2008 оны долдугаар сарын хэрэг явдлыг давтах сонирхолтой байх шиг байна. Миний бие энэ Засгийн газарт Тэргүүн шадар сайдаар ажиллаж байхдаа иргэдээ цахим үнэмлэхтэй болох ажлыг эхлүүлсэн. Гэтэл одоо цахим үнэмлэх хэвлэх ажил АН-аас болоод саатаж, сонгуулийн өмнө амжиж хэвлэн тарааж чадахгүй болсон мэтээр МАН-ынхан удаа дараа мэдэгдэж байна. Цахим үнэмлэх тараахгүй байна гэдэг сонгуулийг дахин будлиантуулах гэж байгаа хэрэг. Хэрвээ үнэхээр ийм бодолтой байгаа бол энэ Засгийн газар огцрох ёстой” гэв. Мөн тэрбээр маргааш өдөр нь Ерөнхий сайд Сү.Батболдын хамт Таван толгойн хувьцааны асуудлаар

мэдээлэл хийнэ гэсэн зарыг хэвлэл, мэдээллийнхэнд тараагаад байлаа. Гэвч товлосон цагт нь Ерөнхий сайд ирсэнгүй. Харин Ерөнхий сайдын хэвлэлийн албаныхан гэнэтхэн ийм санал ирсэн тул хүлээж авах цаг хугацаа байсангүй гэсэн тайлбарыг хийв. Ингээд Н.Алтанхуягаас яагаад Ерөнхий сайдад урьдчилан мэдэгдээгүй юм бэ гэсэн асуултыг хэвлэлийнхэн тавихад тэрбээр “Мэдэгдэлгүй яах вэ. Би гуравдугаар сарын 30-нд Ерөнхий сайд Сү.Батболдод албан тоот явуулсан. Монгол Улсын иргэдэд нэг сая төгрөг олгох асуудлаар УИХ-аас гаргасан шийдвэрүүд хэрэгжихгүй байгаа тул дөрөвдүгээр сарын 2-4-ний аль нэг өдөр хамтарсан мэдээлэл хийхийг урьж байна гэсэн. Ерөнхий сайдтай утсаар ч ярьсан. Олон нийтийн дунд яваад байгаа ойлголтыг нэг мөр болгочих гэсэн санаатай юм. Тэгэхгүй бол МАН-ынхан иргэн бүрт өгөх 1072 ширхэг хувьцааны асуудлыг огт өөрөөр ярьж, манай намаас бас огт өөр тайлбар хийгээд байж болохгүй” гэлээ.

МӨНГӨНИЙ АМЛАЛТААР ӨРСӨЛДӨХГҮЙ БАЙХ САНАМЖ БИЧИГ

Мөн оны дөрөвдүгээр сарын 8-нд улс төрийн намуудын дарга нар харилцан ойлголцох санамж бичигт гарын үсэг зуржээ. Санамж бичигт “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангаж, хууль ёсыг дээдлэн сахиж, 2012 оны УИХ-ын болон орон нутгийн сонгуулийн үед мөнгөний амлалтаар өрсөлдөхгүй байхаа батлан илэрхийлж байна” хэмээсэн ба МАН-ын дарга С.Батболд, АН-ын дарга Н.Алтанхуяг, ИЗ-НН-ын дарга Д.Энхбат, дэд дарга С.Оюун, ҮШН-ын дарга Ц.Цолмон, МСДН-ын дарга А.Ганбаатар, БНН-ын дарга Б.Жаргалсайхан, МУНН-ын дарга Б.Батболд, Эх орон намын дарга Б.Эрдэнэбат нар мутарлажээ.

УИХ-ЫН СОНГУУЛИЙГ НИТХ-ЫН СОНГУУЛЬТАЙ ХАМТРАН ЯВУУЛАХ БОЛЛОО

УИХ-ын сонгуулийг орон нутгийн сонгуультай хамт явуулах асуудал дээр хоёр нам зөвшилцөж чадаагүйгээс мөн л гацдагаараа гацлаа. АН-ын зүгээс аймаг, нийслэлийн сонгуулийг цугт нь сум,



дүүргийн ИТХ-ны сонгуулийг тусад нь явуулах буулт хийсэн ч МАН-ын зүгээс хүлээн авсангүй. Орон нутгийн сонгуулийн УИХ-ын сонгуультай цуг явуулах нь эдийн засгийн хувьд ашигтайгаас гадна сонгогчдын ирцэнд ч сайнаар нөлөөлөх ач холбогдолтой байв. Басхүү өргөн утгаараа эрхийг нь бүрэн өгч хариуцлагыг ч бүрэн тооцох ач холбогдолтой байв.

Дөрөвдүгээр сарын 6-нд хуралдсан Төрийн байгуулалтын байнгын хорооны хурлын үеэр УИХ дахь АН-ын бүлгийн дарга Ч.Сайханбилэг “Хоёр сонгуулийг хамт явуулах уу, салгах уу гэдгийг намын бүлгүүдийн байр сууриар шийдэхэд хэцүү байна. Тэгэхээр одоо бидэнд хоёрхон гарц бий. Бүлэг дээр тохиролцохгүй байгаа асуудлаа орхиод Орон нутгийн сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах төслийн бусад асуудлыг хэлэлцье. Эсвэл одоо мөрдөгдөж байгаа Орон нутгийн сонгуулийн хуулиа дагаад хоёр сонгуулиа хамт явуулья” гэсэн юм. АН-ын энэ байр суурийг МАН-аас Д.Загджав гишүүн дэмжиж “Орон нутаг, УИХ-ын сонгуулийг хамт явуулах бүх талын боломж манайд байгаа”⁶⁹ гэжээ.

Байдал сунжирсаар. Эцэст нь УИХ-ын дарга Д.Дэмбэрэл УИХ-ын чуулганы дөрөвдүгээр сарын 19-ний чуулган дээр “Хоёр намын бүлэг маргаад байгаа асуудлаа өнөөдрийн дотор шийд. Ганцхан өдрийн хугацаа өглөө. Хэрэв шийдэлд хүрч чадахгүй бол УИХ-ын гишүүд өөрсдийнхөө бүрэн эрхийн хүрээнд аль ч намын эрх ашгийг хамгаалахгүйгээр шууд санал хураалтаар шийдье. Сонгууль ойртож байхад бидэнд ухрах цаг байхгүй”⁷⁰ гэж сануулж, сургаж, хатуурхав.

Хоёр намын бүлэг эцэст нь зөвшилцөлд хүрлээ. Тодруулбал Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг УИХ-ын сонгуультай хамтран явуулах шийдэлд хүрсэн байна. Өөрөөр хэлбэл, АН нийслэлд, МАН орон нутагт найдвар тавьж байлаа.

⁶⁹ Мөнгөн.Я. Байнгын хорооны хурал “бантан” болоод тарав,-ӨС.№088 (2012.04.07)

⁷⁰ Мөнгөнцэцэг.Я. Хоёр намын бүлэгт нэг өдрийн хугацаа өглөө,-ӨС.№099 (2012.04.20)

УИХ-ЫН СОНГУУЛЬ-2012

Сонгуулийн будлианы эсрэг тэмцэл: Н.Алтанхуяг vs Ц.Нямдорж



2012 оны нэгдүгээр сарын 1-нээс эхлэн УИХ-ын сонгуулийн тухай шинэ хууль үйлчилж эхэлсэн бөгөөд маш товчоор бол тухайн хүн нэг бол улс төр буюу намыг, үгүй бол төрийн албыг сонгох ёстой болсон юм. УИХ-ын сонгуулийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 6-д “Улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан Улсын Их Хурлын гишүүнд нэр дэвших бол сонгуулийн жилийн нэгдүгээр сарын 1-ний өдрөөс өмнө төрийн албанаас болон ажил, албан тушаалаасаа чөлөөлөгдсөн байна” гэсний дагуу Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Л.Мөнхбаатар нарыг өргөдлийнх нь дагуу ажлаас нь чөлөөлсөн байдаг.

Хамтарсан ЗГ-аас АН гарсантай холбоотойгоор Тэргүүн шадар сайдын албан тушаал цомхотгогдсон билээ. Ингэснээр Тэргүүн шадар сайдын эрхлэх асуудлын хүрээнд багтаж байсан Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийг Шадар сайдын, Оюуны өмчийн газар,

Улсын бүртгэлийн ерөнхий газрыг Хууль зүй, дотоод хэргийн Сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэх санал гарч батлагдсан юм.

УБЕГ-ын дарга Л.Мөнхбаатарыг чөлөөлөгдсөнөөс хойш тус газрын дэд дарга С.Энхбаатар даргын албан тушаалыг орлон гүйцэтгэж байсан ба МАН намынхаа нарийн бичгийн дарга асан Л.Амарсанааг 2012 оны 2-р сарын 3-нд УБЕГ-ын даргаар томилсон билээ. Өөрөөр хэлбэл УБЕГ гэдэг байгууллага ХЗДХ-ийн сайд Ц.Нямдоржийн шууд удирдлага дор, МАН-ын нарийн бичгийн дарга асан Л.Амарсанаагийн мэдэлд очсон байна. УБЕГ-ын ерөнхий чиг үүргийн нэг нь сонгуулийн үеийн бүхий л бүртгэл мэдээллийг хариуцах юм.

УИХ дахь АН-ын бүлгийн дэд дарга Л.Гантөмөр 2-р сарын 27-ны өдөр болсон бүлгийн хурлын талаар мэдээлэл хийхдээ ““Л.Амарсанаагийн оронд тухайн байгууллагын дэд даргыг томилох боломж байсаар байтал уг албан тушаалыг улс төрийн томилгоо болгон хувиргасныг АН шүүмжилж байна. Тиймээс ийм улс төрийн томилгоогоо зогсоохыг МАН-аас шаардсан”⁷¹ хэмээн мэдээлэв. УИХ дахь АН-ын бүлгийн дээрх хуралдаанд СЕХ-ны дарга Н.Лувсанжав, УБЕГ-ын даргын үүрэг гүйцэтгэгч Л.Амарсанаа, ХЗДХ-ийн сайд Ц.Нямдорж нарыг оролцуулан иргэний цахим үнэмлэх солих, хурууны хээ таних төхөөрөмж, санал хураах автомат машины тухай мэдээлэл авсан байна. Намын бүлгийн хуралдаан дээр сонгуулийг будлиантуулдаг буюу будлиантуулах боломж иргэний бүртгэл дээр их гардаг тухай, үүнийг таслан зогсоох тухай, түүнд хамгийн их үүрэгтэй даргыг улс төрийн шалтгаанаар томилсон тухай, үүнийг нэн даруй залруулах тухай, алдаагаа ухамсарлах тухай зөвлөсөн, сануулсан, анхааруулсан байна. Гэсэн ч байдал засагдсангүй, хэвээр.

2012 оны тавдугаар сарын 15-нд хуралдсан УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Иргэний үнэмлэхийн талаар авах зарим арга хэмжээний тухай УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцсэн байна. “Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржийн танилцуулснаар шинээр иргэний үнэмлэх авах шаардлагатай 64 мянга гаруй иргэн байгаа аж. Тэдэнд хуучин үнэмлэх олгох боломжгүй, тиймээс нөхцөл байдлыг

⁷¹ Мөнгөн.Я “Улс төрийн томилгоогоо зогсоохыг МАН-аас шаарджээ,-ӨС.№055 (2012.02.29)

харгалзан үзэж УИХ-ын сонгуулиас урьтаж шинэ цахим үнэмлэх олгох шаардлага тулгарч байгааг энэ үеэр онцлов”⁷². Энэхүү хэлэлцүүлгийн үеэр Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, УИХ-ын гишүүн Н.Алтанхуяг нарын дунд сонгуулийг шударга явуулах болоод сонгогчдын бүртгэлийг үнэн зөв гаргах талаар ширүүн маргаан өрнөсөн байна. “Тухайлбал, Н.Алтанхуяг гишүүн “Ц.Нямдорж оо, чи зориуд сонгуулийг будилаантуулах гэж ийм ажил зохион байгуулж байгаа, яагаад хурууны хээгээр санал өгөх асуудлыг оруулж ирэхгүй байна вэ” гэж хэлсэн бол сайд Ц.Нямдорж “Хэн чамайг замын дундаас ажлаа хая гэсэн юм. Би дуртайдаа ажлыг чинь аваа юу” гэж байлаа. Н.Алтанхуяг гишүүн ч мөчөөгөө өгсөнгүй “Чи тэр Л.Амарсанаагаа халаарай, танай нам чамд хайртайдаа сайдын суудлаас чинь огцруулаагүй гэж бодож байна уу. Чи бол сонгууль будилаантуулах гэж л үлдсэн” гэж байлаа”⁷³. Ийм байдлаар АН болоод АН-ын гишүүд, даргатайгаа нэгдэн бүртгэлийн тогтолцоо, сонгуулийн тогтолцоог хуулийн дагуу, шударга байхыг, байлгахыг шаардсаны үр дүн нь УИХ-ын сонгуулийн үеэр гарсан билээ.

Мөрийн хөтөлбөрөө нууцлав

АН-ын ҮЗХ 2012 оны дөрөвдүгээр сарын 30-ны даваа гарагт хаалттай хуралдлаа. Ардчилсан нам бусад намуудаас түрүүнд мөрийн хөтөлбөрөө хэлэлцэж байгаа бөгөөд гол санаагаа алдахгүй тулд хаалттай хуралдахаар шийджээ. Нууцлах ч учир байж. 2008 оны Сонгуулийн мөрийн хөтөлбөртөө “Эрдэнийн хувь” гээд тусгатал МАХН (МАН) өлгөж аваад, “Иргэн бүрт эх орны хишиг” өгөх амлалтыг намынхаа мөрийн хөтөлбөрт тусгасан байна. “Монгол хүн-2020” хөтөлбөрөө баталтал МАН “Хөгжлийн хөтөлбөр” болгоод гаргаж байсан гэх мэт.

Тавдугаар сарын 02-нд АН-ын Гүйцэтэх зөвлөлийн хурал “Монгол хүн-2020” хөтөлбөрийн байранд болж 2012 оны УИХ-ын сонгуульд оролцох Ардчилсан намын мөрийн хөтөлбөрийг батлаад Үндэсний аудитын газар хянуулахаар өргөн барилаа. АН-ын энэ удаагийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийн талаар намын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Эрдэнэбат тодорхойлохдоо

⁷² Гэрэл.Т “Орон нутгийн сонгуулийн тухай хууль дахин гацаанд оров,-ӨС.№121 (2012.05.16)

⁷³ Мөн тэнд

“Хөтөлбөрийн гол санаа нь Монгол оронд өөрчлөлт хийх. Үүний дотор улстөр, нийгэм, эдийн засгийн өөрчлөлтийг хийх хэрэгтэй байна. Бид монгол хүн эх орондоо сайхан амьдрах нөхцлийг бүрдүүлэх тийм л хөтөлбөрийг боловсруулсан” хэмээжээ.

Ардчилсан намын мөрийн хөтөлбөрийн үндэс нь улсын хөгжлийн суурь нь иргэн, хүн гэдгийг баримталсанд оршиж байв. Тиймээс Монгол хүнээ хөгжүүлэх мөрийн хөтөлбөр боловсруулж, улмаар хийх ажлынхаа цар хүрээгээнарийвчлан гаргасан байлаа.

АН-ын ҮЗХ-ны хурал 4-р сарын 30-нд Төрийн ордонд боллоо. ҮЗХ-ны 228 гишүүнээс 121 гишүүний ирцтэйгээр хуралдсан тус хурлаар УИХ-ын ээлжит сонгуульд аливаа нэгэн намтай эвсэл байгуулахгүй гэсэн шийдвэр гаргажээ.

УИХ-ын гишүүн Э.Бат-Үүл 2012 оны УИХ-ын сонгуульд нэр дэвшихгүй, харин гэр хорооллыг орон сууцжуулах, хотын тулгамдсан асуудлыг шийдэхэд гар бие оролцохоор нийслэлийн сонгуульд намаа удирдан оролцохоо зарлав.

Ардчилсан намын Сонгуулийн хороо байгуулагдав

АН-ын Гүйцэтгэх зөвлөл тавдугаар сарын 4-нд хуралдаж АН-ын Сонгуулийн хороог есөн хүний бүрэлдэхүүнтэй байгуулан, даргаар нь АН-ын дарга Н.Алтанхуяг, Ерөнхий менежерээр намын ЕНБДарга Д.Эрдэнэбат, гишүүдээр УИХ-ын гишүүн Ч.Сайханбилэг, Р.Гончигдорж, З.Энхболд, Р.Амаржаргал, ҮЗХ-ны гишүүн А.Гансүх, П.Батчимэг, АН-ын нарийн бичгийн дарга П.Гантулга нарыг томилон батлав.

Намууд батламж гардав

УИХ-ын 2012 оны сонгуульд оролцох намууд тавдугаар сарын 14-нд Сонгуулийн ерөнхий хорооноос батламж гардлаа. УИХ-ын ээлжит сонгуульд 11 нам, хоёр эвсэл оролцох хүсэлтээ илэрхийлж, ийнхүү батламж гардан авсан юм. Үүнд:

1. Монгол ардын нам
2. Ардчилсан нам
3. Монголын ногоон нам
4. Иргэний зориг-Ногоон нам



5. Уламжлалын нэгдсэн нам
6. Эх орон нам
7. Бүгд найрамдах нам, Хамуг Монголын хөдөлмөрийн намын “Гуравдахь хүчин” эвсэл
8. Монголын социал демократ нам
9. Монгол ардын хувьсгалт нам, Монголын үндэсний ардчилсан намын “Шударга ёс” эвсэл
10. Эрх чөлөөг хэрэгжүүлэгч нам
11. Иргэний хөдөлгөөний нам
12. Хөгжлийн хөтөлбөрийн нам
13. Эх орончдын нам

УИХ-ын сонгуульд АН-аас нэр дэвшигчид тодров

АН-ын ҮЗХ-ны хурал 5-р сарын 17-нд болж бүх шатны сонгуульд нэр дэвшигчийг сонгон шалгаруулах журмыг хэлэлцэв. ҮЗХ-ны 37-р хурлаар баталсан журмын дагуу нэр дэвшигч нь аймаг, дүүргийн намын хорооны хурлын өмнө намын анхан шатны байгууллагаас санал авах ёстой болсон бөгөөд УИХ болон бүх шатны ИТХ-ын сонгуульд нэр дэвших шаардлага хангасан гишүүн нэр дэвших саналаа намын удирдлагад бичгээр илэрхийлсэн байх ёстой болжээ. Тухайн шатны намын дарга нь мандатын тооноос илүүгүй нэр дэвшигчийг тойргийн дарааллаар нь ҮЗХ, нийслэл, дүүргийн намын хорооны хурлаар хэлэлцүүлж, нууц санал хураалтаар шийдвэрлэнэ. 28-ын жагсаалтаар нэр дэвшихийг хүлээн зөвшөөрсөн нэг дэвшигчийг Гүйцэтгэх зөвлөл, Нийслэлийн зөвлөлдөх хорооны тэргүүлэгч, дунд шатны намын байгууллагын зөвлөлд танилцуулж, улмаар тогтоосон мандатаас илүүгүй нэр дэвшигчдийг эрэмбэлэн ҮЗХ, нийслэл, дүүргийн хуралд оруулж, нууц санал хураалтаар олонхийн саналаар шийдвэрлэх болов. Журам батлагдсанаар мөн сарын 23-нд нэр дэвшигчдээ тодруулах болсон юм.

АН-ын ҮЗХ-ны хурал 5-р сарын 24-нд хуралдаж жагсаалтад нэр дэвших гишүүдээ эхний ээлжинд тодрууллаа.

1. Н.Алтанхуяг(АН-ын дарга)
2. З.Энхболд (УИХ-ын гишүүн)

3. Х.Тэмүүжин (УИХ-ын гишүүн)
4. Ч.Сайханбилэг (УИХ-ын гишүүн)
5. Д.Эрдэнэбат (АН-ын ЕНБД)
6. Ш.Түвдэндорж (Нийслэлийн АН-ын дарга)
7. Р.Бурмаа (Сонгогчдын боловсрол төвийн тэргүүн)
8. Ц.Баярсайхан (УИХ-ын гишүүн)
9. Р.Гончигдорж (УИХ-ын гишүүн)
10. М.Батчимэг (Ерөнхийлөгчийн зөвлөх)
11. Б.Мэдрээ (Худалдаа хөгжлийн банкны захирал)
12. Л.Гансүх (УИХ-ын гишүүн)
13. Б.Ургамалцэцэг (АН-ын нарийн бичгийн дарга)
14. А.Гансүх (ЗТБХБ-ын дэд сайд асан)
15. н.Байгальмаа (МоАХ-ны нарийн бичгийн дарга)
16. П.Ганхуяг (Дорноговь аймгийн Засаг дарга)
17. н.Баатарбек
18. Р.Эрдэнэбүрэн (УИХ-ын гишүүн асан)
19. З.Нарантуяа (ҮЗХ-ны гишүүн)
20. Ж.Батболд
21. н.Сувдаа
22. Л.Пүрэвсүрэн (Ерөнхийлөгчийн зөвлөх)
23. н.Энхтуяа
24. Б.Баттүвшин
25. н.Үүрийнтуяа
26. Б.Батбилэг
27. Ц.Оюундарь (МҮОНТВ-ийн захирал)
28. н.Ариунболд (НИТХ-ын төлөөлөгч)

УИХ-ын ээлжит сонгуульд АН-аас Н.Батбаяр, Б.Болор, Ч.Куланда, А.Бакей, Х.Баттулга, Д.Ганбат, н.Түмэнжаргал, Б.Ариунсан, Я.Батсуурь, Б.Мөнхцэцэг, П.Алтангэрэл, Б.Наранхүү, Г.Батхүү, Д.Зоригт, Д.Бат-Эрдэнэ, С.Баярцогт, Д.Цогт-Очир, М.Зоригт, Д.Нямхүү, н.Мэндсайхан, Х.Золжаргал, Д.Одхүү, н.Гантулга, Б.Мөнхтуяа, н.Хүдэрбаатар, Б.Гарамгайбаатар, Б.Доржпүрэв, Г.Баярсайхан, Ц.Сэдванчиг, Л.Гүндалай, н.Шинэбаатар, Я.Санжмятав, КД.Батбаяр, Д.Пүрэвдорж, Д.Ганболд, П.Эрхэмбаяр, Л.Эрдэнэчимэг, С.Эрдэнэ, С.Одонтуяа, И.Нарантуяа, Ж.Батзандан, Д.Ганхуяг, Л.Болд, Ц.Оюунгэрэл,

Г.Баярсайхан, Б.Батбаатар, Р.Амаржаргал, Л.Гантөмөр нар нэр дэвшихээр болжээ.

Ардчилсан нам 76 нэр дэвшигчээ танилцууллаа



Тавдугаар сарын 25-ны өдөр нэр дэвшигчдийнхээ нэрсийг, ҮЗХ-ны 38 дугаар хурлын тогтоол, хурлын тэмдэглэлийн хамт Сонгуулийн ерөнхий хороонд хүргүүлээ.

Тэрчлэн энэ өдөр Ардчилсан нам 2012 оны УИХ-ын сонгуульд оролцох “Монгол хүн- 2020” хөтөлбөрөө, 76 нэр дэвшигчийнхээ хамт танилцуулах ёслолын Их чуулганыг Буянт-Ухаа дахь спорт цогцолборт хийлээ. Их чуулганд 21 аймаг, Улаанбаатар хотын есөн дүүргийн 8000 гаруй төлөөлөгч оролцжээ. Чуулганыг АН-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Д.Эрдэнэбат нээж, намын анхны дарга Баабар илтгэл тавин, АН-ын дарга Н.Алтанхуяг үг хэллээ.

Нийтлэлч Б.Батбаяр “Бид ялах хэрэгтэй сонгуульд орж байсан бол өнөөдөр ялагдах эрхгүй тийм сонгуулийн өмнө ирээд байна. Ардчилсан намын хувьд ч, монгол эх орны хувьд ч, ардчиллын хувьд ч ийм сонголт анх удаа, бас сүүлчийн удаа тохиож байгаа нь энэ байх аа”⁷⁴ гэж цохон тэмдэглэжээ. Ардчилсан намаас нэр дэвшигчиддээ батламж гардуулах ёслолын их чуулганы үеэр АН-

⁷⁴ Баабар. Ялагдах эрхгүй сонгууль, -ӨС.№132 (2012.05..30)

ын дарга Н.Алтанхуяг “Энэ удаагийн сонгуульд ард түмэн ялах ёстой. Ялахдаа бүрэн дүүрэн ялах ёстой. Энэ ялалтыг Ардчилсан нам парламентад олонхи болох явцуу утгаар бус ард түмний амьдралаас ургуулсан Ардчилсан намын мөрийн хөтөлбөр амьдралд бодьтой хэрэгжих өргөн утгаар хэлж байна. Тийм учраас энэ сонгуульд ард түмэн ялах ёстой. Ард түмэн ялахын тулд Ардчилсан нам ялах ёстой. Одоо бидний цаг ирсэн”⁷⁵ хэмээсэн байна.



Ардчилсан нам Алтай таван Богдоос сурталчилгаагаа эхлүүлэв

Ардчилсан нам сонгуулийнхаа сурталчилгааг Монгол улсын хамгийн баруун захын цэг Алтай таван Богд орших Баян-Өлгий аймгаас эхлүүлээ. Намын дарга Н.Алтанхуяг болон тухайн тойрогт нэр дэвшсэн А.Бакей, Ч.Куланда болон С.Отгонбаатар, залуусын төлөөлөл болж жагсаалтад орсон А.Эрдэнэбүрэн, жагсаалтын 17-д бичигдсэн Баатарбек нар Баян-өлгий аймгийн АН-ын дарга Х.Ержаны хамт зургадугаар сарын 4-нд сонгуулийн сурталчилгааныхаа анхны уулзалтыг хийсэн юм. Ингэхдээ чухам яагаад эндээс сурталчилгаагаа эхэлж буйгаа АН-ын дарга Н.Алтанхуяг ингэж тайлбарласан байна.

⁷⁵ Мөнх.Л. Ард түмэн, АН-ын цаг ирснийг сануулав, -ӨС.№130 (2012.05.28)



“Гурван учир шалтгаантай. Нэгд, аливаа улс орны тэргүүн ноён оргил, хамгийн өндөр цэгт тухайн улс орны сүлд хийморь оршиж байдаг. Тиймээс ч бид уул усандаа залбирч, шүтэж амьдардаг ард түмэн. Ийм учраас Монгол улсынхаа хамгийн өндөр ноён оргил бүхий Алтай таван Богдын бэлээс манай нам сонгуулийнхаа сурталчилгааг эхлэхээр шийдсэн юм. Алтай таван Богдын босоо хийморь манай намд ялалт авчирна гэдэгт итгэлтэй байна. Хоёрт, казах түмэн дэлхийд бүргэдээрээ алдартай. Та бүхэн бүргэд шигээ хүчтэй, бүргэд шигээ эр зоригтой, бүргэд шигээ алсын хараатай хүмүүс. Та бүгдийнхээ бүргэдийн хүчит мэргэн сонголтонд Ардчилсан нам итгэж ирлээ. Гуравт, манай намын энэ удаагийн сонгуульд оролцож байгаа бэлгэдэлийг та бүхэн анзаарсан байх. Монгол Улсын газрын зургаар морь унан давхиж байгаа хүнийг дүрсэлсэн бөгөөд энэхүү шинэ цагийг авчрах хурдан хүлгийн толгой хэсэг Баян-Өлгий аймгийн газар нутаг оршиххэсэгт таарч байгаа юм. Бид бүргэдээ гар дээрээ суулгаад тэр хурдан хүлгээрээ ардчилсан ялалтыг авчрах болно” гэсэн байна.

АН-ын дарга Н.Алтанхуяг журмын нөхдийнхөө хамт Монгол Улсын бүх аймгаар явж нэр дэвшигчдийнхээ сурталчилгаанд оролцон, сонгуулийн мөрийн хөтөлбөрийг танилцуулсан билээ.

ТӨГСГӨЛИЙН ОРОНД

Ардчилсан нам засгийн эрхийг барилцсан буюу Засгийн газраас гарсан, эвссэн буюу бутарсан, нэгэн бүрэн эрхийн хугацаа ийн шувтарч, 2012 оны УИХ-ын ээлжит сонгууль болсон юм. Сонгуульд туйлын магадгүй, туйлын тодорхой үр дүн гарсан ба дөрөвхөн жилийн өмнө ардчилсан хүчнээс 27 хүн сонгогдож цөөнх болж байсан бол, 2012 онд ялалт байгуулсан, олонхи болоогүй ч олуулаа болсон билээ. Ялалт байгуулсан гол үндэс нь өөрийн нэр төрөөр, улс төрийн амжилт ба ирээдүйгээрээ дэнчин тавьж хамтарсан Засгийн газарт орсон намын удирдлага, нам дотроо хийгээд улс эх оронд эв нэгдэл авчирч, эх нутгийн баялгийг эдийн засгийн эргэлтэнд оруулах үндсийг тавьсанд, бие хүн болоод эх орны хөгжлийн бодлогыг тодорхойлсонд орших юм. Түүх хэрхэн үргэлжилснийг дараагийн дэвтрээс үзмүү.



ҮГИЙН ТОВЧЛОЛ

АН	Ардчилсан нам
АТГ	Авилгатай тэмцэх газар
БНН	Бүгд Найрамдах нам
ГЗ	Гүйцэтгэх зөвлөл
ЕНБД	Ерөнхий нарийн бичгийн дарга
ЗГ	Засгийн газар
ЗСБНХОУ	Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Орос Улс
ЗТБХБ	Зам тээвэр, барилга хот байгуулалт
ИБМУТ	Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв
ИЗН	Иргэний Зориг нам
ИЗНН	Иргэний Зориг-Ногоон нам
ИХ	Их хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МАН	Монгол Ардын нам
МАХН	Монгол Ардын Хувьсгалт нам
МНН	Монголын Ногоон нам
МСДН	Монголын Социал Демократ нам
МУ	Монгол Улс
МУНН	Монголын Уламжлалын Нэгдсэн нам
МУОНТВ	Монголын Үндэсний Олон Нийтийн телевиз
МоАХ	Монголын Ардчилсан холбоо
НБД	Нарийн бичгийн дарга
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ОХУ	Оросын Холбооны Улс
Ө	“Өнөөдөр” сонин
ӨС	“Өдрийн сонин”
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо
ТББ	Төрийн бус байгууллага

ТТ	Таван толгой
ТНБД	Төрийн нарийн бичгийн дарга
УМБГ	Улсын мөрдөн байцаах газар
УИХ	Улсын их хурал
УЕП	Улсын ерөнхий прокурор
ҮЗХ	Үндэсний зөвлөлдөх хороо
ХЗБХ	Хууль зүйн байнгын хороо
ХЗДХ	Хууль зүй, дотоод хэрэг
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар



